Detection and investigation: Needs of people who give and receive bribes are met already therefore those types of crimes are hard to detect. Thus these crimes tend to be hidden.²⁹ Moreover these crimes are highly organized, misconducts and illegal income are attentively covered by offender using their powers and positions therefore there is a need of intelligence activities to detect and collect proof of evidence.

Investigations department of National independent agency of Anticorruption investigate corruption crimes. Investigation and Court hearings practice showed there was great improvement in detection and court hearing of abuse of powers and state positions.³⁰

In 2015 around 2 billion tugrug out of 46 billion tugrug damage of corruption crimes was recovered on the stage of investigation, 11 billion tugrug asset and property were collected from offenders and 800 million tugrug hidden asset and property were detected.³¹ But this number is decreased compared to the previous year. (Graph 3)

Lately perpetrators of economic and corruption crimes tend to escape abroad during the investigation procedure and transfer illegal income into foreign banks in offshore regions. Thus we need to cooperate and share information with foreign law enforcement agencies in rendition of fugitive offenders and asset recovery.

Court hearings: Court makes final decision. There is high risk to have influence on court independency while corruption and white-collar crimes are on trial by giving bribes, offering materials and service, putting pressure using relatives and close friends, threatening to send message publicly about sore and personal subjects of judge, soiling and defaming them, making intentional disturbance to court hearing, showing disrespect and making unreasonable complains.³² In accordance with some

²⁹ USAID, The Asia Foundation, National Legal Institute. Corruption, Official Position and Crime. UB., 2014, p 53.


³⁰ Bayarsaikhan D. Phd., Report on Criminal Investigation Procedure and Human Rights, Criminal Law, Outstanding issues of criminal procedure law. Law School, Public Law Institute, National University of Mongolia. UB., 2015, p 8.

³¹ 2015 Work Report of the Investigative Division under IAAC. <http://www.iaac.mn/content/761#.VqxdQ9rlrIU>

³² USAID, The Asia Foundation, National Legal Institute. Corruption, Official Position and Crime. UB., 2014, p 140.

Status target groups training 2015

- Ministries, agencies and departments
- City, district
- Province, sub-provincial unit
- State-owned enterprise
- Non-governmental organizations and citizens
- Students and pupils
- Parliament appointed organizations
- Others



statistics, for last 9 years 150 crimes involving 458 offenders were solved by court. Several people who were holding political higher positions were involved in corruption crimes. For example: former president of Mongolia Enkhbayar Nambar was charged with abuse of state powers and fraud causing high amount of damages to the people and punished with 7 year incarceration according to 150.3 provision, and 25 million tugrug assets were collected, to be away from public service position for 3 years and 3 year incarceration according to 263.2 provision of Criminal law respectively. In 2015 former counselor to Prime Minister Gansukh.L is charged with abuse of state powers and framing, distributing and organizing crime which causes great amount of money to government and is punished to be away from political positions for 4 years and 4 months incarceration.³³ Even though this is explained as opposition political force’s intentional action court hearing was based on enough evidence and proof.

Graphic 3.

Conclusion, proposal

Any country being on the transition period is in need of reform in legal framework and organizational structure to combat corruption.³⁴ Legal framework and appropriate organizational structure have been already well-established and measures/activities against corruption have been conducted with high efforts in Mongolia. For example:

Mongolia adheres to international conventions and domestic laws on anti-corruption, in reflection of them a number of rules and regulations have been developed and reviews and assessments are made on their implementation.

Mongolia prevents corruption and improves public awareness of corruption in a way of

ensuring state and public service accountability and transparency, monitoring asset and income declaration of state officials, maintaining state officials’ high ethics, organizing trainings, publicizing laws, improving public awareness of negative impacts of corruption and conducting education activities.

Investigation and intelligence departments of National independent agency of Anticorruption investigate corruption crimes and much more improvement has been shown in investigation procedure furthermore legal and judicial institutes become more experienced.

Crime detection improvement is asserted by lowering level of Corruption perception index and increasing number of registered crimes.

Brave steps were made in a way of investigating political leaders who abuse their powers and charging them with legal punishments.

Legal framework should become more comprehensive and well-implemented, review and monitoring constantly should be made on state institutes activities and state officials’ conducts, and high ethics and responsibility of people and business entity should be maintained upgrade.

There is a need to increase public awareness of corruption and it negative impacts and take wide range of actions on creating good norms and behaviors among society.

Corruption is always prevented from becoming norm in society by constantly presuming corruption is getting more complicated and organized.


Corruption crime coincides with money laundering and other economic crimes thus investigation approach and tactics should become comprehensive.

Corruption is considered as a base form of transnational organized crimes and therefore there is need to learn and introduce international good practices and intensify international cooperation on it.

Generally justice and fairness are always

³³ <http://shine.shuukh.mn/eruanhan/1179/view>

³⁴ Poup. J. Handbook against Corruption. Transparency International NGO. UB., 2003. p 54.



good start of everything. Higher and middle ranking officials of public service, business sector and civilians all should keep fairness and justice as fundamental principle.

Finally anti-corruption relies on political will. Political party and institutes in power should stop corruption-based "game" and try hard to make great and honest effort to build up healthy society and go for it.³⁵

References

One. International Conventions and Regulations:

1. UN Convention against Transnational organized crime, 2000
2. UN Convention against Corruption, 2003

Two. State Laws and Regulations of Mongolia:

1. The Constitution of Mongolia, UB., 1992. Official State Announcement #1
2. Law on prevention against crime. 1997. Official State Announcement #1
3. Criminal Code of Mongolia, UB., 2002. Official State Announcement #5
4. Criminal Procedure Law, UB., 2002. Official State Announcement #5
5. Anti - Corruption Law. UB., 2006. Official State Announcement #35
6. Information Transparency and Right to Information Law. UB., 2011. Official State Announcement #26
7. Law on the regulation of public and private interests and prevention of conflict of interest in public service, UB., 2012. Official State Announcement #08
8. State Financial Transparency Law. UB., 2014. Official State Announcement #26

Three. Legal Acts:

1. National Program on Combating Corruption, State Parliament of Mongolia, 2002, 41st Resolution, Attachment.
2. Comprehensive National Development Strategy of Mongolia, based upon the Millennium

um Challenge. State Parliament of Mongolia, 2008, 12st Resolution, Attachment.

3. National Security Policy of Mongolia, State Parliament of Mongolia, 2010, 48st Resolution, Attachment.

4. Registration and storage regulation of state employee forms on conflict of interest, income report, State Parliament Legal Committee, 25th April, 2012. 05th Resolution, Attachment.

5. Regulation on collecting Government information providence service charges, freeing and discounting from them. Government of Mongolia, 2013, 54th Resolution, Attachment.

6. Regulation on conduct of state officials authorized to register and store State employee's personal income report and conflict of interest forms. Head of the Independent Authority against Corruption, 11th October, 2012, Order 196, Attachment 1.

7. Regulation on informing and announcement about State employee's personal income report and Conflict of Interest Form. Head of the Independent Authority against Corruption, 11th October, 2012, Order 196, Attachment 2.

Four. Books, Publications and Reports:

1. Hayek F. Law, Legislation and Liberty. Vol II, London, 1973
2. Poup J (G), Handbook against Corruption. Transparency International NGO. UB., 2003.
3. Suzan Rose Ackerman, Corruption and Government. NEPKO Publishing, UB., 2007.
4. Zvemberel-Ikham D. Criminal act of Corruption. Handbook. UB., 2007.
5. Lvndendorj N. "JURISPRUDENCE", The Study of Law, Philosophical Theory. UB., 2011.
6. USAID, The Asia Foundation, National Legal Institute. Corruption, Official Position and Crime. UB., 2014.
7. Independent Authority against Corruption, Social Development and Women's Right Movement, USAID, The Asia Foundation. The Introduction of the Anti-Corruption Law. Handbook. UB., 2015.

³⁵ Zvemberel-Ikham D. Criminal act of Corruption. Handbook. UB., 2007. p 25.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Мөнхдорж

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, магистр, цагдаагийн ахмад

Хүн гэртээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид, эрүүл саруул, аюулгүй орчинд эрх тэгш амьдрах эрхтэй байдаг. Гэтэл гадны нөлөөллийн улмаас эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээ авч буй шалтгаануудад гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмтэл орж байна.¹ 2010-2014 оны байдлаар улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 2782 гэмт хэрэг бүртгэгджээ. Жилд дунджаар 545, сард 45, өдөрт 1-2 хэрэг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж байна гэсэн үг юм. Энэ бол зөвхөн эмнэлэгт хандан, тусламж үйлчилгээ авч бүртгэгдсэн иргэдийн тоо юм. Гэтэл гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнд “нүднээс далд”, байнга давтагдах шинжтэй үйлдэгддэг бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь тэр бүр цагдаа, хууль, шүүхийн байгууллагад хандаад байдаггүй. Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон талаар статистик тоон мэдээ хангалттай байдаггүй. Гэр бүлийн хүчирхийлэл, дарамтнаас үүдэн хүүхэд эрүүл мэндээрээ хохирох, орон гэрээсээ дайжих,

¹ Гэр бүл, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн өнөөгийн байдал, бууруулах арга зам сэдэвт салбар дундын зөвлөлдөх уулзалтын тайлан, Улаанбаатар хот, 2008 он

улмаар гэмт хэргийн замд хөтлөгдөн орж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт өсөн нэмэгдэх хандлага байна. Тоон үзүүлэлт, нийгмийн хандлага, бодит нөхцөл байдлаас үзэхэд эдийн засгийн хямралт байдал, хүн амын амжиргааны бодит түвшин, хэрэглээ,



нийгмийн соёл, хүмүүсийн ёс суртахууны төлөвшил зэрэг хүчин зүйлсээс үүдэлтэйгээр хүчирхийлэл үйлдэгдсээр байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 75.5 хувийг хөнгөн, 14.8 хувийг хүндэвтэр, 6.5 хувийг хүнд, 3.2 хувийг онц, хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба тэдгээрийн 62.0 хувь нь нийслэл хотод, 38.0 хувь нь аймгуудад тус тус бүртгэгджээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийг *Эрүүгийн хуулийн зүйл ангиар авч үзвэл*, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 90.4, танхайрах 3.0, хүчиндэх 2.7, хүнийг санаатай алах 2.1, бусдыг амиа хорлоход хүргэх 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 45.3 хувь нь согтуугаар үйлдэгдэж, 6.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 0.7 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон нийт хүүхдийн 22.3 хувийг 7 хүртэлх насны хүүхэд, 73.4 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн гэсэн хэлбэртэй² байхаар заасан байдаг боловч бие махбодийн хүчирхийллээс бусад хэлбэрийг тогтоон шалгахад хүндрэлтэй байдаг.

Гэтэл гэр бүлийн хүрээнд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөх явдал хамгийн өндөр буюу 42.6 хувьтай байх бөгөөд “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2004 он, 6.1 дэх заалт



өөс хийсэн судалгаанаас үзвэл гэр бүлийн хүрээнд хүчингийн гэмт хэрэгт өртөгсдийн 60 орчим хувь нь бага, өсвөр насны охид байх бөгөөд хохирогч жирэмсэн болох, БЗХӨ-өөр өвдөх, гэрээсээ дайжих, амь нас нь хохирсон зэрэг ноцтой үр дагаварт хүрсэн үед л илэрдэг байна.

Мөн эцэг, эхчүүд хүүхдийг алдаа гаргаж, буруу зүйл хийсний төлөө зодож шийтгэдэг, үүний улмаас эрүүл мэнд, амь насанд аюул занал тулгараагүй л бол мэдээлэгддэггүй, бүртгэгддэггүй, далд нууц байсаар байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийг эрхэлсэн тодорхой ажилгүй, согтууруулах ундаа хэрэглэдэг хүмүүс үйлдэхээс гадна өндөр боловсролтой, төр, хувийн хэвшлийн албан тушаалтнууд багагүй үйлдэж, хүчирхийлэгчийн хэв, маяг халхавчлагдаж буй байдал ажиглагдаж байгааг анхаарах нь зүйтэй.

2012 оноос эхэлсэн хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд УИХ-ын 2013 оны 7 дугаар сарын 5-нд Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэгдэж батлагдан 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль УИХ-аар 2014 оны 01 дүгээр сарын 16-нд батлагдаж, тус тус дагаж мөрдөгдөж байна. Шинэ хуулиар цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй байхаар хуульчлагдсан ба цагдаагийн байгууллага бол гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс үүдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлэгч үндсэн байгууллага юм.

Ийм учраас цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудлыг хөндөж, одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа сайжруулах, батлагдсан болон хүлээгдэж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд бэлтгэл хангах чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорилгоо.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)-д заасан хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979), энэхүү конвенцийн нэмэлт протокол (1999), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989),

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2000), түүнчлэн Хүний эрхийн талаарх 1993 оны Венийн, Хүн ам ба хөгжлийн асуудлаарх 1994 оны Кайрын, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжингийн бага хурлуудын шийдвэрүүдэд тусгагдсан гэр бүлийн гишүүн бүр аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг хангахад чиглэгдэхээс гадна үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй”, 16 дугаар зүйлд иргэн”...аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”, “Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн заасан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс суурь юм.

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуультай байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” хэмээн дотоод аюулгүй байдлыг томъёолж оруулсан. Мөн архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа орсон байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бодлого давхар хэрэгжих учиртай.

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “гэр бүлийн хүчирхийлэл” гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар



заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг” хэмээн томьёолсон.

Уг хуульд цагдаагийн байгууллагатай хамааралтай тодорхой заалтууд байна. Тухайлбал, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага³ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэхээр тусгасан байдаг.

Мөн цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар⁴ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах, энэ хуульд заасны дагуу хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх, хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах, шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх, шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх, хохирогчийг энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах үүрэг хүлээхээр заажээ.

Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль

тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” хэмээн заасан байсан бол УИХ-аар 2015 оны 12 дугаар сарын 5-нд батлагдсан “Зөрчлийн тухай хууль”-ийн 7.12 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих бол хариуцлага тооцохоор тусгасан байна.

Гэр бүлийн гишүүд хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангаж, гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгах зорилгоор Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 12-ны 225 дугаар тогтоолоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийг 2007-2015 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Тухайлбал, хөтөлбөрийн 8.1.4-д заасан “цагдаагийн байгууллагын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг бий болгох асуудлыг судлах”, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁵-ийн тавдугаар бүлэгт “цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах”-аар заасан нь Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяанд байгуулсан байна.

Мөн хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох механизмыг бий болгон хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг цуглуулж сан бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан.

Түүнчлэн, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай маягт, бүртгэлийг эрх бүхий байгууллагаас баталж, мөрдүүлэх заалт туссан нь өнөөдөр гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан, маягт, мэдээний үзүүлэлтэд энэ талаарх мэдээлэл 2009 оноос эхэлсэн, одоогийн байдлаар гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийн тоон үзүүлэлт нэгтгэгдэн гарч байгаа нь сайшаалтай.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр нь хоорондоо харилцан уялдаа бүхий хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх гэсэн тэргүүлэх

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-д

⁴ Мөн хуулийн 9 дүгээр зүйл.

⁵ Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан.



чиглэлийн хүрээнд зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга хэмжээг томъёолж, хэрэгжүүлжээ. Энэхүү хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ цагдаагийн байгууллагын хамаарах асуудлууд нийтлэг байгаа бөгөөд хэрэгжүүлэх үндсэн субъект байхаар тусгасан нь Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, захиргааны хяналтын чиг үүрэгт хамаарч байгаа юм.

УИХ-ын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д “Гэр бүлийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах эрхзүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг заасан үндэслэлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж байна. Хуулийг шинэчлэх гол хэрэгцээ, шаардлагыг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, хөтөлбөр, эрхийн актууд гарган хэрэгжүүлсэн нааштай үр дүн харагдаж байгаа боловч хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болж, цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй болон захиргааны зөрчилд тооцогдон арга хэмжээ авагдсан хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн тоо үүнээс даруй 5 дахин их байгааг энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын судалгаа харуулж байна⁶.

Энэ хуулийн зохицуулалт оновчтой бус, ялангуяа байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий, салангид байдлаар тусгаж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааг орхигдуулсантай холбоотой юм. Тухайлбал, шүүхээс хүчирхийлэл үйлдэгчийг тусдаа амьдрах шийдвэр гаргадаг, энэ нь эдийн засгийн хувьд хэрэгжих боломж хомс, хамгаалах байрны хүрэлцээ муу, зарим орон нутагт хамгаалах байр байдаггүй, улмаар хүчирхийлэгч шүүхийн шийдвэрийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй гэх мэт анхаарах асуудлууд байсаар байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар гэр бүлийн хүчирхийллийн ноцтой хэлбэрийг гэмт хэрэгт тооцдог ч дийлэнх нь зөрчилд тооцон Захиргааны хариуцлагын тухай хуулийн танхайрах, согтуурахтай холбоотой зүйлд заасны дагуу эрүүлжүүлэх, 15,000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 30⁶ ХЭҮТ-ийн судалгаа. 2010 он.

хүртэл хоног баривчлах арга хэмжээ авч, хохирогчийг давхар хохироож байна.

Харин хохирогч хүсвэл хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлуулах арга хэмжээг авахуулах хүсэлтийг шүүхэд иргэний журмаар гарган шийдвэрлүүлэх боломжийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан ч энэ нь гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хохирогчийн үүрэг болгож, эрсдэлд оруулахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахад хүргэж байна.

Хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэр бүлийн тухай зэрэг хуульд хуульчилсан хэдий ч ямар тохиолдолд хүлээлгэх үндэслэл тодорхойгүй, давхардсан, өөрөөр хэлбэл нэг үйлдэл, эс үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг өөр өөр байдлаар тодорхойлсон нь гэм буруутай этгээдэд ял завших, хуулийн хариуцлагаас зайлсхийх боломж олгож байна.

Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан ба энэхүү хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаатай уялдаж байгаа юм. Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэх төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн төсөлд “Цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг” талаар тусгайлан бүлэг оруулжээ. Энэ бүлэгт цагдаагийн байгууллагын албан хаагч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл, дуудлага хүлээн авсан даруй Цагдаагийн албаны тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан арга хэмжээ авах болон дуудлага, мэдээлэл хүлээн авах, шалгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүч хэрэглэх, хохирогчид учрах аюулын зэргийг үнэлж, хамгаалалтад авах, хохирогчийн эрхийг хангах арга хэмжээнүүд авахаар тусгасан байна.



ДҮГНЭЛТ

1. Цагдаагийн байгууллагад ирдэг нийт дуудлага, мэдээллийн 50 гаруй хувийг гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэлтэй холбоотой дуудлага эзлэх бөгөөд энэхүү гомдол, мэдээллийн **70 орчим хувь нь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр шийдвэрлэгддэг** байна. Энэ нь хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс гомдол, саналгүй гэсэн хүсэлттэй холбоотой бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг арилсан эсэхэд хяналт тавих боломжгүй байдал нь энэ төрлийн хэргийн гаралтыг бууруулахгүй, хүчирхийлэл дахин давтан үйлдэгдэх, хүчирхийлэгч ял завшсанаар хууль зүйн хариуцлага гарцаагүй байх зарчим хэрэгжихгүй байна.

ЭБШХ-ийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэж заасан бол мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн 25.1-д заасан хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагаас, эсхүл бусад шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй ба энэ тохиолдолд хэргийг шүүхэд шилжүүлж, шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан тул гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хэргийг хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхгүй байх шаардлагатай байна.

2. 2010-2014 оны байдлаар улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 2782 гэмт хэрэг бүртгэгджээ. Жилд дунджаар 545, сард 45, өдөрт 1-2 гэмт хэрэг үйлдэгдэж байна. 2015 оны эхний 11 сарын байдлаар **1229 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 365 хэргээр буюу 42.2 хувиар өсчээ.**

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд цагдаагийн байгууллагад хандахаас ичих, хүчирхийлэл үйлдэгчээс айсныулмаасзохихбайгууллагадмэдэгдэлгүй орхих, тэвчиж өнгөрөөх тохиолдол түгээмэл байгаа бөгөөд хүчирхийллийн эсрэг төвийн хийсэн судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн таван хүн тутмын нэг нь цагдаагийн байгууллагад ханддаг нь гэр бүлийн хүчирхийллийг

нуугдмал байдалд оруулсаар байна. Хохирогч ямагт хүчирхийллийн эрхшээлд, хараат байдалд байдаг. Энэ нь улам нуугдмал байдалд оруулдаг. Хохирогч нь үр хүүхдээ бодох, айх, ичих, гэр бүлийн дотоод асуудал хэмээн нэр төрөө бодох, цагдаагийн байгууллагын эерэг бус хандлагаас болоод эвлэрдэг, эцэстээ бурууг өөрөөсөө хайж эхэлдэг байна.

Гэр бүлийн хүчирхийлэл далд даамжирдаг учраас хүчирхийлэгч аливаа маргааныг хүч хэрэглэн шийдвэрлэх хэв маяг, дадал зуршилтай болсон байдаг. Хувь хүний ухамсар, зан төлөв хүчтэй нөлөөлж байна.

Нөгөө талаас Монгол Улсын хүн амын бараг 70 орчим хувь нь хотод ажиллаж, амьдарч, сурч байгаа бол хөдөө орон нутагт 30 орчим хувь байна. Тэгвэл гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийн **43 хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдэж, бүртгэгдсэн байна.** Эндээс хөдөө орон нутагт гэр бүлийн хүчирхийллийн түвшин өндөр байгааг харуулж байна. Энэ нь эцгийн эрхт ёс, үндэсний зан заншлын хэм хэмжээнээс гадна хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл, сурталчилгаа, нутаг орны төрийн болон цагдаагийн байгууллагын үйлчилгээ, хүртээмжтэй холбон үзэж болох юм.

Гэр бүлийн хүчирхийллийг Захиргааны зөрчлийн тухай хуулийн 21-р зүйлд зааснаар согтуугаар танхайрах зөрчил гэж ихэнх тохиолдолд шийдвэрлэж ирсэн. Гэр бүлийн хүчирхийлэл нь дамжирсаар амь насыг хохироож, бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах гэмт хэрэг болж, үйлдэгдэж буй нь дээрх тоон үзүүлэлт юм.

12 дугаар сард шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй бие даасан гэмт хэрэг байхаар, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хүндрүүлж үзэхээр тусгаж, Зөрчлийн тухай хуульд “гэр бүлийн хүчирхийллийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” заалтыг тус тус шинээр хуульчилсан юм. Эндээс дүгнэж үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо огцом нэмэгдэж, ялангуяа гэмт хэргийн тоо 10-аас 20 мянга хүртэл нэмэгдэх магадлал өндөр байна.

3. Гэр бүлийн хүчирхийлэлд цагдаагийн байгууллага, алба хаагч болон нийгэм бүхэлдээ дасан зохицож, байж л байдаг хэвийн үзэгдэл мэтээр хандаж байна.



САНАЛ, ЗӨВЛӨМЖ

А. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, бодлогын түвшинд анхаарах асуудал:

1. Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэх хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэх талаарх бүлгийг нэмж батлуулах;

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах нарийвчилсан зохицуулалтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгуулж, батлуулах;

3. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон бусад хууль тогтоомжуудтай уялдуулан **"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"**-ийг Засгийн газрын тогтоолоор батлуулах;

4. Олон жил гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон хохирогчдод, тэдний гэр бүлд төрөөс дэмжлэг үзүүлэх, амьжиргааны хэрэгцээг хангах эх үүсвэр бий болгон өгч байх эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгөх нь зүйтэй.

5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2-д хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэхээр заасан байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийг шалгах процесс нь олон шат дамжлага дамжсаны дараа шүүхээс хүчирхийлэгчийг албадан сургалтад хамруулах шийдвэр гаргаж байна. Иймд практикт учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэгчийг шүүхээс өмнөх шатанд албадан сургалтад хамруулдаг байх зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

Б.Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар санал, зөвлөмж

1. Эрүүгийн болон Зөрчлийн тухай шинээр батлагдсан хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчлийг хянан шийдвэрлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хүлээгдэж буй хууль тогтоомжийг цагдаагийн

байгууллагаас хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангах;

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн төсөл дээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн гүйцэтгэх чиг үүргийг оновчтой тодорхойлж оруулах;

3. Дээрх батлагдсан болон батлагдах хуулийн тогтоомжууд, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан **"Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлогын баримт бичиг"**-ын төслийг урьдчилан боловсруулж, эцэслэн батлуулах;

4. Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль хэрэгжихтэй холбогдуулан гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг, зөрчил болгон, ял, шийтгэл оногдуулдаг болсон, түүний хууль зүйн хариуцлага, үр нөлөөний талаар нийгэмд урьдчилан сэргийлэх мессежийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд сурталчлан таниулах;

5. Гэр бүлийн нуугдмал хүчирхийллийн талаарх мэдээллийг олж авах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хууль сахиулах сүлжээ бий болгох зорилгоор олон нийтэд үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйн төв, вэб сайтыг бие дааж болон бусад байгууллагатай хамтарч ажиллуулах, мэдээллийг үнэлдэг механизм бий болгох, хөршийн холбоог сайжруулах;

6. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах хугацаа урт байна. Ингэснээр хоорондоо эвлэрэх хандлага их байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил огцом нэмэгдэх хандлагатай байгаа тул хурдан хугацаанд шалган шийдвэрлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах хандлагыг өөрчлөх;

7. Цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалгадаг, хэргийн газар дээр очоод ажилладаг аргачилсан заавар (стандарт буюу журмыг) бий болгон мөрдүүлэх, аюулын эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргадаг байх;

8. **"Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс"**-ийг ЦЕГ-ын үндсэн албаны харьяанд байгуулж, улсын хэмжээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

9. Орон нутагт хамгаалах байр байгуулах чармайлт гаргаж байгаа боловч харуул



хамгаалалт, цахилгаан, дулааны төлбөрийг шийдээгүйгээс болоод үйл ажиллагаа нь зогсонги байдалд байна. Нийслэл, орон нутгуудад хохирогчийг хамгаалах байрыг бий болгох, тэдний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулах мөн хамгаалах байрын байршлыг нууцлалтай байхад анхаарах ёстой.

10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод дэмжлэг үзүүлж, хүчирхийлэл үйлдэгдэгчийг согтууруулах ундаа хэрэглүүлэхгүй, амьдралын зөв хандлагад оруулж буй цагдаагийн нэгж, алба хаагчдын үйл ажиллагааг дэмжин, урамшуулах тогтолцоог бий болгон ажиллах;

11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга барил, стандартыг гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээсэн нийт алба хаагчдад хэвшүүлэх, сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

А.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх хууль тогтоомж:

1. Цагдаагийн албаны тухай хууль, 2013;
2. Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл /нэмэлт, өөрчлөлт оруулах/, 2015;
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2004;
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөл, 2015;
5. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль;
6. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
7. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөх;
8. Зөрчлийн тухай хууль, 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөх;
9. Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” ;
10. Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”;
11. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, ХЗДХ-ийн сайдын 2009 оны 128/188 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хохирогчдод аюул учруулах эрдслийн түвшинг үнэлэх аргачлал, маягтын загвар”;
12. УДШ-ийн 2006 оны 47 дугаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоол;

Б.Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл:

13. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, УБ, 2015;
14. Г.Бямбадорж, Хүчирхийлэл, 2014;
15. Д.Саруул, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн шинэтгэл” эрдэм шинжилгээний өгүүлэл, “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл.



**ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ГЭМТ
ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ БУСАД НӨХЦӨЛ
БАЙДЛААС ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЯЛГАГДАХ ОНЦЛОГ**

Б.Хишигтогтох

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Мөрдөх ажиллагааны онол,
тактикийн тэнхимийн ахлах багш,
докторант, цагдаагийн дэд хурандаа

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хууль цаазын мөн чанарыг судлан тодорхойлсноор энэ нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын нэг үндсэн төрөл болох нь тодорхой болж байна. Гэвч уг асуудлыг манай улс Эрүүгийн хуулиар зохицуулж ирээгүй бөгөөд цаашид эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн үүднээс судлан тодорхойлох, төрөлжүүлэн судлах нь зайлшгүй. Гэхдээ энэ нь бие даасан эрдэм шинжилгээ-судалгааны объект болох эсэх нь маргаантай-эргэлзээтэй байгаа боловч тухайн тодорхой хувь хүн-иргэн болон тодорхой ажил-алба, мэргэжлийн ажилтан өөрт нь хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх бодит үйл явдал амьдралд гарсан буюу цаашид ч гарсаар байх болно гэдэг нь нэн ойлгомжтой.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Эрүүгийн хуульд нэгэнтээ тодорхойлон заасан аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, үндэслэл бүхий эрсдэл зэрэг нөхцөл байдлуудтай нэн төсөөтэй шинж, нөхцлүүдтэй тул тэдгээрийг өөр хооронд нь

ялгаж зааглах зайлшгүй шаардлагатай.

М.С Гринберг бичихдээ: «Гэмт хэргийг зүйлчлэх нөхцөл байдлууд нь нийгэм-улс төрийн болон хууль цаазын өвөрмөц онцлогуудтай боловч тэдгээрийг бие биеэс нь салган авч үзэх үнэмлэхүй зааг хязгаарыг тогтооход нэн төвөгтэй байдаг»¹ гэж тэдгээр нөхцөл байдлын эрх зүйн мөн чанар, онцлогийг тун оновчтой тодорхойлсон билээ. Үнэхээр дээр дурдсан нөхцөл байдлууд нь өөр хоорондоо олон шинжээрээ нийтлэг. Түүгээр ч үл барам тэдгээртэй төсөөтэй тухайлбал, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй болон хэрэг хариуцах чадваргүй хүний халдлага-довтолгооноос хамгаалж хийсэн үйл ажиллагааг аргагүй хамгаалалтаас хэрхэн ялгах вэ гэдгийг одоо хэр хууль тогтоомжийн болон мөрдөн байцаах, шүүхийн ажиллагааны түвшинд нэгэн мөр шийдэж чадаагүй байгааг дурдахад хангалттай. Гэвч уг асуудлын талаар эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн судалгааны хүрээнд янз бүрийн үзэл бодол, санал-дүгнэлт байсаар байна. Тухайлбал, зарим судлаачид А.П.Дмитренко² уг үйл ажиллагааг гарцаагүй байдал гэж үзэж байгаа бол И.С.Тишикевич³, Б.Сахаров⁴ нар үүнийг аргагүй хамгаалалт гэж тооцжээ. Үүнээс үзвэл, гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдлуудын төрлүүдийг бие биеэс нь ялгах шалгуур, хэр хэмжээ, бодит үндэслэлүүдийг цаашид гүнзгийрүүлэн судалж, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн үүднээс нарийвчлан тогтоох нь зайлшгүй. Харин бидний судалгааны ажлын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, түүний ялгагдах онцлогийг тодорхойлох явдал гол зорилго болж байна. Иймд энэ асуудлыг өргөн ба тодорхой хүрээнд судлах шаардлагатай. Энэ тухай Г.К.Рахимжанова бичихдээ: «Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь түүнийг хийж буй тухайн хүний бодит үйлдлийн нийгмийн буюу амин (социал) мөн чанарыг ямагт илэрхийлэн харуулдаг бөгөөд тэр нь эрх зүйн харилцааны тодорхой хэлбэрээр заавал дамжин илэрдгийн дээр тэдгээр нь тэрхүү харилцааг зохицуулж байгаа янз бүрийн хууль тогтоомжийн хэм хэмжээтэй зайлшгүй холбогддог бөгөөд нэг

¹ Гринберг, М.С. Проблема производственного риска в уголовном праве /М.С. Гринберг, М.1996, 126 дахь тал

² Дмитренко А.П. Пределы правомерности права на необходимую оборону, Ставрополь, 2000, 47 дахь тал

³ Тишикевич И.С. Условие и пределы необходимой обороны М. 1969., 22-р тал

⁴ Сахаров А.Б. Обязательства, исключяющие уголовную ответственность советское государство и право 1987. №11. 111 дэх тал



үгээр хэлбэл тухайн хүний аж амьдрал тэр ч байтугай эрхлэн хийж буй ажил албатай нь ч холбоотой байдаг. Тодруулбал, уг субьектэд хууль ёсоор олгогдсон эрх үүрэг байдаг ба тэдгээр нь аль ч субьектив эрх зүйн салбартай холбогдож болох талтай тул эцсийн дүндээ өөртөө олгогдсон эрхээ хэрэгжүүлж хууль ёсны эрхээ хамгаалахад хүргэдэг¹» гэснээрээ уг асуудал нь маш өргөн хүрээтэй ойлголт болохыг оновчтой тодорхойлсон байна. Гэвч энэ нь судлаачдын дунд маргаан дагуулсан билээ. Онцолбол, хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжоор тухайн хүнд олгогдсон субьектив эрхтэй, тухайлбал, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт этгээдийг баривчлах, саатуулах ажиллагаатай, тэр ч байтугай үр хүүхдээ асран хүмүүжүүлж буй төрөл төрөгсөд буюу эцэг, эхийнх нь үйл ажиллагаатай ч холбогдож болох юм гэж үзснээрээ «өөрт нь олгогдсон эрхээ хэрэгжүүлж байгаа» төрөл бүрийн үйлдлийг хамааруулж үзэхэд хүргэж байна. Асуудалд хэрэв ингэж хандвал дурдсан нөхцөл байдал буюу үйл ажиллагаанууд нь бүгд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамаарна. Энэ нь уг үйл ажиллагааны бодит мөн чанарыг онцгойлон анхаарч нарийвчлан тодорхойлох ёстой гэдгийг батлан харуулж буй бөгөөд үүнтэй холбогдуулж А.П.Дмитренко бичихдээ: «Гэмт хэргийг үгүйсгэж байгаа нөхцөл байдлуудын бодит мөн чанарыг бүхэлд нь авч үзвэл уг үйлдэл нь Эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хор хохирол учруулж байгаа эрх ёсны (зүй ёсны) үйл ажиллагаа байдаг²» гэжээ. Аливаа юмс үзэгдлийн бодитой нөхцөл байдлуудын мөн чанар нь уг болсон үйл явдлын хамгийн гол шинжийг бүхэлд нь буюу тэр ч байтугай нэгж байдлаар нь ч илэрхийлэн харуулдаг зүй тогтолтой гэдгийг философийн шинжлэх ухааны ерөнхий, тусгай, онцгой категори тодорхойлдог. Тэгвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хамгийн гол мөн чанар нь уг үйлдэл хууль ёсны (эрх ёсны) үйл ажиллагаа байдагт оршино. Энэ шинж нь уг үйл явдлын мөн чанарыг бүхэлд нь буюу нэгж байдлаар ч гэсэн тодорхойлдог. Гэхдээ юмс үзэгдлийн мөн чанарын шинж тэмдэг нь тухайн болсон үйл явдлын хамгийн гол шинжийг ямагт бодитой тусган илэрхийлдэг тул энэ нь гол төлөв асуудлыг иж бүрнээр нь буюу бүхэлд нь авч үзэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, юмс үзэгдлийн мөн чанар гэдэг нь тухайлбал, гэмт хэргийг үгүйсгэж байгаа нөхцөл байдлын хамгийн гол шинж

нь тухайн үйл ажиллагаа нь хууль ёсны байх явдал мөн бөгөөд чухамхүү энэ нь өөр бусад шинж тэмдгээс илүү бодитой байх ёстой. Иймд дээр дурдсаныг нэгтгэн маш товч тодорхойлбол, Монгол Улсад сүүлийн 30 шахам жилд дагаж мөрдөж ирсэн Эрүүгийн хуульд үйл явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын хамгийн гол тодорхойлох шинж нь «Уг болсон үйл ажиллагаа хууль ёсны байх ёстой» гэдгийг ямагт хуульчилж ирсэн бөгөөд энэ нь (уг нөхцөл байдлууд) хэдийгээр нийгмийн болон хууль тогтоомжийн хөгжилтийг даган өөрчлөгдөж ирсэн боловч гол мөн чанар нь бараг өөрчлөгдсөнгүй гэдгийг тодорхой батлан харуулж байна.

Иймд нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд нь өргөн утгаараа бараг бүгд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаатай нэн ялангуяа сэдэлт, үндэслэлээрээ адилхан байж болох талтай боловч хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа нь тэдгээр ерөнхий нөхцөл байдлуудаас арай ялгаатай бөгөөд нэн ялангуяа түүнийг явцуу хүрээнд нь авч үзвэл ялгаа нь нэлээд тодорхой болдог. Нэн ялангуяа хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч бусад нөхцөл байдлаас юуны өмнө нилээд бие даасан шинжтэй үйлдэл байдгаараа онцлог тул түүний нийтлэг болон ялгаатай шинжийг арай тодруулан авч үзье. Тухайлбал, хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт этгээдийг баривчлан саатуулж байгаа үйл ажиллагаатай зарим нийтлэг шинжээрээ төсөөтэй тул тэдгээрийг өөр хооронд нь ялгаж зааглах нь нэг талаараа ээдрээтэй, нөгөө талаараа төвөгтэй байж болох талтай. Эдгээр үйл ажиллагаа нь юуны өмнө бүгд Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр тодорхойлон тогтоосон бодит үндэслэл, хэр хэмжээний дотор болдог буюу болох ёстой. Тодруулбал, цагдаагийн ажилтан гэмт этгээдийн нийгэмд аюултай үйл ажиллагааг өөрөөр хэлбэл, үйлдэж буй гэмт хэргийг нь газар дээр нь таслан зогсоож улмаар түүнийг (гэмт этгээдийг) баривчлан саатуулах, тулгарч буй бодит эсэргүүцэл болон үйлдлийг нь таслан зогсоохын тулд тэр ч байтугай өөрийгөө хамгаалах зайлшгүй шаардлагын улмаас галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх тохиолдол гарч болох бөгөөд энэ нь хэдийгээр цагдаагийн албаны тухай хууль ба уг хуулийн дагуу гарсан тусгай журам, заавараар нарийвчлан тогтоож өгсөн тусгай стандартыг дагаж



мөрдөж буй үйл ажиллагаа байдаг учир тэрхүү үйл ажиллагаа нь мөн чанарын хувьд эрүүгийн хуулийн хэм хэмжээг үндэслэсэн байдгаараа түүнтэй тун төсөөтэй учир ялган зааглахад нэн төвөгтэй байдаг.

Чухам ийм учраас эдгээр нөхцөл байдлын нийтлэг ба ялгаатай шинжийг эрүүгийн хууль тогтоомжийг үндэслэн улмаар эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны жинхэнэ онол-арга зүйн үүднээс нарийвчлан судалж тодорхойлох шаардлагатай юм.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа тодруулбал, хуульд заасан эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь тодорхой хэр хэмжээ, хуульд заасан үндэслэл, нөхцлийн дотор болдогоороо уг үйлдэл нь бусдад хор хохирол учруулсан байсан ч гэсэн тэрнийг нь зөв тодорхойлон тогтоож чадвал тэр нь тухайн эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа болох нь дамжиггүй. Бидний энэ санал-дүгнэлтийг нилээд олон судлаач дэмжиж байгаа буюу дэмжих нь дамжиггүй гэж найдна.

Үүний тулд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хууль цаазын болон (юуны өмнө Эрүүгийн хуулийн) эрх зүйн мөн чанарыг нь онол-практикын арга зүйн үүднээс судлан тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын гол зорилт мөн. Чухамхүү энэ нь ялангуяа Монгол Улсын хувьд харьцангуй анхдагч гэж хэлж болохуйц эрдэм шинжилгээний бүтээл болж буй гэдгийг онцгойлон тэмдэглэхийг хүсч байна.

Үүнтэй холбогдуулан дурдвал цагдаагийн ажилтан өөрт нь хуулиар олгогдсон албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэсэн бодитой тохиолдол Монгол Улсын хувьд амьдрал-практикт төдийлөн элбэг гардаггүй нь онцлогтой боловч ийм тохиолдол болсныг 2007 оны 7 дугаар сарын 1-нд гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед тохиолдсон үйл явдал гэрчилнэ. Гэвч энэ нь тусдаа бие даасан үйл явдал тул бидний судалгааны ажлын гол сэдэв биш юм.

Ихэнх судлаачдын үзэж буйгаар, хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг юуны өмнө холбогдох хууль тогтоомж тэр ч байтугай эрх зүйн тусгай нарийвчилсан дүрэм, журам, заавар¹ зэрэгт түүний эрх зүйн үндэслэлийг заавал урьдчилан тогтоож зааж өгөх ёстой бөгөөд энэ нь гол төлөв эрх зүйн тусгай хэм хэмжээгээр тухайлбал, Цагдаагийн албаны тухай хууль тэр ч байтугай зэвсэгт хүчний харуулын дүрэм зэрэг холбогдох төрөл бүрийн эрх зүйн

актаар зохицуулагддагаараа онцлогтой. Гэвч энэхүү тусгай хэм хэмжээнүүд нь нийгмийн аюулыг үгүйсгэгч үндсэн нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын хэм хэмжээг тайлбарлахад туслах чанарын хэрэгсэл болох бөгөөд харин хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа тодорхой ажиллагаануудыг тодорхойлон тогтооход хууль-эрх зүйн зайлшгүй, бие даасан гол эх сурвалж буюу хууль шаардлагатай учраас хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь харьцангуй бие даасан шинжтэй байдгаараа онцлог гэдгийг дахин тэмдэглэж байна.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг буюу түүнтэй холбоотой тодорхой үйл явдлыг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээг ялган тодорхойлоход нэн ялангуяа аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт хэрэгтнийг баривчлан саатуулж байгаа үйл явдлын зохицуулалтын эх сурвалж болсон хууль-эрх зүйн актыг заавал нарийвчлан зааглах шаардлагатай. Бидний явуулсан судалгаанд хамрагдсдын 90 гаруй хувь нь «галт зэвсэг, тусгай арга хэрэгсэл ашиглах болон тодорхой этгээдийн эсэргүүцлийг таслан зогсооход хүч хэрэглэж байгаа үйл ажиллагааг ямар хууль, эрх зүйн актаар зохицуулах вэ? гэдэг асуултанд хариулахдаа Цагдаагийн албаны тухай хууль гэж тун цөөвтөр буюу 20 хувь нь хариулсан бөгөөд галт зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах төрөлжсөн журам-зааврыг ихэнх нь мэдэхгүй байгаа нь харагдаж буй тул хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг төдийлөн тодорхой мэдэхгүй байгаа нь илт байна. Цаашилбал, хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үүсгэгч бусад нөхцөл байдлуудаас харьцангуй бие даасан шинжтэй болохыг батлан харуулж буй 2 дахь үндэслэл нь гэмт хэргийг үүсгэгч нөхцөл байдал нь бие даасан шалгууртай байх ёстой явдал юм. Гэвч Дээд Шүүхийн тогтоол-тайлбар нь зөвхөн тодорхой тохиолдлыг тайлбарлаж байгаа эрх зүйн тайлбар болохоос бус жинхэнэ хуулийн хүчин чадалтай эрх зүйн акт болж чадахгүй учир хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үүсгэгч бие даасан нөхцөл байдал болохыг зөвхөн хууль тогтоогч шийдвэрлэж чадах тул Монгол Улсын Эрүүгийн хуульд ийм бие даасан тусгай хэм хэмжээг тусган оруулах зайлшгүй шаардлага байна гэж үзэв.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа



үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч бие даасан бусад нөхцөл байдлуудаас ялгагдах шинжүүдийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны арга зүйн үүднээс судалж нарийвчлан тогтооход арга зүйн нэмэр хандив болох үүднээс холбогдох судалгааны зарим чиглэлүүдийг тодорхойлохыг эрмэлзэв. Юуны өмнө хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болохын хувьд уг үйлдлийг хийхийг хүргэсэн бодит үндэслэлийг тал бүрээс нь судлах шаардлагатай байна. Яагаад гэвэл ОХУ-ын эрдэмтэн-судлаачид энэ чиглэлээр нилээд судалгаа-бүтээл туурвиж харилцан адилгүй санал-дүгнэлт гаргаж байгааг товчхон боловч тоймлон авч үзье. Жишээлбэл, зарим судлаачид нь 1993 оны 4 дүгээр сарын 9-нд батлан гаргасан ОХУ-ын Хилийн тухай хуульд заасан эх сурвалжийг үндэслэн хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гарцаагүй байдалд хамааруулан үзэж байна. Учир нь уг хуулийн 9 дүгээр зүйлд заахдаа «ОХУ-ын усан хил болон хуурай замын хилийн гол нуур бусад усан байгууламж хуурай газрын хилийг аргагүй байдлын улмаас зөрчсөн хувь этгээд болон хуурай ба усан замын тээврийн хэрэгсэл зэргийг зөрчсөн нөхцөлд хил зөрчигчдийг саатуулсаны улмаас хохирол учруулсан бодит үйл ажиллагаа нь хэрвээ холбогдох дүрэм, журам, зааварт заасан үндэслэл, хэр хэмжээний дотор болсон байвал уг үйл ажиллагааг болон түүнтэй холбогдож гарсан тодорхой тохиолдолыг хилийн зөрчилд тооцохгүй»⁵ гэж заасан нь түүнийг мөн чанарынх нь хувьд гарцаагүй байдалд тооцох эрх зүйн эх сурвалж-үндэслэлийг буй болгожээ. Түүнчлэн, эрүүгийн эрх зүйн зарим судлаачид: золгүй тохиолдол, осол, байгалийн аюултай үзэгдэл зэрэг онцгой гамшигт байдлын үед аюулд өртсөн багийн гишүүд зорчигчдыг аврах яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх аюулгүй газарт тээвэрлэж хүргэх зэрэг зайлшгүй бодитой шалтгааны улмаас хийсэн үйл ажиллагааг гарцаагүй байдалд тооцох талтай» гэж үздэг. Энэ тухай А.В.Наумов бичихдээ: «Тухайн бодит тохиолдолд бусдад заналхийлж байгаа хор аюулыг зайлуулахдаа өөр ямарч аргыг сонгох боломжгүй нөхцөлд уг бодит аюулыг зайлуулснаар бусдад гэм хор учруулсан байвал түүнийг гарцаагүй байдалд тооцохоос аргагүй юм»⁶ гэжээ.

⁵ Закон Российской Федерации о государственной границе РФ, М, 1993, 11-р тал

⁶ Наумов, А.В. Уголовное право. Общая часть. Курс лекций А.В.Наумов, М, 1996, 349-р тал

Ийнхүү гарцаагүй байдлын үндэслэл нь энэ хуульд тодорхойлсон шинж нөхцлүүдтэй бүрэн нийцэж буй бөгөөд харин «тулгарч байгаа аюулыг тухайн нөхцөлд өөр арга сонгох боломжгүй нөхцөл байдалд хийнэ» гэсэн энэхүү үндэслэл нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд зайлшгүй тогтоовол зохих «хэр хэмжээ үндэслэл» биш байж болох талтай. Яагаад гэвэл тухайн хүнийг тэрхүү тодорхой тохиолдолд уг зайлшгүй ажиллагааг хийхэд хүргэж байгаа биеийн хүчний үйлдэл буюу албадлага нь цагдаагийн ажилтны эсрэг хийж байгаа гэмт этгээдийн халдлага довтолгооноос өөр юм. Учир нь тухайн нөхцөл байдалд нь чухам өөрийн үзэмжээр сонгох боломж нөхцөл байдаггүйгээр үл барам гол төлөв агшин зуурт болж өнгөрдгөөрөө хариу үйлдэл тодруулбал довтолгоо-халдлагыг няцаах аргыг сонгох боломж олгодоггүйгээрээ гарцаагүй байдлаас эрс ялгаатай юм.

Ер нь эрүүгийн эрх зүйн онолд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох өөр нилээд төрлүүдийг хамааруулан авч үздэг. Тухайлбал, А.Г.Кибальник бичихдээ «Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны төрөлд эхнэр, нөхөр, үр хүүхэд, төрөл садныхаа эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах тэр ч байтугай тэдгээрийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс зориуд худал мэдүүлэг өгөх нь бараг хүн болгоны иммунитет буюу дархлаа байдаг тул мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд гарцаагүй хамаарна»⁷ гэсэн нь бидний үзэж буйгаар дэмжүүштэй санал-дүгнэлт юм. Учир нь дэлхийн нилээд улс тухайлбал АНУ, Англи, Герман зэрэг барууны орнуудад «Иммунитетное право» буюу утгачлан орчуулбаас «Дархлааны эрх зүй» нэгэнтээ эрх зүйн бие даасан салбар болон хөгжиж байгаа нь манай Монголын хувьд ч гэсэн анхаарууштай, судалж боловсруулмаар асуудал болж байгааг энэ дашрамд тэмдэглэе. Энэ тухай өмнөх бүлгүүдэд ч гэсэн товч дурдсан билээ.

Нэгэнтээ «дархлааны эрх зүйг» бодит байдалд хүлээн зөвшөөрч нэн ялангуяа Эрүүгийн хуульд түүнтэй холбогдсон зохих өөрчлөлтүүдийг тусган оруулбал уг тохиолдлыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бодит үндэслэлд тооцож болох бөгөөд тэгэхлээр уг үйл ажиллагаа нь

⁷ Кибальник, А.Г. Иммунитеты в уголовном праве / А.Г. Кибальник ; Ставрополь , 1999, 7-8 дахь тал



хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа нөхөх байдалд онцолбол түүний нэг бие даасан төрөлд хамаарах нь гарцаагүй. Тухайлбал, энэ тухай С.Г.Келина бичихдээ: «Нэгэнтээ тухайн хүний хийсэн үйл ажиллагааг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа бол уг этгээдийн хийсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй бөгөөд тийнхүү тооцохгүй байх үндэслэл хэр хэмжээ, шалгуур, бодит нөхцлийг холбогдох хуульд нэн түрүүнд эрүүгийн хуульд урьдчилан заах хэрэгтэй»⁸ гэжээ. Дээр дурьдсан эхнэр, нөхөр болон ойрын төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах бодит эрх нь хууль цаазын мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаагаас үйл ажиллагааны олон төрлийн нэг болж болох талтай боловч харин энэ нь аргагүй хамгаалалт биш юм. Яагаад гэвэл аливаа хүн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх замаар гэмт хэрэг үйлдэж болохгүй нь тодорхой.

Иймд өөртөө байгаа эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа болон түүнтэй холбогдуулж холбогдох хуульд заасан «Дархлаа» нь гагцхүү өргөн агуулгаараа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамаарч болох юм. Ийм учир хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тодорхой тохиолдлуудыг эрүүгийн хуулинд бодитой тусган оруулсан нөхцөлд тэр нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогдох хууль-эрх зүйн үндэслэл болно гэдгийг дахин тэмдэглэе. Энэ бүгдийг үндэслэн дараах санал-дүгнэлт дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэргийг үгүйсгэж байгаа ялангуяа Эрүүгийн хуульд заасан бүх нөхцөл байдлууд нь өргөн утгаараа хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд тооцогдоно.

2. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь бие даасан үндэслэл, шалгуур, хэр хэмжээтэй байх ёстой. Тэгсэнээрээ төсөөтэй бусад нөхцөл байдлаас ялгагдах болно.

3. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг зохицуулдаг хэм хэмжээг Эрүүгийн хуульд зайлшгүй тусган оруулж тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

4. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлан саатуулж байгаа үйл ажиллагаанаас ялгах үндэслэл, шалгуурыг

эрүүгийн эрх зүйн үүднээс нарийвчлан судалж, бодитойгоор тодорхойлон тогтоох.

5. Албан үүргээ гүйцэтгэж байгаа ажилтанд цаашид тухайн этгээдээс гэмт үзүүлж байгаа биеийн хүчний бодит нөлөөлөл нь (халдлага, эсэргүүцэл, довтолгоо гэх мэт) гарцаагүй шинжтэй буюу аргагүй байдалд хүргэсэн байх нөхцөл шалгууруудыг аль болох бодитойгоор тогтоох, холбогдох тухайн журам, зааварт тусгаж улмаар стандарттай болох шаардлагатай байна. Гэвч энэ нь ямагт харьцангуй ойлголт юм гэдгийг анхаарвал зохино.

6. Эхнэр, нөхөр болон ойрын төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх нь хууль цаазын мөн чанарынхаа хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны нэгэн төрөл болж болох талтай болохоос бус эрүүгийн эрх зүйн бие даасан «Дархлаа» биш болно.

Гэвч эдгээр санал-дүгнэлт нь уг асуудлыг онол-практикийн талаас нь шийдвэрлэх төгс шийдэл биш гэдэг нь тодорхой юм.

⁸ Келина С.Г. Теоретические вопросы освобождения от уголовной ответственности / С.Г. Келина .М., 1974,8 дахь тал



БЭЛГИЙН ДУР ХҮСЛЭЭ ЁС БУСААР ХАНГАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Б.Баасанбат

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 2008-2015 онд 97, жилд дундажаар 12 бүртгэгджээ. Иргэд согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэх, бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхих, орчиндоо түгшүүр төрүүлдэг эрсдэл бүхий этгээдүүдэд тавих хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.¹

Монгол Улсын Эрүүгийн хуулийн «Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг» гэсэн 17 дугаар бүлгийн 125 дугаар зүйлд «Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах» гэмт хэргийг хуульчилсан.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нийгмийн хор аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан:

Үндсэн бүрэлдэхүүн /Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ./

Хүндрүүлэх бүрэлдэхүүн

Энэ хэргийг:

-Давтан,

-Бүлэглэж үйлдсэн,

-Уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан,

-Насанд хүрээгүй,

-Бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилан ангилжээ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект:

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шууд объект нь бусдын эрх, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал байна.²

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын тухай

¹ Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төв. "Монгол Улсад 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт". УБ., 2013., 153 дахь тал, "Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал". ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. УБ., 2014, 2015

² С.Жанцан. "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" ерөнхий, тусгай анги. УБ., 2011., 328 дахь тал

асуудлын хүрээнд гэмт хэргийн халдлагын зүйлийн тухай асуудлыг хамааруулан авч үздэг. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тухайд халдлагын зүйл гэдгийг халдлагад өртөгч гэсэн ойлголтоор авч үзэх нь зүйтэй.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн, бие махбодь, сэтгэл санааны хохирол хүлээсэн этгээдийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн халдлагад өртөгч гэж үзэх болно.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект

тал:
Улсын Дээд Шүүхийн 1989 оны 28 дугаартай тогтоолд "Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах нь субъект хохирогчийг хүчиндэх, түүнтэй эр, эмийн ёсоор хурьцах зорилгогүйгээр өөрийн шалиг завхай дур сонирхолдоо хөтлөгдөн бэлгийн уламжлалт харьцааны замаар бус садар самуун байдлаар, хохирогчийн бие, эрхтнийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангах байдлаар илэрнэ" гэж тайлбарласан байдаг. Хүчингүй болсон Эрүүгийн хуулийн хэм хэмжээг тайлбарласан БНМАУ-ын Дээд Шүүхийн дээрх тайлбар одоо хүчин төгөлдөр бус. Иймд 2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн хэм хэмжээг Улсын Дээд Шүүхээс дээрх агуулгаар тайлбарлах шаардлагатай байна. Албан ёсны тайлбар байхгүйн улмаас практикт энэ төрлийн гэмт хэргийг хүчиндэх гэмт хэргээс ялган зүйлчлэхэд бэрхшээл тулгарч байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объект тал нь гэмт этгээд хохирогчид хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулах, түүнийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ хангасан идэвхтэй үйлдлээр илэрнэ.

Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэгт "Субъект хохирогчийг багалзуурдах, зодох, өвтгөх, биед нь гэмтэл учруулах зэргээр түүний эсэргүүцлийг няцааж"³ бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан байхыг ойлгож болно. Мөн сэтгэл зүйн хүч хэрэглэж болно.⁴

Хүч хэрэглэхээр заналхийлж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэгт: хохирогч болон түүний гэр бүл, төрөл садангийн хүн, найз нөхдийн амь насыг

³ С.Жанцан. "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" ерөнхий, тусгай анги. УБ., 2011., 330 дахь тал

⁴ С.Жанцан. "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" тусгай анги. УБ., 2003., 155 дахь тал



хөнөөх, бие махбодид гэмтэл учруулах, эрх, эрх чөлөөг нь хязгаарлах гэх мэтээр заналхийлж, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөн хохирогчийг тохуурхан доромжилж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангахыг ойлгоно.

Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэгт: хохирогч согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэсэн, эсхүл хохирогч сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй, хохирогч бага настайн улмаас гэмт этгээдээс биеэ хамгаалах, түүний үйлдлийг эсэргүүцэх чадваргүй байхад нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан байхыг ойлгоно.

Хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэдэгт хохирогчийн бэлэг эрхтэнд мод, лонх, гар, хуруу, бусад зүйлсийг хийж ёс бус авирлах, бэлгийн уламжлалт харьцааны замаар бус хохирогчийн ам, суга, цавь, гуя, хөхөн завсар дур тавих, хохирогчийн нэр төр, алдар хүндэд халдах зорилгоор гэмт үйлдлээ хэрэгжүүлж буй үйл явцыг бэхжүүлэн видео бичлэг хийх, хохирогчийн биеийн нүцгэн хэсгийн гэрэл зургийг авах, мөн түүнчлэн хохирогчийг гэр бүл, ойрын төрөл садангийн хүмүүсийн нүдэн дээр болон олон нийтийн өмнө түүний хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасныг ойлгож болох юм.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчлахдаа түүний үндсэн бүрэлдэхүүнд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчилсан. Гэхдээ хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх үйлдэл хийгдсэнээр /хувцасыг урах, татах, чирэх гэх мэт/ гэмт хэрэг төгссөн гэж үзэхгүй. Хууль тогтоогч уг гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан байхаар хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан тул материаллаг бүрэлдэхүүнтэй.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах үйлдэл нь дараах аргуудаар объектив талын шинжүүдийг үүсгэнэ.

1. Хүч хэрэглэх,
2. Хүч хэрэглэхээр заналхийлэх,
3. Бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах,
4. Хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах аргуудаар илэрнэ.

Энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд давтан үйлдлийн шинжийг зааж өгсөн байна. Уг гэмт хэргийг давтан үйлдсэн бол

5-аас дээш 10 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

2015 оны Эрүүгийн хуульд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах үйлдлийг хүчиндэх гэмт хэргийн диспозицид заасан. Харин бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив талыг хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэж шинээр томъёолсон.

Гэмт хэргийн объектив талын нэмэгдэл шинж болох цаг хугацааг 2015 оны Эрүүгийн хуулийн диспозицид зааж өгсөн учраас объектив талын үндсэн шинжийн агуулгыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэрэг болно.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект:

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол улсын иргэн, харьяалалгүй иргэн, гадаад улсын иргэн байна.

Уг гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэй, ижил хүйстэн хэн ч байж болно.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал:

Гэмт этгээд хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн дур хүслээ хангахад чиглэсэн үйлдэл хийж буйгаа ухамсарлаж, түүнээс үүдэн гарах хор уршгийг мэдсэн, мэдэх бололцоотой байтал, түүнийг хүсэж гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлддэг.

Ёс бус /гаж буруу/ аргуудыг санаатай сонгон авсан байдаг.⁵

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг нь өс хонзонгийн болон хувийн бусад сэдэлтээр үйлдэж болно.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн:

⁵ С.Жанцан. "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" ерөнхий, тусгай анги. УБ., 2011., 328 дахь тал



Энэ гэмт хэргийг

- Давтан үйлдсэн,
- Бүлэглэж үйлдсэн,
- Уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан,

- Насанд хүрээгүй,

- Бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хүндрүүлэн хуульчилсан байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах **гэмт хэргийг давтан үйлдсэн гэдэгт**: Хоёр ба түүнээс дээш удаа бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн байхыг ойлгоно.

Давтан үйлдэх гэдэг нь ял шийтгэлтэй ба ял шийтгэлгүй давтан гэсэн хоёр ойлголтоос бүрддэг.

Ял шийтгэлтэй давтан гэдэг нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл эдэлж байхдаа буюу ял шийтгэл эдлээд ял шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй байхад тус гэмт хэргийг үйлдсэн байхыг ойлгодог.

Ял шийтгэлгүй давтан гэдэг нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдээд ял шийтгэгдээгүй байхдаа дахин гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно. Гэмт хэргүүдийн хооронд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрөөгүй байх шаардлагатай.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг бүлэглэж үйлдэх нь субъектүүд гэмт хэргийн объектив талыг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож, хамтран оролцогч бүр хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан байх ёстой.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн улмаас **бусад хүнд хор уршиг учирсан гэдэгт** хохирогч хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өвчтэй болсон, үр тогтоох, тээж төрүүлэх чадваргүй болсон, амиа хорлосон, хүүхдээ дутуу төрүүлсэн, үр хөндүүлэхэд хүргэсэн байхыг ойлгоно.

Насанд хүрээгүй хүний хүсэл зоригийн эсрэг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэдэгт **хохирогч 18 насанд хүрээгүй байхыг ойлгоно**. Гэмт этгээд хохирогчийн насанд хүрээгүй гэдгийг мэдсэн, мэдэх боломжтой байсан байх шаардлагатай.

Бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан **гэдэгт хохирогч 14 насанд хүрээгүй байхыг ойлгоно**. Гэм буруутай этгээд **хохирогчийг 14 насанд хүрээгүй**

бага насны хүүхэд гэдгийг мэдсэн, ухамсарласан байх ёстой.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 125 дугаар зүйл/, Хүчиндэх гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл/ ялган зүйлчлэх нь:

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах болон хүчиндэх гэмт хэргүүд нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт хуульчлагдсан.

Практикт хуулийн байгууллагын ажилтнуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг хүчиндэх гэмт хэргээс ялган зүйлчлэхэд ихээхэн эргэлзээ төрдөг байна. Эдгээр гэмт хэргүүдийн ялгааг дараах байдлаар тайлбарлаж болно.

А. Шууд объектоороо ялгаатай

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шууд объект нь бусдын эрх, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал⁶ байдаг бол хүчиндэх гэмт хэргийн шууд объект нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал байдаг.

Б. Объектив талын шинжээрээ ялгаатай

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив тал нь бусдын хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах, хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан идэвхтэй үйлдэл байдаг бол хүчиндэх гэмт хэргийн объектив тал нь хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн идэвхтэй үйлдэл байдаг.

Насанд хүрээгүй болон бага насны хүүхдийн биеэ хамгаалж чадахгүй буюу уг үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүйг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангахдаа /хохирогчийн цавь, гуяны завсар болон аманд хийж/ заавал хүч хэрэглэсэн, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулсан, тохуурхан даажигнасан бол энэ гэмт хэрэг болно.⁷

В. Субъектээрээ ялгаатай.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдаг бол хүчиндэх гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдаг.

⁶ С.Жанцан. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/, УБ., 2011., 329 дэх тал

⁷ С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/, УБ., 2011., 328 дахь тал



**ТЕРРОРИЗМЫН ГЭМТ ХЭРГИЙН
ТАЛААР ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН
БАЙР СУУРЬ, ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

Н.Мөнхбат

СБД-ийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн
эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

Товч агуулга: Эрүүгийн хуульд терроризмын гэмт хэргийн талаарх нэр томъёог зөв, оновчтой томъёолох талаар санал-зөвлөмж боловсруулсан.

1980-аад оны сүүлчээр Европ тивийг хамарч байсан глобалчлал буюу даяаршлын үйл явц дэлхий ертөнцийг бүхэлд нь хамарч, шинжлэх ухаан, техникийн хөгжилд гарсан дэвшлийг дагаад асар хурдацтай явагдаж байна.

Нийгмийн аливаа үзэгдэл нь эерэг, сөрөг хоёр талтай байдаг. Даяаршлын үйл явц нь эерэг, сөрөг үр дагавартай. Даяаршил нь үндэстэн хоорондын болон эдийн засгийн тогтолцоо, хүмүүс хоорондын, дэлхий нийтийн чөлөөт харилцааны шинэ хэлбэр болохын хувьд экспорт, импорт нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх, банкны зээл олголт хувь нэмэгдэх, валютын эргэлт өсөх, мэдээлэл технологийн тархалт эрчимжих, цахим сүлжээ хурдацтай хөгжих зэрэг эерэг үр дагавруудыг бий болгож байна.

Өнөөдөр Монгол цэрэг энхийг сахиулах хүчинд зүтгэж Ирак, Афганистан, Өмнөд Судан, Сериалион зэрэг улсад терроризмын эсрэг халуун цэгт үүрэг гүйцэтгэж, дотооддоо аливаа аюул, заналхийллийн эсрэг, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг

сахиж, хамгаалахад Батлан хамгаалах яам, цагдаа, тагнуул, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газруудын тусгай албад байнгын бэлтгэл, сургуулалт хийж байгаа нь сайшаалтай боловч байгууллага, хувь хүмүүс, малчин ард ч террорист үйл ажиллагааны талаар ойлголтод хүрч чадаагүй байна.

Даяаршлын сөрөг үр дагавар нь хар тамхи, мансууруулах бодис, хүн наймаалагчдыг олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хөгжлийн төвшин буурай орнуудын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг алдагдуулах гэх зэрэг нөхцөл байдлыг бий болгож байна. Олон улсын терроризм нь шинэ бүс нутаг, улс гүрэн, үндэстэн дамнасан иж бүрэн цогцолбор сүлжээгээ аль хэдийнээ бий болгож, улмаар 21 дүгээр зууны тахал болтлоо дэлгэрэх магадлалтай байна.

Олон улсын терроризмын мөн чанарыг судалдаг шинжээчид 21 дүгээр зууны эхэн жилүүдэд дунджаар 1500-2000 удаа террорист халдлага гарах магадлалтай бөгөөд шашны терроризмын оргил үе нь 2029-2030 онд болно гэж таамаглаж байна. Даяаршлын үйл явцын улмаас терроризмын аюул занал ч улс, үндэстэн дамнан хэсүүчлэх боллоо.¹ Тухайлбал, террорист байгууллагууд нь хамтран ажиллаж нэг нэгнийгээ идэвхтэй дэмжин үйл ажиллагаагаа нягт уялдуулан явуулах болсон. Манай орны хувьд терроризмын гэмт хэрэг нь өнөөгийн байдалд харьцангуй байна. Гэвч, манай орон терроризмын гэмт хэргээс ангид энэ гэмт хэрэг гарах магадлал бага хэмээн тайвширч болохгүй бөгөөд тус гэмт хэргээс урьчилан сэргийлэх, эрүүгийн хуулиндаа гэмт хэргийн нэр томъёог зөв, оновчтой томъёолох зэрэг асуудлуудыг анхаарахгүй орхиж болохгүй.

Терроризмын гэмт хэргийн талаар авч үзэхийн өмнө түүний үүслийн талаар авч үзэх нь зүйтэй юм. "Терор" нэр томъёо нь "terror" буюу аймшиг, айдас гэсэн латин үгнээс гаралтай ажээ. Төрийн болон улс төрийн зүтгэлтнүүд, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, жирийн иргэдэд халдах, үйлдвэрийн газар, тээвэр, холбооны барилга, байгууламжуудыг эвдэн сүйтгэх, устгах болон ижил төстэй бусад ийм халдлага янз бүрийн зорилгыг агуулах боловч үйл

¹ Бидний үзэж байгаагаар, терроризмын гэмт хэрэг өнөөдөр дэлхий дахинд тулгамдсан гол асуудлуудын нэг мөн бөгөөд энэхүү судалгааны ажилд бид Монгол улсын эрүүгийн хуулийн 178¹.1, 178¹.2 дугаар зүйл ангийн бүрэлдэхүүний асуудлаар судалгааны ажлаа хягаарлан авч үзэх болно.



ажиллагааных нь шинж чанар айдаст автуулах, тийм сэтгэгдэл төрүүлэх үзэгдэл бий болсон тохиолдолд л терроризмын тухай ярьж болно гэж ОХУ-ын эрдэмтэн, судлаач Ю.М. Атонов тэмдэглэсэн байдаг.

Террорист гэмт хэргийн үүсэл нь эртний Ромын үед Zealots of Judea гэсэн бүлгээс үүсэлтэй. Энэ нь Ромын эзэрхийллийн эсрэг чиглэгдсэн гэмт хэргийн үйл ажиллагаа байсан. Үүний дараагаар Ислам шашинтай Низари гэсэн нэртэй хөлсний алуурчдын бүлэг гарч ирсэн. Тэдний гол тактик нь өөрсдийн нэг хүнээ илгээн дайсныхаа толгойлогчийг устгахаар явуулж, амиа золиосолдог байсан байна. Энэ нь орчин үеийн терроризмын шинж чанарын эхлэл болсон байна. Орчин үеийн бүлгүүдийн бүтэц нь энэхүү хоёр бүлэглэлийн бүтэцтэй төстэй юм.

1795 оноос хойш Францын хувьсгалын үед “террорист” ба “терроризм” гэдэг үгийг хэрэглэж, дарангуйлагч бүлгүүдийг «Террорист» гэж нэрлэдэг байв.

ОХУ-ын эрдэмтэн Марина Латашева өөрийн номондоо “Терроризм нь боолын нийгэмд ч байсан.”² Жишээ нь, Александр Македоны эцэг Филипп Македон алан хядагчдын гарт амь үрэгдсэн, хамгийн эртний алан хядах бүлгийн нэг бол Сикариевийн бүлэг бөгөөд эртний Иудын газар нутаг дээр манай эриний 66-73 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан тус бүлэг нь Римийн улс төрийн зүтгэлтнүүд болон Римд талтай Еврейчүүдийг алан хядахаас гадна хотын үр тарианы агуулах шатаах, ус түгээх системийг эвдэлж, нураах зэрэг ажиллагаа явуулж байжээ” гэж дурдсан байдаг.

Терроризмын талаарх НҮБ-ын 18 конвенц байдаг ба Монгол Улс 13-т нь нэгдэж орсон бөгөөд 2004 онд Терроризмтой тэмцэх тухай хууль, 2007 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталсан. Энэ хуульд заасны дагуу терроризмтой тэмцэх 15 байгууллагын төлөөлөл бүхий зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

Терроризмын гэмт хэргийн талаар ерөнхий ойлголт өгөх үүднээс зарим нэг гадаад болон дотоодын эрдэмтэн, судлаачдын олон улсын хэмжээнд зохиогдсон хурал, зөвлөгөөний үеэр өгсөн тодорхойлолт, терроризмтой тэмцэх, нилээд туршлагатай тооцогдох АНУ, ОХУ-ын эрдэмтэн, судлаачид хэрхэн тодорхойлсныг авч үзье. Энэ гэмт хэргийг тайлбарлах талаар дэлхийн нэртэй судлаач, шинжээчид, эрдэмтэд, улс төрчдийн тодорхойлолт хоорондоо нилээд ялгаатай

² Марина Латашева “Терроризм” М., 2000, 156стр

ба ОХУ, АНУ, ХБНГУ зэрэг улсын нэртэй эрдэмтдийн сүүлийн жилүүдэд бүтээсэн ном зохиолуудыг шинжилж, дүгнэснээр 100-150 гаруй ойлголт байна.

Бид энэ асуудлыг авч үзэхийн өмнө терроризм буюу терроризмын гэмт хэрэгтэй байнга холбогдон хэрэглэгдэх террорист, террорист байгууллага, террорист ажиллагаа гэх зэрэг ойлголтуудын талаар тайлбар өгөх шаардлагатай юм.

Монгол Улсын терроризмтой тэмцэх тухай хуульд **“Терроризм”** гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг хэлнэ.³

“Террорист ажиллагаа”

1.Террорист үйлдэл хийх, түүнд оролцох зорилгоор террорист бүлэг байгуулах.

2.Террорист үйлдлийг бэлтгэх, зохион байгуулах.

3.Террорист үйлдэл бүрэн буюу хэсэгчлэн ашиглуулах зорилгоор өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа эд хөрөнгө, мөнгийг террорист байгууллага болон түүнийг дэмжигч хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар, санаатайгаар өгөх, хуримтлуулах.

4.Терроризмын зорилгоор мэдээллийн цахим сүлжээнд халдах.

5.Терроризмын зорилгоор иргэнийг элсүүлэх, зэвсэглэх, сургах.

6.Террорист үйлдэл байгууллага, иргэнийг өдөөн хатгах, албадах, эсхүл өдөөн хатгах, албадахыг оролдох.

7.Терроризмыг үзэл санааг дэлгэрүүлэхийг...хуулинд гэж заасан байна.

Олон улсын жишээгээр:

“Террорист” гэж улс төрийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэгч этгээдийг хэлнэ.⁴

“Террорист бүлэг, байгууллага” гэж дээрх зорилгоор нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй хууль бус бүлэг, байгууллага юм.

“Террорист ажиллагаа” гэж террорист шинж чанар бүхий гэмт хэрэг үйлдэх зорилготой дараах үйл ажиллагааг хэлнэ. Үүнд:

³ “Монгол Улсын терроризмтой тэмцэх тухай хууль” 2004.

⁴ Terrorist: Longman “Dictionary of Contemporary English” London, 2002, 171 тал



- 1.Террорист үзэл санааг дэлгэрүүлэх
- 2.Террорист акци зохион байгуулах, төлөөлөх, бэлтгэх, үйлдэх.
- 3.Террорист акци үйлдэх өдөөн хатгах, террорист зорилгоор хүчирхийлэл үйлдэх явдалд уриалах.
- 4.Террорист акци үйлдэх зорилгоор зэвсэгт бүлэг, гэмт хэргийн бүлэг байгуулах, тэдгээрт оролцох.
- 5.Террорист ажиллагаа санхүүжүүлэх.
- 6.Террорист акцид бэлтгэхэд туслах,⁵ зэрэг болно.

“Террорист акци” гэж террорист зорилгоо бусад гэмт хэрэг үйлдэх замаар чиглэсэн цогц ажиллагаа юм.

Зарим эрдэмтэн, судлаачид терроризм буюу террор үйлдэх гэмт хэргийг террористуудын зүгээс үйлдсэн бүх л гэмт хэрэг хэмээн ойлгоно гэж үзэх тохиолдол байдаг. Бидний үзэж байгаагаар энэ нь боломжгүй бөгөөд террорист бүлэг, байгууллагын гишүүдийн зүгээс үйлдсэн гэмт хэргийг уг ойлголтод хамааруулан авч үзвэл Эрүүгийн эрх зүйн тусгай зарчим болох эрүүгийн хариуцлага, ялыг ялгамжтай хэрэглэх зарчим алдагдаж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн шударга ёс, хууль ёс ноцтойгоор зөрчигдөхөд хүрнэ. Өөрөөр хэлбэл, терроризмын гэмт хэргийн хүрээг дээрх байдлаар хэт өргөжүүлэн авч үзсэнээр үр гэмт хэргийг бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчилж, хариуцлага хүлээлгэх боломжийг алдагдуулна гэсэн үг юм.

Бидний үзэж байгаагаар, дээрх байдлаас гарах хамгийн зөв зүйтэй арга зам бол террористуудын зүгээс улс төрийн зорилгоор нийгэмд аюултай аливаа үйлдэл, эс үйлдэл хийсэн тохиолдолд эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангид нэмэлт өөрчлөлт оруулж, хариуцлагыг хүндрүүлэн хүлээлгэж байх явдал бөгөөд терроризмын гэмт хэрэг нь нийгэм, эрх зүйн үзэгдэл гэдгийг анхааралдаа авах ёстой.

Өмнөх хэсэгт дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт өгөх гэсэн оролдлого анх 1937 оны Үндэстнүүдийн лигийн чуулганы үеэр хийгдэж байсан тухай дурдаж байсан. Уг тодорхойлолтод “Аливаа улс үндэстний эрх ашгийн эсрэг хандсан болон алан хядах зорилготой ямар нэг үйл ажиллагаа явуулахаар зээх буюу санаархсан хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн явуулж буй бүх эрүүгийн үйлдлүүдийг хэлнэ.”⁶ гэж

⁵ БНКУ-ын “Терроризмтой тэмцэх тухай хууль” 1999 он, 1-р зүйл

⁶ Батлан хамгаалахын Олон улсын эрх зүйн судалгааны хүрээлэн “ Олон улсын гэмт хэрэг”, УБ, 2003 он, 1-р тал

дурдсан байдаг. Энэхүү тодорхойлолт нь өнөөгийн дэлхийн хөгжлийн өндөрлөгөөс авч үзэхэд учир дутагдалтай хэдий ч терроризмтой тэмцэх ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулсан тодорхой юм.

Харин НҮБ-аас зохион явуулсан бага хурлын үеэр өгсөн тодорхойлолт нь оновчтой болж чадсан гэж судлаачид үздэг байна. Уг хурлын үеэр олон орны төлөөлөгчид “Терроризмыг хаана ч, хэн ч үйлдсэн бай тэр этгээдийн үйлдэл эрүүгийн гэмт хэргийн чанартай бөгөөд бүх талаар буруушаах нь зүйтэй” гэж цохон тэмдэглээд уг гэмт хэргийг “Олон түмний дотор террорист үйлдэл явуулахаар санаархсан хэсэг бүлэг болон хувь хүмүүсийн улс төрийн зорилгоор явуулж буй энэ үйлдэл нь ямар ч нөхцөл байдалд явуулсан гэсэн эдийн засаг, философи, үзэл суртал, шашин шүтлэг болон бусад ямарч зорилгоор үйлдсэн байсан байж болзошгүй явдал юм.”⁷ Мөн АНУ-н хуульд /Title 22 of the United states Code, section 2656f/ “Терроризм гэдэг улс төрийн сэдлээр зориуд зохион байгуулагдсан гэмгүй номхон ард иргэд болон чухал алба хашдаг эрх мэдэл бүхий хүмүүсийн эсрэг голдуу ард түмэнд нөлөөлөх зорилгоор явуулж буй ажиллагаа”⁸ гэж тодорхойлсон байдаг бол ОХУ-ын терроризмтой тэмцэх тухай хуулинд “Хувь хүн болон байгууллагын эсрэг хүчирхийлэл хэрэглэх буюу хүчирхийлэл хэрэглэхээр заналхийлэх, эд хөрөнгө болон бусад материаллаг объектыг сүйтгэх нь хүмүүсийн амь насанд халтай аюулыг учруулах, олон нийтийн аюулгүй байдлыг зөрчих хүн амыг айлган сүрдүүлэх эсхүл террористуудад ашигтай шийдвэрийг төр, засгийн байгууллагуудаас гаргуулах буюу хууль бус эд хөрөнгийн болон бусад ашиг сонирхлыг хангах зорилгоор үлэмж их хэмжээний хохирол учруулах, нийгэмд аюултай үр дагаврыг бий болгох, төр болон улс төрийн зорилгоор явуулж буй үл ажиллагааг зогсоох, өш хонзонгоор төрийн зүтгэлтний амь биед халдах, олон улсын харилцааг хурцатгах болон дайн өдөөх зорилгоор олон улсын хамгаалалтанд байдаг этгээдүүдийн тээврийн хэрэгсэл болон албан тасалгаанд халдахыг”⁹ хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Мөн ОХУ-ын Эрүүгийн хуульд “Хүмүүсийг үхлийн аюултай байдалд хүргэх, эд хөрөнгийн их хэмжээний хохирол учруулах

⁷ Мөн тэнд

⁸ Department of State, “Partners of Global Terrorism”, 2008, 16-р тал

⁹ ОХУ-н “Терроризмтой тэмцэх тухай” холбооны хууль, 1998 он, 3-р зүйл



болон нийгэмд аюултай бусад үр дагаварт хүргэхээр тэсэлж дэлбэлэх, галдан шатаах, бусад үйлдлийг нийгмийн аюулгүй байдлыг зөрчих, хүн амыг айлган сүрдүүлэх, эрх барих байгууллагын шийдвэрт нөлөөлөх зорилгоор үйлдсэн бол...”¹⁰ Оросын нэрт эрдэмтэн Л.А Моджорян терроризм нь улс төрийн ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд улс гүрний дэг журмыг алдагдуулах, улс төрийн зарим зүтгэлтнийг зайлуулахад чиглэгдсэн бүлэг хүмүүс, байгууллага, Засгийн газрын байгууллагуудын хүчирхийлэл юм гэж тодорхойлсон байна.¹¹

Үүний зэрэгцээгээр терроризмыг түүний шинж чанар, онцлогоор задлан шинжилж үнэлэх явдал юм. Жишээ нь, АНУ-ын Ерөнхийлөгч асан Ж.Буш терроризмтой тэмцэх байгууллага хоорондын комиссын илтгэлдээ “Терроризм нь улс төр, нийгмийн тодорхой зорилгодоо хүрэхийн тулд иргэд болон объектын эсрэг хүчирхийллийг хууль бусаар үйлдэх, айлган сүрдүүлэх, хүчирхийлэл үйлдэхэд чиглэгддэг...”¹² гэж тодорхойлжээ. Терроризмын гэмт хэргийн тухай өргөн хэмжээний тодорхойлолтыг Америкийн судлаач В.Милсон, С.Милсон нар өгсөн байдаг. Тэдний тодорхойлсноор терроризм нь “Нийтийн юм уу эсхүл нийгмийн зорилгод хүрэхийн тулд харгисаар хүчирхийлэх, заналхийлэх үйлдлийг ашигладаг явдал юм”. Терроризмын гэмт хэргийн тухай дээр дурдсан зөрүүтэй тодорхойлолтуудыг нэг мөр нийтээр хүлээн зөвшөөрүүлэх тал дээр НҮБ-ын зүгээс сүүлийн жилүүдэд нилээд хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Манай улсын хувьд 2001 оноос хойш уг гэмт хэргийн талаар тодорхойлолт гаргаж, бүтээл туурвиж, энэ чиглэлээр холбогдох хурал, зөвлөгөөнийг зохион байгуулж байсан нь манай орны нөхцөлд уг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эхний алхам болж чадсан юм. Академич С.Нарангэрэл “... манай улс терроризмыг алан хядах ажиллагаа, зандачлах, зэрэг нэр томьёоны оноолт хийсэн нь оновчтой болж чадаагүй бөгөөд аллага бол терроризмын гэмт хэргийн зөвхөн илрэл учраас алан хядах ажиллагаа гэсэн нэр томьёо нь оновчтой бус” гэж дүгнэсэн байдаг. Монгол нэр томьёоны оноолт нь оновчтой бус, терроризмын жинхэнэ утга санааг илэрхийлж чадахгүй байгаа учраас

¹⁰ ОХУ-н эрүүгийн хууль М., 1999 он, 205-р зүйл

¹¹ Ч.Баатар “Терроризм, аюулгүй байдал” 2006 он, 6-р тал

¹² Терроризмын эсрэг олон улсын бага хурлын материал, 2005 он

терроризмын гэмт хэргийг олон улсад нэгэнт хэвшсэн нэр томьёогоор хэрэглэх нь зүйтэй байна.”¹³ гэж өөрийн илтгэлдээ дурдсан байдаг. Олон улсын практикт ямар нэг урьд байгаагүй шинэ үзэгдэл, бүтээгдэхүүн тухайн улсад бий болсон, өөр улсаас нэвтэрч орж ирсэн тохиолдолд өөрийнх нь нэр томьёог хэрэглэж ирсэн тийм биш тохиолдолд тухайн зүйлийн агуулгыг бүрэн илэрхийлж үл чадах оновчгүй нэр томьёо ашиглах тохиолдол их гардаг.

Одоо зарим эрдэмтэн, судлаачид терроризмын гэмт хэргийг хэрхэн тодорхойлсон талаар авч үзье. Бостоны Олон улсын харилцааны их сургуулийн доктор, профессор Вожтек Мазни “Терроризм гэдэг нь хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар ард иргэдийн дунд айдас хүйдэс төрүүлэх явдал. Террористууд эсрэг шашин бүхий нийгмийн бүлэг, засгийн газар, улс төрийн нам, корпорац, хэвлэл мэдээллийн байгууллагыг халдлагын бай болгодог. Тэдгээрт террорист байгууллагууд нь халдлагын бай болгож буй ард түмэн, байгууллагатай нь харьцуулбал хүн хүчин, материаллаг эх сурвалжийн хувьд өчүүхэн жижиг байдаг. Тэд хүчирхийлэл үйлдэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр заналхийлэх замаар улс төрийн бодлогод нөлөөлөхийг зорьдог.”¹⁴ гэж тодорхойлсон байдаг бол доктор Сарфараз Ниазиги “Терроризм бол улс төрийн зорилгоор үйлдэж буй хүчирхийлэл. Тухайлбал, аллага, хүн барьцаалах, онгоц барьцаалах, бөмбөгдөх гэх мэт үйлдлүүдийг хэлнэ”¹⁵ гэж тодорхойлсон байдаг. Харин ОХУ-ын эрдэмтэн Евгений Кожушка терроризм гэдэг нь “Хүмүүсийн аль нэг аюулгүй байдалд заналхийлэхүйц алах, хорлон сүйтгэх, эмх замбараагүй байдал үүсгэх, дээрэм тонуул хийх, зэрлэг балмадаар танхайрах зэрэг хэлбэрээр илрэх үзэл сурталжсан системд хүчирхийллийн аргаар явуулах улс төрийн тэмцлийн тактик юм. Ийм хүчирхийлэл нь улс төр, шашин, нийгэм-эдийн засгийн тодорхой ашиг сонирхлын үүднээс өөрийн дайсныг замаасаа зайлуулах, төр, нам, нийгэм-улс төрийн ба шашны хөдөлгөөн, үндэс угсаатны бүлэг, нийгмийн давхаргыг айлган сүрдүүлэх зорилгоор үйлдэгдэж болно.”¹⁶ гэж тодорхойлсон байна.

Манай орны судлаач Ц.Дашзэвэг,

¹³ ТЕГДС “Мэдээлэл” /Ил дугаар/, №1, УБ., 2003 он, 13-р тал

¹⁴ Terrorism. Microsoft, Encarta, Encyclopedia 2007.

¹⁵ Батлан Хамгаалах Олон Улсын Эрх зүйн Судалгааны Хүрээлэн “Олон улсын Гэмт Хэрэг”, УБ, 2003 он, 2-р тал

¹⁶ Евгений Кокушка “Современный терроризм” М., 2002 г, стр 4



Д.Шагнаадорж нарын “Олон улсын терроризм түүнээс сэргийлэх зарим асуудал” гэсэн номонд терроризмын зорилго нь улс төр, нийгмийн байгууллын тогтолцоог өөрчлөх, төрийн байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх гэсэн үндсэндээ улс төрийн агуулгатай байна. Гэхдээ шашны болон үзэл суртлын агуулгатай зорилго бүхий эсгэл зүйн дайралт гэж терроризмыг үзэж болно.¹⁷

“Терроризмын эсрэг Монголын холбоо”-ны ерөнхийлөгч Ч.Баатар 2002 оны 12 сард зохион байгуулагдсан “Терроризмын эсрэг” олон улсын бага хуралд тавьсан илтгэлдээ “Терроризм гэдэг нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, улс төрийн арга хэлбэр юм”. Терроризм-нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах, олон улсын хэмжээний онц чухал объектууд, АЦС, цөмийн болон хими, бактериологийн зэвсгийн үйлдвэрүүдийг эзлэх, халдахыг завдах ард түмнийг айлган сүрдүүлэх, алан хядах бүлэглэлүүдийн эрх ашгийг хангахуйц шийдвэрийг удирдлагын зүгээс гаргуулах зорилгоор бие хүн болон байгууллагын эсрэг хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгө, бусад материаллаг зүйлсийг гэмтээх, устгах, улс орны дотор улс төр, эдийн засгийн онцгой байдлыг бий болгох улмаар улс хоорондын харилцааг хүндрүүлэх, дайн үүсгэх эх үүсвэрийг бий болгох, үндэстэн ястнуудыг хагаран бутаргах үйл ажиллагааг санаатайгаар зохион байгуулах үйл ажиллагаа юм.¹⁸ гэж дурдсан байдаг. Энэ мэтээр олон эрдэмтэн, судлаачид терроризмыг тодорхойлсон байгаа хэдий ч дээрх тодорхойлолтуудаас харахад, уг гэмт хэрэг нь улс төрийн зорилгоор үйлдэгддэг хүчирхийлэл болох нь харагдаж байна. Өөрөө хэлбэл, терроризмыг бусад гэмт хэргээс ялгаж буй гол онцлог, дахин давтагдахгүй шинжүүдийн талаар нэг бүрчлэн авч үзэх шаардлагатай.

Статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ:

Зөвхөн 2015 оны байдлаар дэлхийн 85 оронд 6771 удаа террорист ажиллагаа үйлдэгджээ. Террористууд 11 мянга гаруй хүний амь насыг бүрэлгэж, 21,6 мянга гаруй хүн шархдаж, 1280 гаруй хүн хулгайлагдсан байна. 2015 оны олон улсын терроризмын

тухай АНУ-ын Төрийн департаментын илтгэлд дурджээ. Дэлхийд сар бүр дунджаар 564 удаа террорист ажиллагаа (халдлага) үйлдэж, үүний улмаас 925 хүн амь насаа алдаж, 1804 хүн шархдаж байна. Гол нь Ирак, Африкийн Нигери улсад хүчирхийлэл гаарсантай холбоотойгоор өнгөрсөн оны нэгдүгээр сард хамгийн их цус асгарсан байна. (1378 хүн амь насаа алдсан байна). Өнгөрсөн жил Афганистаны “Талибан” хөдөлгөөн хамгийн олон буюу 525 удаа террорист ажиллагаа үйлджээ.¹⁹

Манай улсад терроризмын шинжтэй 20 орчим гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Гэхдээ хор уршгийн хувьд нийгмийг цочроох хэмжээнд хүрээгүй. Хамгийн сүүлд 2013 оны 9 дүгээр сарын 16-нд Төрийн ордон руу байлдааны зэвсэг, гар бөмбөг оруулах гэж оролдсон асуудал байна. Төрийн тусгай хамгаалалттай газрын хашаанд буудсан асуудал өөрөө мөн л терроризмын гэмт хэргийн зүйл заалтад багтаж байгаа учраас энэ хуулийн дагуу хэрэг үүсгэн шалгаж байсан. Мөн одоогоос арваад жилийн өмнө багагүй шуугиан тарьсан “Адмирал” баарны дэлбэрэлтийг дурдаж болох юм. Энэ хэрэгт уул, уурхайн зориулалттай тэсрэх бодисыг баарны цахилгаанаас холбон тэсэлсэн асуудал бий. Гэхдээ энэ хэргийг бол санамсар болгоомжгүйгээр үйлдсэн гэж үздэг. Түүнчлэн Сэлэнгэ аймгийн Баруун-хараа суманд хувийн өс хонзонгийн сэдлээр хүний машиныг дэлбэлсэн асуудал гарсан. 2000 оны эхээр хүний бэлгэнд өгсөн хайрцаг машин дотор дэлбэрч, тухайн үед байсан хүмүүс хүнд бэртсэн. Цаашлаад “Чингис хаан” олон улсын нисэх буудлаас тэсрэх бөмбөг олдсон асуудлуудыг дурдаж болно. Гэхдээ бид цаашид заавал АНУ-ын хоёр өндрийг дэлбэлсэн асуудал шиг зүйл хүлээх албагүй. Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаагаа сайжруулах ажлыг зохион байгуулж байх нь зүйтэй.

Дүгнэлт

Монгол Улс даяаршин буй дэлхий ертөнцийн нэг гишүүн орон болохын хувьд терроризмын гэмт хэрэг болон түүнтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгдэхгүй гэсэн баталгаа байхгүй байна. Иймд терроризмын гэмт хэрэгтэй тэмцэх онол-практикийн асуудлуудыг сайтар судалж үзэх шаардлагатай байна. Энэ талаар УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга асан Ц.Шаравдорж “Терроризмын эсрэг” онол-практикийн бага хурал дээр тавьсан илтгэлийнхээ үеэр ... бид терроризмын гэмт

¹⁹ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

¹⁷ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн “Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал” УБ, 2004

¹⁸ Терроризмын эсрэг Монголын холбоо “ Терроризмын эсрэг”, УБ, 2005 он, 12-р тал



хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэхдээ үндэсний хууль тогтоомжийн шинэчлэлд анхаарах ёстой. Тухайлбал, терроризмын ойлголтыг тодорхой болгож хуульчлах, үндэсний хууль тогтоомжийг олон улсыг жишиг стандартад хүргэх, олон улсын гэрээ конвенцийн заалтуудтай нийцүүлэх шаардлагатай байна.²⁰ гэж хэлсэн нь оновчтой байна.

Манай орны хувьд терроризмын гэмт хэргээс ангид энэхүү гэмт хэрэг гарах магадлал бага хэмээн тайширч болохгүй бөгөөд тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хуулиндаа тус гэмт хэргийн талаарх нэр томъёог зөв, оновчтой томъёолох зэрэг асуудлуудыг эргэж харах нь зүйтэй юм.

Тагнуул, цагдаагийн байгууллагын албан хаагчдын мэргэшил, тусгай бэлтгэлийн түвшин өнөөгийн шаардлагад нийцүүлэн дэвшлүүлэх шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна.

1. Терроризмын гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор боловсруулан, батлан гаргасан олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээр, эвсэлд нэгдэн орох замаар үйл ажиллагаагаа бусад улсуудтай нэгтгэх;

2. Энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 178¹ дүгээр зүйлд “Терроризм” гэж хуульчилсныг өөрчлөн “Терроризмын гэмт хэрэг” гэж томъёолох. Учир нь террор буюу терроризм нь нийгмийн нэг үзэгдэл юм. Жишээ нь, хууль тогтоогчдын тодорхойлсноор “Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэхээр заналхийлсэн, энэхүү үйлдлээрээ гоц халдварт өвчин, гал түймэр болон гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх” үзэгдлийг хэлж байгаа бөгөөд шууд террор үйлдэх эсхүл терроризм гэж томъёолох нь учир дутагдалтай юм.

3. Терроризм үйлдэх гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан гэж хууль тогтоогч заасан байна. Гэвч гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд хууль бус зэвсэгт

²⁰ Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв “Терроризмын эсрэг” УБ, 2003 он, 19-р тал

бүлэглэл үйлдсэн гэж тодорхойлсон мөртлөө хүндрүүлэх нөхцөлд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гэж заасан нь ямар тохиолдолд үндсэн бүрэлдэхүүнээр шийдвэрлэх, ямар тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх талаар маргаан гаргаж болзошгүй байна. Тиймээс үндсэн бүрэлдэхүүнд байгаа хууль бус зэвсэгт бүлэглэлт гэдгийг гэж өөрчлөх нь зүйтэй.

4. Мөн хууль тогтоогчийн зүгээс энэхүү гэмт хэргийг үйлдэх, санхүүжүүлэх, сурталчлах гэж тусгаж өгсөн нь хууль зүйн хувьд хязгаарлагдмал байна.

5. Мөн тус зүйл ангид цахим хэлбэрээр терроризмын гэмт хэрэг үйлдэх талаар хуульчилж өгөөгүй байгаа нь нэг дутагдал юм.

6. Манай улсын терроризмын гэмт хэрэг болон түүнтэй холбоотой бусад гэмт хэрэгтэй тэмцэх тагнуул, цагдаагийн байгууллагын албан хаагчдын мэдлэг, тусгай бэлтгэлийн төвшин өнөөгийн шаардлагыг хангахгүй байна.²¹ Тиймээс радио идэвхт болон хими, биологийн хорт бодис ашиглаж мөн цахим хэлбэрээр терроризмын гэмт хэрэг үйлдэхийн эсрэг мэргэшсэн ажилтан бэлтгэх шаардлагатай байна.

7. Хил, гааль, цагдаа, тагнуулын байгууллагаас гадаадын иргэд, Монгол Улсад нэвтрэх, зорчих, оршин суух үйл ажиллагаа, тэдний бичиг баримтад тавих хяналтыг сайжруулж, терроризмын гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход онцгой анхаарах.

8. Терроризмын гэмт хэргийн санхүүгийн гол эх үүсвэр болсон хууль бус галт зэвсгийн наймаа, хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах зэрэг гэмт хэргүүдтэй хийх тэмцлийг улам эрчимжүүлэх.

9. Терроризмын гэмт хэрэг гарсан үед хүчний байгууллагуудын хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах.

Ном зүй

Хууль эрх зүйн акт

- Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002
- Монгол Улсын Эрүүгийн хууль / шинэчилсэн найруулга/. 2015
- Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002
- Үндэстний аюулгүй байдлын тухай хууль. 2003

²¹ Хавсарлт-1, судалгааны үр дүнг харна уу.



- Терроризмтай тэмцэх тухай хууль. 2004

Ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

- Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжлгээний, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв “Терроризмын эсрэг” УБ 2003
- Б.Шагдар “Орчин үеийн алан хядар ажиллагаа, үндсэн чигллийн судалгаа” УБ 2002
- ТЕГДС “Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хуулиудын эмхтгэл” УБ 2002
- Ц.Дашзэвэг, Д. Чагнаадорж “Олон Улсын Терроризм ба Монгол Улс” Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан онол практикийн бага хурлын материалын эмхтгэл УБ 2003
- Ц.Дашзэвэг, Д. Чагнаадорж “Олон Улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал” УБ 2004
- Доктор, профессор Д.Зүмбэрэлхам “Терроризм түүнтэй тэмцэх эрх зүйн асуудал” УБ 2003
- Д.Адъяабазар “Мафи” УБ 1998
- Ч.Баатар “Терроризм, аюулгүй байдал” УБ 2006
- С.Пүрэв ОУ-н терроризмоос сэргийлэх болзошгүй хохиролыг аргилгах арга зам 2014

Гадаад орны хууль тогтоомж, ном зохиол

- СВ Дьяков “Государственные преступления и Государственная преступность” 1999
- Уголовное право РФ 1999
- Федеральный закон “О Борьбе с терроризмом” 1999
- Закон Республики Казакстан “О борьбе с терроризмом” 1999
- Евгений Кожушка “Современный терроризм” 2001
- Department of state “Patterns of global terrorism” Washington D.C 2001
- Magazine of department of the state / USA/
- Longman “Dictionary of Contemporary English” London 2002



ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЦАГДААГИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ю.Бадамханд

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа

Товч утга: Энэхүү ниитлэлд гадаадын зарим орны цагдаагийн мэргэжлийн боловсролын тогтолцоог судлан, өөрийн орны онцлогт тохируулан сургалтыг хэрхэн зохион байгуулах асуудлыг авч үзсэн.

Дэлхийн улс орон оршин тогтнож хөгжих явцдаа улс орны дотоод дэг журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг төрийнхөө нэг чухал үүрэг болгож иржээ. Энэ үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэж ирсэн бөгөөд түүхийн тодорхой үед улс орон бүр цагдаагийн мэргэжлийн боловсролын тогтолцоог өөрийн онцлог, уламжлал, хөгжлийн түвшинтэй уялдуулан бий болгожээ. Цагдаагийн мэргэжлийн боловсролын агуулга, хэлбэр ялгаатай ч улс орон бүр “Шилдэг мэргэжилтнийг бэлтгэхэд мэргэжлийн боловсролыг хэрхэн зохион байгуулах, ямар хэлбэрээр олгох вэ?” гэсэн асуудалд анхаарал хандуулсаар ирсэн.

Баруун Европт цагдаагийн хүний нөөцийн туршлагаараа Герман тэргүүлдэг.

Германы холбооны 16 улс бүрийн цагдаагийн байгууллага цагдаагийн албан хаагчдыг бэлтгэдэг сургалтын тогтолцоотой. Цагдаагийн байгууллага нь 350.000 албан хаагчтай, тэдний 80 хувийг нь цагдаагийн

дунд сургууль төгссөн дипломтой бага бүрэлдэхүүн, 19 хувийг цагдаагийн дээд боловсролтой дунд шатны албан хаагчид, 1 хувийг (3.5 мянга) ахлах офицерууд бүрдүүлэх ба Цагдаагийн удирдлагын академи төгссөн тохиолдолд уг албан тушаалд томилогддог байна.¹

Цагдаагийн мэргэжлийн боловсролыг дараах сургалтын байгууллагад бэлтгэдэг.

1.Муж улсын цагдаагийн сургууль (ерөнхий, тусгай курс-дунд боловсрол)

2.Цагдаагийн дээд сургууль (цагдаагийн дээд /тусгай/ боловсрол)

3.ХБНГУ-ын Цагдаагийн удирдлагын академи.

ХБНГУ-ын цагдаагийн хүний нөөцийн бэлтгэл нь магадлан итгэмжлэгдсэн 3 түвшний сургуулиар зохион байгуулагддаг.

Нэгдүгээр түвшин- ерөнхий, тусгай, төгсөх гэсэн цогцолбор хичээлийг агуулсан анхан шатны бэлтгэл хамаарах ба муж улсуудын цагдаагийн сургуульд 2.5 жилийн хугацаатай бэлтгэдэг. Энэ хугацаанд онол, практик сургалтад хамруулдаг ба суралцагсдад онолын мэдлэгийн нэг сургуульд, практикийн сургалтыг өөр сургуульд олгодог, сургалт тасралтгүй байх үүднээс сургалтын хөтөлбөрт нарийвчлан тусгагдаг байна.

Төгсөгчид бага бүрэлдэхүүний албан тушаал хаших эрх авах шалгалтыг өгч, цагдаагийн дунд боловсрол эзэмшсэн гэрчилгээ гардан авдаг.

Энэхүү сургалтад ерөнхий боловсролын сургууль төгссөн охид, хөвгүүдийг элсүүлэн суралцуулах ба элсэлтийн шалгалтад сэтгэн бодох чадвар, сэтгэл зүй, бие бялдрын сорил авдаг.

Хоёрдугаар түвшин- Холбооны улсуудын цагдаагийн дээд сургуулиудад бэлтгэдэг дунд удирдах бүрэлдэхүүний бэлтгэл бөгөөд тусгай (цагдаагийн) дээд боловсролын диплом олгодог. Сургалтын хугацаа 3 жил байдаг.

Гуравдугаар түвшин- ХБНГУ-ын Цагдаагийн удирдлагын академид бэлтгэдэг ахлах бүрэлдэхүүний бэлтгэл бөгөөд цагдаагийн удирдлагын дээд боловсролын гэрчилгээ олгодог. Сургалтын хугацаа 2 жил байдаг. Тус академид дараах болзол хангасан албан хаагчдыг элсүүлэн суралцуулдаг. Үүнд:

- Ажиллаж буй цагдаагийн байгууллага албан хаагчийн ажлын үр дүнг эерэгээр үнэлж, тодорхойлсон,

¹ Олег Мартыненко. Профессиональное обучение полиции Германии (по материалам МВД Украины).



- Цагдаагийн байгууллагад 12 жилээс доошгүй хугацаагаар ажилласан,
- Ерөнхий комиссар цолоос багагүй цолтой,

- 40 хүртэл (онцгой тохиолдолд 45 хүртэл) насны,

- Шуурхай албанд ажиллаж байсан-зэрэг болно.

Цагдаагийн удирдлагын академи нь цагдаагийн менежмент, нийгмийн ухаан, эрх зүй, цэргийн хэргийн мэдлэг олгох 4 салбар, 80 гаруй багш, 700 гаруй сонсогчтой. Сургалтын хөтөлбөр нь онолын хичээл 25%, дасгал, дадлагын хичээл 40%, хүнтэй харилцах чадварыг сайжруулах дадлага 10% байдаг.

Германы цагдаагийн хүний нөөцийг бэлтгэх асуудлыг Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, орон нутгийн цагдаагийн байгууллагын тухай хууль, журмаар зохицуулдаг. Тухайлбал, Гамбургын холбооны улсын цагдаагийн байгууллагын албан хаагчдыг бэлтгэх асуудлыг "Гамбургын цагдаагийн байгууллагад алба хаах журам", "Гамбургын цагдаагийн сургалтын журам", "Гамбургын цагдаагийн шалгалтын журам" зэрэг хэд хэдэн эрх зүйн баримт бичгээр зохицуулагддаг.

Гамбургын цагдаагийн алба 3 түвшинтэй.

-Нэгдүгээртүвшин-полицайвахмейстерээс полицайхаупмайстер хүртэлх цолны албан тушаал

-хоёрдугаар түвшин - цагдаагийн комиссараас (шуурхай албаны) цагдаагийн нэгдүгээр ерөнхий комиссар хүртэлх цолны албан тушаал

-гуравдугаар түвшин - цагдаагийн зөвлөх (шуурхай албаны зөвлөх), зөвлөхөөс дээш цолны албан тушаалыг тус тус хамардаг.

Гамбургын цагдаагийн байгууллага нь ерөнхий цагдаа (нийгмийн аюулгүй байдлын цагдаа), голын усны, эрүүгийн цагдаа гэж хуваагддаг. Гамбургын цагдаагийн дийлэнх бүрэлдэхүүнийг ерөнхий цагдаагийн албан хаагчид эзэлнэ. Ерөнхий цагдаад дараах иргэнийг элсүүлэн авдаг. Үүнд:

•16-аас багагүй, 25-аас илүүгүй насны,

•тусгай боловсрол эзэмшсэн, бундесверт 4-өөс доошгүй жил ажилласан, 4-өөс доошгүй жил хүүхэд асрах ажил / хүүхдийн төлөө/ эрхэлсэн эсхүл цагдаагийн байгууллагад алба хаах онцгой ур чадвар, мэдлэг эзэмшсэн 35 нас хүрээгүй байх,

•бүрэн дунд сургуулийн ахлах ангийг (8-р анги) төгссөн гэрчилгээтэй,

•цагдаагийн байгууллагад алба хааж

чадахыг батлан харуулах шалгалтыг амжилттай өгсөн,

•эрүүл мэндийн хувьд цагдаагийн байгууллагад алба хаахад тэнцэх.

1 дүгээр түвшний албаны сургалт:
Цагдаагийн байгууллагад ажиллахаар сонгогдсон иргэн нь бэлтгэл албаны хүрээнд 1 жилийн турш анхан шатны сургалтад хамрагдаж, сургалтыг амжилттай дүүргэсний дараа төгсөлтийн шалгалт өгнө. Төгсөлтийн шалгалт амжилттай өгсөн цагдаагийн албан хаагч нь туршилтын хугацаагаар полицайвахмайстер ба полицайобервахтмайстер цол эдэлж цагдаагийн албан тушаалд туршилтын 3 жилийн хугацаатай ажиллана. Гэхдээ бундесверт 4-өөс доошгүй жил ажилласан эсхүл 4-өөс доошгүй жил хүүхэд асрах ажил эрхэлсэн, бүрэн дунд сургууль 8 дугаар ангийг төгссөн цагдаагийн албан хаагчдын хувьд 2.5 жил байж болно.

Туршилтын хугацаанд уг цагдаагийн албан хаагч нь 1 дүгээр түвшний албаны сургалтад үргэлжлүүлэн суралцсаар байна. Энэ сургалт журамд зааснаар 2 жил үргэлжлэх боловч бундесверт 4-өөс доошгүй жил ажилласан эсхүл 4-өөс доошгүй жил хүүхэд асрах ажил эрхэлсэн, бүрэн дунд сургуулийн 8 дугаар ангийг төгссөн албан хаагчийн хувьд 1.5 жил байж болно. Сургалтын төгсгөлд цагдаагийн полицаймайстер цол авч, холбогдох албан тушаалд томилогдохын тулд 1 дүгээр түвшний албанд тохирох эсэхийг тодорхойлох шалгалт өгөх ба дээрх туршилтын хугацааг дүүргэн амжилттай ажилласан байхыг шаардана.

Дээрх нэг жилийн хугацаатай анхан шатны сургалт, дараагийн 2 жил (1.5 жил)-ийн сургалтууд нь орон нутгийн цагдаагийн сургуулиудад явагдана.

1 дүгээр түвшний албаны сургалтын хугацаанд цагдаагийн сургуулийн сонсогчид криминалистик (Эрүүгийн эрх зүй, криминалистикийн тактик, криминалистикийн техник, эрэн сурвалжлах ажиллагаа г.м), эрх зүй (төрийн албаны эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, цагдаагийн эрх зүй, зөрчлийн эрх зүй, замын хөдөлгөөний эрх зүй г.м), нийгмийн ба хүмүүнлэгийн шинжлэх ухааны (сэтгэн бодох, менежмент, нийгэм судлал, сэтгэл судлал, ёс зүй, гадаад хэл г.м) зэрэг 2200 цагийн онолын хичээл үздэг.

Германы цагдаагийн дээд сургуулиудын сургалтын анхны жил онолын цогц хичээлүүдийг судална. Хоёр дахь жилд хоёр онолын блок сургалт, гурав дахь жил-



төгсгөлийн жилд практик сургалтын курс байх ба эхлээд практик сургалт явуулдаг цагдаагийн дээд сургууль дээр, дараа нь цагдаагийн хэсэг дээр сургалтад хамрагдаад, эцэст нь мэргэжлийн шалгалт өгдөг.

Цагдаагийн алба хаагч нь замын хөдөлгөөнийг зохицуулах, зам тээврийн ослын газарт ажиллах, хэргийн газрын үзлэг хийх, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажиллах, зөрчилдөөнийг галт зэвсэг хэрэглэхгүйгээр шийдвэрлэх мэдлэг, ур чадвар заавал эзэмшсэн байх ёстой тул эдгээр чиглэлээр төрөл бүрийн нөхцөлд хэрхэн ажиллах талаарх дасгалын хичээлүүд түлхүү ордог. Тухайн сургуулийн орон тооны бүтцэд хохирогч, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн иргэний, мансууруулах бодис худалдаалагчийн зэрэг дүрд тоглох тусгай алба хаагчид байдаг.

Галын бэлтгэлийн сургалт дадлагын сургалтад үндэслэн явагдах бөгөөд буудлагын тир-нд гэнэт өөдөөс нь зэвсэггүй эсхүл зэвсэглэсэн иргэн гарч ирэх зэрэг нөхцөл байдлыг бүрдүүлж сургалтыг явуулдаг. Дадлага сургалт 12 хүнтэй бүлгээр явагддаг. Бүлэг бүртэй 2 багш ажиллаж, бүх төрлийн дадлага сургалтыг удирдан явуулж, суралцагчийг 15 онооны үнэлгээгээр дүгнэдэг, 5-аас доош үнэлгээ авсан тохиолдолд давтан суралцана.

Хууль зөрчигч нь дандаа эрэгтэй хүн байдаггүй, хууль тогтоомжид заасан тодорхой үйл ажиллагааг хийж гүйцэтгэх үүднээс эргүүлийн үүргийг эрэгтэй, эмэгтэй алба хаагчаас бүрдсэн баг гүйцэтгэдэгтэй холбоотойгоор охид олноор суралцдаг. Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив харьцангуй доогуур, аль ч хүйсний хувьд адил байдаг. Төгсөөд “цагдаагийн комиссар” цол авч, нэг таван хошуутай погон зүүдэг байна.

2 дугаар түвшний албаны сургалт: 1 дүгээр түвшний алба хаагч нь дараах тохиолдолд хоёрдугаар түвшний албаны албан тушаал эрхлэх сургалтад хамрагдана:

1) 32 нас хүрээгүй, эсхүл 25 наснаас алба хашиж эхэлсэн бол 40-с илүүгүй насны,

2) 1 дүгээр түвшний албаны шалгалтыг “3»-аас /хангалттай/ дээш үнэлгээтэйр өгсөн,

3) 1 дүгээр түвшний албаны шалгалт өгснөөс хойш цагдаагийн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан,

4) Дээд боловсролын диплом авсан байх,

5) 2 дугаар түвшний албаны албан тушаалд тэнцэх.

Энэхүү сургалтад хамруулах шийдвэрийг дээд шатны цагдаагийн байгууллагын сонгон шалгаруулалтын үр дүнгээр гаргана. Сургалтын хугацаа 3 жил байна. Сургалт нь Удирдлагын дээд сургуулийн цагдаагийн факультет дээр явагдана. Төгссөн цагдаагийн албан хаагч нь 2 дугаар түвшний албанд томилогдох хүртэл өмнөх албан тушаалдаа ажиллана. Цагдаагийн түшмэд нь 2 дугаар түвшний албан тушаалд уг түвшний шалгалтыг өгсний дараа 6 сараас 1 жилийн хугацаагаар туршилтын хугацаанд ажиллаж уг албанд тэнцэх эсэх нь тогтоогдсон тохиолдолд томилогдоно.

Цагдаагийн энэ сургалтын байгууллага нь цагдаагийн ажлын мэргэжлийн эрэлт, хэрэгцээг хангахад чиглэгдэж, албан хаагчийн чадвар, далд боломжуудыг нээн хөгжүүлэхийг зорьдог ба эрүүгийн алба, мансууруулах бодистой тэмцэх алба, эрэн сурвалжлах алба, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны албан хаагчдыг голчлон бэлтгэдэг.

3 дугаар түвшний албаны сургалт: 2 дугаар түвшний албаны цагдаагийн түшмэд нь дараах болзлыг хангасан тохиолдолд 3 дугаар түвшний албаны албан тушаал эрхлэх сургалтад хамрагдана.

• 41 хүртэл насны,

• 2 дугаар түвшний албаны шалгалтыг “3»-аас /хангалттай/ дээш үнэлгээтэй өгсөн,

• 2 дугаар түвшний албанд 4-өөс доошгүй жил (үүний 1-ээс доошгүй жил нь ерөнхий, голын эргийн, шуурхай албанд) ажилласан, тодорхой амжилт үзүүлсэн,

• 3 дугаар түвшний албаны албан тушаалд тэнцэх.

2 дугаар түвшний албаны сургалтад хамрагдахтай адил 3 дугаар түвшний сургалтад хамрагдах шийдвэрийг дээд шатны байгууллагын сонгон шалгаруулалтын үр дүнгээр гаргана. Сургалт 2 жил үргэлжлэх ба 2 үе шаттай байна. Эхний үе шатанд суралцагч нь орон нутгийн цагдаагийн сургуульд 1 жилийн хугацаагаар онолын мэдлэг, практик дадлагад суралцах ба сургалтын тал хэсгийг Гамбург хотын их сургуулийн хичээл, эрдэм шинжилгээ хуралд оролцох замаар дүүргэнэ. 2 дугаар үе шатанд нэг жилийн хугацаагаар Цагдаагийн удирдлагын дээд академид суралцана.

ХБНГУ-ын Цагдаагийн удирдлагын дээд академи нь цагдаагийн хүний нөөцийн удирдах бүрэлдэхүүнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр томоохон туршлага хуримтлуулсан тус улсын тэргүүлэх сургалтын байгууллага юм.



ХБНГУ-ын Цагдаагийн удирдлагын дээд академи нь улсын ба 16 муж улсын төсвөөс санхүүждэг. ХБНГУ-ын Дотоод хэргийн ба орон нутгийн Дотоод хэргийн сайдуудаас бүрдсэн Тэргүүлэгчдийн зөвлөл энэхүү академийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Зөвлөл нь мэргэжилтнүүдийн бэлтгэлийн үндэс, санхүү, төсөв, орон тоо, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлдог. Газар нутаг дээр нь оршдог гэдэг утгаараа Хойд Рейн-Вестфалия-ын орон нутгийн Дотоод хэргийн сайд шууд бус хяналт тавьдаг.

Академийн сургалт сургалтын хэлтсээс боловсруулсан ерөнхий сургалтын төлөвлөгөөгөөр явагддаг ба тодорхой хичээлүүдийн сэдэвчилсэн төлөвлөгөөг тусад нь гардаг.

Цагдаагийн байгууллагын захиалгаар шинжлэх ухааны тодорхой салбараар эмпирик судалгаа хийх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжих төслүүдэд ач холбогдол өгч хамтран ажилладаг.

Нэгдүгээр курсын сургалтын хөтөлбөрийг цагдаагийн удирдлага ба цагдаагийн үйл ажиллагааны цогц хичээлүүд (эрүүгийн эрх зүй, криминалистик 810 цаг, эрх зүйн хичээлүүд 390 цаг) бүрдүүлдэг. Хоёр дахь жил хүмүүнлэгийн ухааны 110 цагийн хичээлүүд нэмж үздэг.

Тус академид туршлагатай цагдаагийн алба хаагчдыг сонгон шалгаруулалтаар авч багшаар ажиллуулан цагдаагийн тусгай мэргэжлийн хичээлүүдийг заалгадаг ба 3-5 жил ажиллуулсны дараа нь цагдаагийн байгууллагад албан тушаал дэвшүүлэн томилдог байна.

Дүгнэлт

Германы цагдаагийн албан хаагчдыг мэргэшүүлэх үйл ажиллагаа байнгын үргэлжилж байхыг эрхэм болгодог, сургалт нь урьдчилан тодорхойлсон төлөвлөгөөний дагуу явагддаг байна.

Германы сургалтын байгууллагуудын гол зарчим сургалтыг практик байгууллагуудтай нягт уялдаатай явуулах ба гэмт хэрэгтэй тэмцэх мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх, үйл ажиллагааг боловсронгуй болгох, аюулгүй байдлын хэрэгцээ, шаардлага, алба хаагчдын боломж, чадварт нийцүүлэн техникийн ба тээврийн хэрэгслүүдийг нэвтрүүлэхэд илүү анхаарал хандуулдаг ажээ.

Германы цагдаагийн хүний нөөц бэлтгэх тогтолцооны онцлог цагдаагийн сургалтын

3 шатны байгууллагыг төгсөгчид хуулийн дээд боловсрол олгодоггүй, төгсөгч нь шүүх, прокурор, гаалийн зэрэг бусад байгууллагад ажиллах боломжгүй, зөвхөн цагдаагийн байгууллагад (онцгой тохиолдолд зарим төрийн байгууллагад) ажиллах эрх бүхий диплом олгодог байна.

АНУ-д хууль сахиулах байгууллагын ажилтныг бэлтгэхдээ мэргэжлийн өсөлтийг урамшуулан дэмжихэд голлон анхаардаг. Тухайлбал,

-Боловсролын болон нэмэлт зардлуудыг цагдаагийн байгууллагууд хариуцдаг;

-Ээлжийн ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөхгүй бол ажлын цагаар сургалтад суухыг цагдаагийн ажилтнуудад зөвшөөрдөг;

-Цагдаагийн офицер дээд боловсрол эзэмшсэн байх нь албан тушаал дэвшихэд заавал харгалзах нөхцөл хэмээн удирдлага нь авч үздэг байна.

Хотын захиргаа болон цагдаагийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Дээд боловсролын зөвлөл нь хот болгоны нэмэгдэл олговрын хэмжээг тодорхойлдог. Тухайлбал, Массачусетс мужид цагдаагийн албан хаагчдыг мэдлэг боловсролоо тасралтгүй хөгжүүлэх асуудлыг хөхүүлэн дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Их, дээд сургуулиудад суралцаж байгаа ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх журамд зааснаар:

-бакалаврын зэрэг олгох хичээлийн нэг цаг тутамд 1 оноо;

-хоёр жилийн коллеж төгссөн дипломтой бол 60 оноо;

-бакалаврын диплом эзэмшсэн бол 120 оноо;

-эрх зүйн магистрын зэрэгтэй бол 50 оноо олгодог.

Авсан 10 оноо тутамд хөдөлмөрийн хөлсийг 3%, 25 оноонд 6%, 40 оноонд 10%, 60 оноонд 15%, 120 оноонд 20%, 150 оноонд 30% нэмэгдүүлдэг.

Ингэж цалинтай чөлөө олгох, урамшуулах нь өөрсдийн ажил үүрэгт өндөр ач холбогдол өгч, үнэнчээр хандахад үр дүнгээ өгсөн байна.

АНУ-д хууль сахиулах байгууллагад ажилтан элсүүлэн авахдаа тодорхой кредит (60-120) цуглуулсан байхыг шаарддаг. Цагдаагийн академи төгсөгчид албан ёсны боловсролын зэрэг олгодоггүй, сургалтад суралцагсдад кредит цагийн тодорхой тоог тогтоож өгснөөр цагдаагийн албан хаагчид хамрагддаг. /Уг академийг АНУ-д боловсролын байгууллага гэж тооцдоггүй/ Японы мужийн цагдаагийн газруудын



алба хаагчдын 70% нь их, дээд сургууль төгссөн, 30% нь дунд сургууль төгссөн байдаг. Цагдаагийн анхан шатны сургалтаар цагдаагаа 10 сарын хугацаагаар бэлтгэдэг, гэхдээ сургалтын хугацаа нь их, дээд, дунд сургууль төгссөн байдлаараа өөр өөр байна. Тухайлбал, их, дээд сургууль төгссөн иргэний анхан шатны сургалтын хугацаа 6 сар, дадлагын хугацаа 3 сар, мэргэжлийн сургалтын хугацаа 2 сар, дадлагын хугацаа 4 сар байх бөгөөд уг сургалтыг дүүргэсэн тохиолдолд цагдаа болно.

2-4 жил ажиллаад цагдаагийн түрүүч болох шалгалт өгнө. Цагдаад ороходоо их, дээд сургууль төгссөн хүн сургалтын төлбөрт сард 2381000 иен буюу 2381 ам.доллар, дунд сургууль төгссөн хүн сургалтын төлбөрт 200300 иен буюу 2003 ам.доллар төлдөг. Цагдаагийн албан хаагч цол, албан тушаал ахих бүрд сургалтад хамрагдаж, шалгалт өгдөг байна.

Сингапур улсын Цагдаагийн академид:

- Цагдаагийн ажилтны үндсэн сургалт;
- Цагдаагийн ахлах байцаагчийн үндсэн сургалт;
- Аюулгүй байдал хариуцсан ажилтны сургалт;
- Туслах албан хаагчийн сургалт;
- Гэмт этгээдийг баривчлах ажиллагааны сургалт;
- Олон нийттэй харилцах албан хаагчийн сургалт зэрэг сургалт тогтмол явуулдаг.

Олон нийттэй харилцах албан хаагчийн сургалт нь 6 сарын хугацаатай, сургалтын хөтөлбөрт нь иргэдтэй ажиллах арга барил, сэтгэхүй, харилцааны соёл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, иргэдтэй хамтран ажиллах, тэдэнд хэрхэн туслах талаар сургалтыг ихэвчлэн ордог.

Цагдаагийн ажилтны үндсэн сургалтыг дүүргээд ажиллаж байгаа албан хаагч нь албан тушаал ахих бүрдээ сургалтанд хамрагдаж шалгалт өгдөг. Албан хаагчийг 2-3 жил тутам 30-35 хоногийн хугацаагаар давтан сургалтад, шинэ албан тушаалд томилогдсон ажилтанг тухайн ажил мэргэжлийн чиглэлээр нь 3-5 хоногийн сургалтад хамруулдаг.²

ДҮГНЭЛТ

1. ХБНГУ, АНУ, Япон, Сингапурын цагдаагийн байгууллагуудад мэргэжлийн сургалт хэд хэдэн үе шатыг багтаасан иж бүрэн, тасралтгүй, тогтолцоот шинжтэй, цагдаагийн албан хаагч

нь албан тушаал ахих бүрдээ сургалтанд хамрагдаж шалгалт өгдөг байна.

2. Зарим улсын цагдаагийн сургалтын байгууллагуудын сургалт боловсролын зэрэг олгох бус ажилтнуудыг зөвхөн цагдаагийн мэргэшсэн ажилтан байхад чиглэгдэж, энэ нь цаашид тогтвор суурьшилтай ажиллах шалгуур болдог байна.

3. Дээрх орны цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт нь албан хаагчид алдаа дутагдал гаргахгүй байхыг чухалчилж, тохиолдол, баримт шинжлэх, биеэр гүйцэтгэх практик сургалтад түлхүү анхаардаг байна.

4. Цагдаагийн албаны болон мэргэжлийн сургалтыг боловсронгуй болгох нь цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, улмаар үйл ажиллагаагаа чанартай явуулах үндсэн нөхцөл болох ба практик сургалтын шинэлэг технологийг нэвтрүүлэх шаардлага байна.

САНАЛ

1.Цагдаагийн байгууллагын өмнөө тавсан зорилго, зорилтуудыг шийдвэрлэх, эцсийн дүндээ цагдаагийн байгууллагын "имиж"-ийг дээшлүүлэхэд цагдаагийн байгууллагад ажиллах дур сонирхолтой, үнэнчээр ажиллах иргэнийг сонгон бэлтгэх, тасралтгүй мэргэшүүлэн хөгжүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх, үүний тулд гадаад орны туршлагыг судлан нэвтрүүлэх, үндэсний цагдаагийн хүний нөөц бэлтгэдэг сургалтын тогтолцоо, хөтөлбөрт өөрчлөлт оруулах,

2. Суралцагсдад шинжлэх ухааны ерөнхий мэдлэг олгохоос гадна тэднийг бие даан үйл ажиллагаа явуулах чадвар олгох практик сургалт явуулах орчинг бүрдүүлэх, багш нарыг бэлтгэх нь зүйтэй байна.

² Ц.Наранчимэг. Цагдаагийн салбар дахь мэргэжлийн тасралтгүй боловсролыг хөгжүүлэх асуудлыг судалсан зарим үр дүн. Дисс ажил. УБ. 2013. 80-85 дахь тал.



ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Б.Баянмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
цагдаагийн хошууч

Хүний нийгэм, үүсч хөгжсөн үеэсээ гэмт явдлын улмаас үүсэх хор аюултай нүүр тулсаар ирсэн түүхтэй. Хүн төрөлхтөн гэмт явдлыг зөвхөн хатуу чанд ял шийтгэлийн хүчээр хориглон зогсоох боломжгүйг ухаарсан цагаас хойш, нийгмийн сөрөг үзэгдлийн хамгийн тод илрэл болсон гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг бий болгожээ.¹

Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээний хэлбэрийг тодорхойлохдоо уг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж эхлэх үе, нийгэмд харш илэрлийн мөн чанар, онцлог, түүнийг дахин давталтаас сэргийлэх зайлшгүй шаардлага зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.²

Хууль сахиулах байгууллагуудын нэг чухал зорилт бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх аргаар зохиоход оршино.³

¹ Г.Даштүдэв. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй". УБ. 2007. 123 дахь тал

² Н.Жанцан. "Гэмтхэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ". УБ. 1986. 31 дэх тал

³ Ж.Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. УБ. 1997. 159 дэх тал

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль зүйн уламжлал, шинэчлэл нэвт шингэсэн, үр өгөөжтэй байх шаардлагатай. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн түүхэн тодорхой нөхцөл, хүмүүсийн аж амьдралын түвшин, хуулийн хэрэгжилт, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.⁴

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хүн амын нягтрал болон үйлдвэржилт, эдийн засгийн байдал, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамааран аймаг, нийслэлд цагдаагийн газар, хэлтэс, сум, дүүрэгт цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн нэг маягийн зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллаж байна.

Гэмт хэрэг бол нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд хэзээ ч устаж үгүй болохгүй аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй үр дүнтэй хэлбэрээр явуулах ёстой бөгөөд ялангуяа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжид, цагдаагийн байгууллагын нийт албадыг төлөөлөн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд хэсгийн байцаагч нар, хамгийн их үүрэг хариуцлага хүлээдэг.

Иргэд хэсгийн байцаагчийн ажлын үр чадвар, үр дүнгээр нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй байдаг бөгөөд нөгөө талаар тэдгээр нь хүн ам, хамт олон, иргэдийг цагдаагийн байгууллагатай холбогч албан тушаалтны хувьд хэв журмын албанд харьяалагдана.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлнэ. Тэдгээр нь ард иргэдтэй хамгийн ойр дөт байж, тодорхой баг, хороо зэрэг засаг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг.

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны хамгийн гол барих ёстой чиглэл бол урьдчилан сэргийлэх ажил мөн. Учир нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулснаар хариуцсан нутаг дэвсгэр, тухайлбал, ард иргэд амар тайван байх нөхцөл бүрдэнэ.

Өнөөдөр, хэсгийн байцаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий уриа лоозон тавих, хурал, цуглаан, сургалт, семинар явуулахаас биш тодорхой хүнд ялгавартай хандаж, нэг бүрчилсэн ажил

⁴ Н.Гаравсүрэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба Цагдаагийн байгууллага. УБ. 2002. 3 дахь тал



зохиох нь илүү үр дүнд хүрдэгийг практик харуулж байна.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил ихээр үйлдэгдэж, түүний улмаас иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид учруулах хохирол нэмэгдсээр байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг улам хүчтэй болгохын зэрэгцээ шинэлэг арга барилаар ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

Нийгмийн хэв журам хамгаалах, нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх нь зөвхөн цагдаагийн төдийгүй, төр, олон нийтийн бусад байгууллага, албан тушаалтан, бүх хүнд хамааралтай нийгмийн өргөн хүрээтэй ажил юм.⁵

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын эцсийн зорилго нь ноцтой, аюултай үйлдэл болох гэмт хэрэг, зөрчлийг багасгах, улмаар түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг арилгах, ард иргэдийн амгалан тайван байдал, ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудал байдаг билээ.⁶

Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил хаана олноор үйлдэгдэж байна, тэнд согтуурах явдалтай хийх тэмцэл сул, зохиосон ажлын үр нөлөө хангалтгүй байгаагийн баримт юм.⁷

Энэ бүхнээс харахад, цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол ачааг нуруундаа үүрч явдаг хүн бол яахын аргагүй хэсгийн байцаагч юм. Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг засаг захиргааны анхан шатны нэгж дээр бие даан зохион байгуулж байгаа гол хүч юм.

Хэсгийн байцаагч нар гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэлт хийх, өргөдөл, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж цагдаагийн бусад албан тушаалтнуудтай харьцуулбал хууль хамгаалах бүх хүрээг хамарч цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажилладаг өргөн эрх хэмжээтэй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үндсэн нэгж албан тушаалтан

⁵ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ. 2014. 261 дэх тал

⁶ Д. Таванжин. Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил, түүний үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал. УБ. 2002. 19 дэх тал

⁷ Ж. Долгорсүрэн. Согтууралтай хийх ажилд иж бүрэн хандах асуудал. УБ. 1988. 67 дах тал

билээ.

Хэсгийн байцаагч нь байгууллагынхаа өвөрмөц олон талын үйл ажиллагааг ийнхүү бие даан явуулахдаа төвөөсөө алслагдмал, холбоо мэдээллийн хувьд дутагдалтай, ажлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны гол цөмийг бүрдүүлдэг албан тушаалтан юм.

Энэ бүхнээс харахад, хэсгийн байцаагч нь цагдаагийн эрх зүйн бие даасан субъект болж, цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж байгаа албан хаагч бөгөөд өөрийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын өмнө хариуцан тайлагнаж, оршин суугаа газрынхаа хүн амд ажлын үр дүнгийн талаар тайлангаа тавьдаг.

Өнөөдөр хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг биечлэн гүйцэтгэж, иргэд, байгууллагаас гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж байна.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажлын арга барил шинэчлэгдэхгүй, удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдан алдаа дутагдал гарч, ажлын үр нөлөө төдийлөн дээшлэхгүй байна. Түүнчлэн, хэсгийн байцаагч бүр хариуцсан хороо, нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах чиглэлээр хийж буй ажил нь бодит байдал дээр удирдлага, зохион байгуулалт муутай, нэг хэвийн байдлаар явагддаг учраас өнөөгийн нийгэм тэднээс шинэлэг олон санаа сэдэж, олон зүйл хийж ажиллахыг шаардаж буй үндэслэн, практик үйл ажиллагааны ололт, дутагдалд дүн шинжилгээ хийж, тавьсан зорилтыг ханган биелүүлж, ирээдүй хэтийн зорилгодоо хүрэх зарим арга замыг судлан тодорхойлоход дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга бол гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм гэдгийг бид сайтар ухамсарлаж, энэ чиглэл рүү анхаарлаа хандуулах цаг болсон байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн амжилтанд хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлаа өдөр тутам мэдэж үнэлэх, ажлаа



ухаалгаар төлөвлөх замаар албаны цагаа ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа илүү тохиромжтой тактикийн арга барилыг сонгож хэрэглэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын туршлага, шинжлэх ухаан, технологийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчинг бүрдүүлэхэд оршино.⁸

Бид өнөөдөр нийгмийн өөрчлөлтийг соргогоор мэдэрч, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг нийгмийн хөгжлийн зүй тогтолтой уялдуулан байнга шинэчилж байх, түүнийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга, тактикийг боловсронгуй болгох арга замыг бий болгоход анхаарлаа хандуулах шаардлага бий болж байна.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ нарийвчлан шинэчлэн тодорхойлох, хууль сахиулах ажлынхаа арга барил, хэлбэр, удирдлага, зохион байгуулалтаа нийгмийн бодлого, өөрчлөлттэй уялдуулан шинэлэг, үр дүнтэй арга механизмаар солих зорилгоор шинэчлэлтийн бодлого явуулж байгаа нь нэн сайшаалтай.

Тийм боловч эхний ээлжинд нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийг хариуцан ажиллаж байгаа цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан тодорхой болгох, удирдлага, зохион байгуулалтын шинэлэг хэлбэрийг бий болгож чадвал гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө тодорхой хэмжээгээр дээшлэх юм.

Хэсгийн байцаагч нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зэрэг 12 голлох хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудын хэрэгжилтэнд хяналт тавьж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх үүргийг гүйцэтгэж байна.

Үүний зэрэгцээ ЦЕГ-ын даргын 2015 онд шинэчлэгдэн баталж мөрдүүлж буй “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” болон “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг баримтлан, ⁸ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 112 дахь тал

“Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын дагуу ажиллаж байна.

Хэсгийн байцаагч нь захиргааны зөрчлийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд зөрчлийг 14 хоногт, шаардлагатай тохиолдолд албаны даргаар 14 хоногийн хугацаагаар сунгуулж нийт 28 хоногийн дотор шалгаж шийдвэрлэх бөгөөд хангалттай үндэслэл тогтоогдсон тохиолдолд зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар баривчлуулах, торгуулийн хуудсаар болон шийтгэвэрээр торгох арга хэмжээ авдаг байна.

Захиргааны арга хэмжээ авсан материалыг захиргааны тоо бүртгэгчид хүлээлгэн өгөхөдөө захиргааны шийтгэл ногдуулсан, хохирогчийн талаархи болон захиргааны зөрчлийн картуудыг хамт бөглөж, санд шивж оруулах ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Мөн Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-т тухайн сум, дүүрэг, баг, хорооны Иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурал, тухайн шатны Засаг дарга хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар хэсгийн байцаагчийг удирдана гэж заажээ.

Энэ зүйл заалтын хүрээнд ИТХ болон ИНХ, Засаг дарга нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагчтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргах, мөн хэв журам хамгаалах чиглэлээр олон нийтийн эргүүл, жижүүр ажилуулах тухай захирамж гаргах гэх мэт үйл ажиллагаагаар хэрэгжиж байна.

Дээрхи хууль тогтоомжууд, эрх зүйн актуудыг хэрэгжүүлж ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хуулийн хүрээнд ажил үйлчилгээгээ явуулж байгаа боловч хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг хөнгөвчлөх, хэсгийн байцаагчийн ажлын зааварт заасан “энгийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна, хэрэв ажлын цагийг шаардлагатай тохиолдолд сунгаж ажилласан бол дараагийн боломжтой өдөр нөхөн амраах, бямба, ням гаригт амрах ба амралтын өдөр ажилласан бол мөн дараагийн боломжтой гаригт амраана” гэсэн заалт хөдөө орон нутагт ч тэр, нийслэлийн хэмжээнд ч тэр хэрэгждэггүй байна.

Хэсгийн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт гарсан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож арилгахын тулд тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тухайн нутаг дэвсгэрийн объект болон



субъектын судалгаа, гэмт хэргийн өсөлт бууралт, гэмт хэрэг, зөрчил гарч буй цаг хугацаа зэргийг нарийн тогтоож, түүний эсрэг нарийн бодож төлөвлөсөн иж бүрэн арга хэмжээг боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй татан оролцуулснаар нэг талаар олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа сайжрах, нөгөө талаараа цагдаа иргэдийг хооронд нь ойртуулах гүүр болох юм.⁹

Хэсгийн байцаагч өөрийн хариуцдаг нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэдтэйгээ ойр дөт байж, тэдэнд тус нэмэр болохоос гадна тэдэнд үйлчилж, үйлчилсэнийхээ хэрээр ард иргэдээсээ итгэл хүлээж, тэднээр туслалцуулж, хамтран ажиллах нь чухал асуудал болоод байна. Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ иргэдийн итгэлийг хүлээж чадсан хэсгийн байцаагч нь ард иргэдээсээ байнгын мэдээллээр хангагдахын зэрэгцээ нутаг орноо сайн мэдэрснээр ажил үйлчилгээ явуулах таатай орчныг бүрдүүлж чадна.

Өнөөдөр хэсгийн байцаагч засаг захиргааны тодорхой нэгж хариуцан хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, захиргааны хяналтын олон талт үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэхээс гадна цаг үеийн болон өөр бусад ажилд оролцдогоос хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэр дээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах иргэд, оршин суугчдын гүнд нь орж ажиллах, судалгаа бүртгэл хийх, объектын судалгаандаа баяжилт хийх, мэдээлэл цуглуулах боломж хязгаарлагдмал байна.

Хэсгийн байцаагчдын хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн тодорхой арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудад камер, дохиолол хамгаалалтын систем суурилуулах ажлыг зохион байгуулах, тэднийг байнгын харуул хамгаалалттай болгох, сонор сэрэмжийг нь дээшлүүлэх, заавар, зөвлөлгөө өгөх, хяналт шалгалт хийх ажил нь тогтмолжоогүйгээс гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байна.

Өөрсдийн хувийн зардлаар өрөө тасалгаага тохижуулах, хаяг самбар, бүртгэл судалгааны дэвтэр хийлгэх, бичиг хэргийн хангалт муу байгаагаас шалтгаалан хувиасаа цаас авах зэрэг дүрэм журамд харшилсан зүйл байсаар байна. Гэтэл энэ бүхнийг

⁹ Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. УБ. 2013. 146 дахь тал

хувиасаа гаргаж байх цалин хөлс хангалттай авдаггүй. Мөн Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт хэв журмын тасгийн дарга нарын баталсан дүрэм журамд нийцээгүй цагийн хуваарийн дагуу энгийн өдөр **08.00-24.00** цаг хүртэл ажиллаж байна.

Улаанбаатар хотод ажиллаж амьдарч байгаа хэсгийн байцаагч нартай хэсэгчилсэн фокус ярилцлага хийхэд, тэдний 75.8 хувь нь өргөдөл гомдол шалгах нь ажлын ачааллыг улам нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, багийн айл өрхөөр орж биечлэн уулзах, зөвлөгөө өгөх, хорооны иргэдтэй хамтарч ажиллах зэрэг үндсэн ажлаа явуулах цаг хомс болсон байна.

Тэдний ярилцлагын хэсгээс авч үзвэл:

•Хэсгийн байцаагч хэрэг бүртгэнэ, түрийчийн яриад байсан эрэн сурвалжлах ажиллагааг хийх, дээрээс ирж байгаа тушаал, үүрэг, даалгавар, шийдвэрүүдийн биелэлтийг хангана, захиргааны олон хяналтын үйл ажиллагааг явуулна, өргөдөл, гомдлыг шалгаж шийдвэрлэнэ, нэг үгээр хэлбэл бараг л “робот цагдаа” болчихоод байна. Нэг өдрийн зураглал нь өглөөний мэдээллийн хуралд суухаас эхлээд 23, 24 цаг хүртэл ажиллаж байна.

•Яагаад ингэж ажиллаж байна вэ гэхээр хүссэн хүсээгүй өргөдөл, материал цохчихоор тухайн хэсгийн байцаагч хийхээс өөр аргагүй. Хуульдаа ажлын 5 хоногт хий гээд дээрээс шахаад байдаг, шийдэхийн тулд ганц материал авсан хүн хүссэн хүсээгүй явна. Удирдлагаас цаасан материал үзэж шалгахгаас бус чанар, үр дүнг тооцдоггүй. Архидан согтуурахтай тэмцэх ямар ажил хийсэн, хороон дээр хэдэн гэмт хэрэг гарсан, энэ хэрэг дээр та юу хийсэн гээд л тэгээд баахан түдгэлзүүлсэн хэрэг аваад л зарим нь уншсан ч юм уу, уншаагүй ч юм уу, тэгээд нэг түдгэлзүүлсэн хэргийн төлөө яваад нөгөө хүнийг нь барьж авах гээд явна. За эзэнгүй хэрэг юу байна, энэ хэрэг дээр хэсгийн байцаагч яг юу хийж байна гээд л ингээд хэсгийн байцаагчийн ажил маш олон тийшээ салбарлаж байна.

Фокус ярилцлагын үр дүнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг засаг захиргааны анхан шатны нэгж дээр зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа чухал албан тушаалтан мөн болохыг харуулж байна.

Дүгнэлт

Хэсгийн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын үр дүнд, байцаагч нараас гаргасан санал, бодол, хүсэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:



Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэх гол үндсэн нэгж бол цагдаагийн хэсэг, түүнийг хэрэгжүүлэгч нь хэсгийн байцаагч нар байна гэдгийг удирдлагад сайтар ойлгуулж, үйл ажиллагааг дэмжүүлэх шаардлага бий болсон байна. Тухайлбал, хэсгийн байцаагчийн ажил үүрэгт үүргийн давхардал их байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн алба маань тодорхой хэмжээний ажилтай эргээд үзүүлэх юмтай байхад хэсгийн байцаагч салбар болгон руу орж ажилладаг боловч эргээд ажил нь үнэлэгдэхгүй, үнэлэмж муутай, ажил үүргийг нарийн сайн зааглаж өгөхгүй бол маш олон салбарын ажил руу давхардаж орж байна гэж үзэж байна.

Ажлын ихэнхи цагаа өргөдөл, гомдол шалгах, хэрэг бүртгэх үйл ажиллагаанд зарцуулж байна. "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ыг шинэчлэх шаардлагатай байна. Заавар батлагдаж хэрэгжээд даруй 13 жил өнгөрсөн бөгөөд зарим заалт нь шаардлага хангахгүй болсон. Өөрөөр хэлбэл, хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарьт сард харьяа хорооныхоо айл өрхөөр орж, санал хүсэлтийг авна гэж заасан боловч энэ нь практик дээр хэрэгжих ямар ч боломжгүй.

Өнөөдөр газар, хэлтэс, тасаг, нутаг дэвсгэрийн тасгийн дарга гэх мэтчилэн маш олон шат дамжлагын дарга нь өөрсдийнхөө чиглэлээр олон үүрэг, даалгавар өгдөг, тэр нь хоорондоо давхарддаг, маш олон судалгаа, ажил үүргийг нэхдэг байдал одоог хүртэл хэвээрээ байна. Тухайлбал, гадаадын өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийн хамгаалалт мөн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад байнга татагдан оролцдог.

Хэсгийн байцаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндсэн чиглэл нь тодорхой бус, хэсгийн байцаагчийн ажлын байрны нэгдсэн тодорхойлолт, нэгдсэн нэг ойлголтгүй байгаагаас нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болгон өөр өөрийнхөөрөө хийж байна. Үүнийг цэгцлэх шаардлагатай болжээ. Мөн хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийн дагуу явагдаж чаддаггүй, ажлын ажлын байрны орчин нөхцөл муу, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна, ажлын үр дүнг үнэлэх шалгуур, үзүүлэлт бодитой бус байна гэж үзэж байна.

Санал

1.Хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхой болгох;

2.Хэсгийн байцаагч урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангаж өгөх;

3.Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах шаардлага бий болсон;

4.Үндсэн ажил үүргээс гадуур маш олон ажилд татагдан оролцдог байдлыг цэгцлэх;

5.Хэсгийн байцаагч нарт олон шат дамжлагын дарга нараас өгч буй үүрэг, даалгаварын давхардлыг арилгах, нэгдсэн нэг удирдлагаар хангаж өгөх-зэрэг болно.



ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ СЭТГЭЛ ЗҮЙН АСУУДАЛ АЖИЛ ҮҮРЭГТ НӨЛӨӨЛӨХ НЬ

Д.Идэрмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн дэд
хурандаа

Цагдаа бол Монгол Улсын дархлаа юм.¹ Тийм ч болохоор цагдаагийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх бие болон сэтгэл зүйн өндөр чадвартай хэрэгтэй.

Цагдаагийн ажлын ачаалал их, хүнд, онц хүнд гэмт хэрэг дээр ажилласнаар сэтгэл зүйн хувьд тогтворгүй болж, стресст орох, улмаар гэр бүлдээ уурлаж ууцаарлах, иргэдтэй харилцааны зөрчил гаргах явдал тохиолддог.

Улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, ажилгүйдэл, ядуурал, хотжилт, нийгмийн хурдацтай өөрчлөлт, баян хоосны ялгаа, бүлэг хоорондын зөрчлийн улмаас нийгмийн бухимдал үүсч, иргэд гэмт хэрэг, зөрчил үйлдэх, бие биедээ хүндэтгэлгүй хандах зэрэг сөрөг үзэгдэл газар авч байна. Энэхүү нийгмийн сөрөг үзэгдэлтэй өдөр тутам нүүр тулж буй цагдаагийн албан хаагч сэтгэл зүйн хэт ачаалал, ажлын дарамт, шахалт, нэг хүний боломж, нөөцөөс давсан их ажил, удирдах ажилтны ажлын зөв зохион байгуулах чавдар, манлайлал дутмагаас шалтгаалан сэтгэлийн дарамтад орох, улмаар сэтгэцийн эмгэгтэй болж, амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал цөөнгүй байна.

Сэтгэл зүйн хэт ачаалал, цочрол, айдас, бухимдал, сэтгэл гутрах зэрэг нь хүнийг сэтгэл зүйн өөрчлөлтөд оруулж, хэвийн хэмжээнээс хэтэрвэл хувь хүнд сэтгэлзүйн дарамт үүсгэж, сэтгэцийн эмгэг шинж болох аюултай байдаг.

Судлаачид сэтгэл зүйн дарамт үүсгэгчийг нийгэмтэй холбож сэтгэл зүйн хүнд цохилт, сэтгэлийн шарх гэмтэл, сэтгэлзүйн дарамттай холбоотойгоор тайлбарлаж байна. Үүний зэрэгцээ ажлын байран дахь сэтгэл зүйн дарамт нь байгууллагын түвшний болон хамт олон, бүлэг, хувь хүний зэрэг олон хүчин зүйлээс урган гардаг.

Тэр тусмаа Цагдаагийн албан хаагч нь ард иргэдэд сөрөг сэтгэлзүйн дарамтын нөлөөллүүд болох гэмт халдлага, аюул

занал учрахад хамгийн түрүүн тусламжийн гараа сунган гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, таслан зогсоож, амгалан тайван байдлыг хангах хүнд хүчир үүргийг нуруундаа үүрч байдаг.

Иймээс цагдаагийн алба хаагчид нь сэтгэлзүйн дарамтад өртөх магадлал өндөр байдаг. Тэгэхээр үүнээс нийгэм нь гишүүдээ, хувь хүн өөрөө өөрийгөө аварч гарах нөхцөл боломжийг харах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замд суралцах явдал чухал юм. Нийгмийн үнэт баялаг нь хүн бөгөөд улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс нь сэтгэцийн эрүүл мэнд юм.

Цагдаагийн албанд шуурхай, нөхцөл байдлаа үнэлэн зөв шийдвэр гаргах ур чадвартай, бие бялдар, сэтгэл зүйн зөв төлөвшилтэй, албаны бэлтгэлийг хангасан, харилцааны өндөр соёлтой, албандаа дур сонирхолтой, бие сэтгэцийн хувьд эрүүл иргэн ажиллавал зохимжтой, үр дүнтэй. Нөгөө талаас хэн нэг хүний нөлөө, шударга бус байдлаар төрийн тусгай албанд ажилд орох гэсэн санаархалтай хүмүүсийн эрх ашгийг гүйцэтгүүлдэг байгууллага биш нь ойлгомжтой.

“Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин: Одоо үед Цагдаагийн алба хүчний байгууллага биш, хууль сахиулах байгууллага байх ёстой. Цэрэгжсэн биш иргэний зохион байгуулалтад орох ёстой. Ил тод хариуцлагатай, иргэдэд хянагддаг, үйл ажиллагаа нь олон нийтийн дэмжлэгт тулгуурласан байх ёстой. Энэ л цагдаагийн албаны шинэчлэлийн байр суурь зарчим юм”² гэж хэлсэн.

Цагдаагийн албанд одоо хүртэл захиран тушаах арга хэлбэр хэрэглэж бүхий л үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. Энэ арга барил нь цэрэг суурьтай цагдаагийн албаны дотоод үйл ажиллагааны нэг хөшүүрэг болох боловч ямар нөхцөлд, ямар тохиолдолд яаж хэрэглэх вэ, ямар аргатай хослуулан хэрэглэх вэ гэдгийг ухааран зохицуулах шаардлага өнөө үеийн нийгмийн байдалтай холбоотойгоор урган гарч байна.

Цагдаагийн албан хаагчийн зүй бус харилцааны талаарх гомдол, санал ихэссэн асуудлын гол нь биш харин ард иргэд өнөөгийн нийгмийн уур амьсгал, нийгэм сэтгэл зүйн өөрчлөлттэй холбоотойгоор илэн далангүй өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, эрхээ хамгаалах боломж бүрдэж, нээлттэй болсон нь цагдаагийн албан хаагчаас нэгэн хэвийн хөшүүн хэвшмэл арга барил биш, уян хатан хосолмол харилцааг хүсэмжилж байгаатай холбоотой.

¹ Монгол Улсын төрийн соёрхолт, ардын уран зохиолч, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Лхагвасүрэнгийн хэлсэн үг

² Өдрийн сонин. 2015.03.11 № 58,59



Цагдаагийн албан хаагчаас гаргаж буй сахилга ёс зүйн зөрчлийн ихэнхийг иргэдтэй зүй бус харьцсан зөрчлүүд эзэлдэг. Тухайлбал, цагдаагийн байгууллагын хэмжээнд 2014 оны байдлаар 44 /үүнээс офицер 31, ахлагч 13/ алба хаагч 39 эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан байна. Эдгээр гэмт хэргийн 23.9 % хувь нь шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 7.7% өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тус тус эзэлжээ.

Мөн онд эрүүгийн хэрэгт холбогдсон цагдаагийн албан хаагчдыг албан тушаалаар нь ангилан авч үзвэл хэлтсийн дарга-1, мөрдөн байцаагч-5, эрүүгийн төлөөлөгч-3, хэсгийн төлөөлөгч-11, замын цагдаагийн байцаагч -2 тус тус байна.

Цагдаагийн ёс зүйг зуршмал байдлаас гаргаж, итгэлцүүрийн хэлбэрт оруулан тодорхой хугацаанд тооцож байвал үр дүн гарна.

Эдгээрийг шийдвэрлэхдээ цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрмийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж, хариуцлага тооцдоггоос биш, нэн тэргүүн анхан шатны сэтгэл зүйн нөлөөллийн тактикийн аргуудыг огт хэрэглэхгүй байна. Зөрчлийн судалгаан дээр хийсэн болон иргэдийн санал гомдлын талаарх социологийн судалгааны тоо баримт байхаас биш, сэтгэл зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, дүн шинжилгээ, цагдаагийн албан хаагчийн зөрчил гаргасан шалтгаан, нөхцлийг судалж, дүгнэлт хийх асуудал орхигдсоор ирсэн. Ёс зүйн хүрээнд сахилга, ёс зүйг төлөвшүүлэх сургалт явагдахаас биш мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн бэлтгэл эзэмшүүлэх чухал байна.

Цагдаагийн албаны хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаалын томилгоог ил тод нээлттэй, шударга болгох, байгууллага дахь харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, удирдах ажилтны удирдахуйн арга барил ур чадварыг нэмэгдүүлэх, цагдаагийн албан хаагчийг мэргэшүүлэх, төлөвшүүлэх, чадваржуулах, зөв хэвшил олгох албаны сургалтыг зохион байгуулж, албан хаагчийн сэтгэл зүйн дарамтад орох, ажлын алдаа дутагдал, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Цагдаагийн алба хаагчаас албан үүргээ чин сэтгэлээсээ нэр төртэй, сэтгэл зүйн дарамт, түгшүүр үүсгэх тулгамдсан асуудалгүй гүйцэтгэхэд сэтгэл зүйн нөлөө үзүүлэх эдгээр асуудлыг шийдвэрлэх нь сайн нөлөөтэй байдаг.

Тулгамдсан асуудалтай, сэтгэл зүйн

болон ой тогтоолтын сул түвшин дэх албан хаагч, сэтгэцийн хувийн онцлогоос хамаарч сэтгэл зүйн дарамттай орчинд дасан зохицох чадвар сул ажилтан байдаг. Эдгээр албан хаагчид нь хэрхэн гэмт хэрэгтнийг гярхай байдлаар таньж илрүүлэх, хэрхэн урьд өмнө болж өнгөрсөн гэмт хэргийг сэргээн санаж одоогийнхтойгоо харьцуулах зэрэг танин мэдэхүйн процессийн хурд, хүч шаардсан мэргэжлийн ажлыг гүйцэтгэх вэ? хэрхэн өөрийн хүч бололцоог зөвөөр үнэлж орчин нөхцөлдөө дасан зохицож стресс үүсгэх хоруу чанар бүхий нөлөөлөлд ертөхгүй байх вэ зэрэг асуудал тулгарч байна.

Сэтгэл судлалын шинжлэх ухаанд хөдөлмөрт хүнийг дотоод сэтгэлээс нь өдөөдөг сэдлүүд байдаг. Үүнд:

Хэрэгцээ, бие хүний үнэт зүйлс, субъектив сонирхол харилцаа ордог ба энэ нь цагдаагийн ажилтны зан үйлд янз бүрээр нөлөөлдөг. Мэргэжлийн чухал сэдлийг төлөвшүүлж, сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах аргуудыг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- Цагдаагийн ажилтнуудын үйл ажиллагааны зорилтыг хийх ажил бүрээр нь нарийвчлан тодорхой болгон хэлбэршүүлэх;
- Бие бүрэлдэхүүнд ажлын шинэ хандлага, сэдлийн баримжаа олгох;
- Алба хаагчдын ажилдаа хандах сэдлийг бэхжүүлэх, илрүүлэх, хувийн зохион байгуулалтыг идэвхжүүлэх;
- Удирдлага - Ажилтан гэсэн систем дэх дээрээс доош чиглэсэн мэдээллийг мэргэжлийн үйл ажиллагааны явцад ажилтнуудын харилцаанд үүссэн зөрчлийг арилгахад чиглэсэн доороос дээш хандсан мэдээллээр солих гэх мэт.

Сэтгэл зүйн бэлтгэл хангалтгүй байдлаас болж албан хаагчид ажлын цаг хийдүүлэх, хэрэг зөрчилд холбогдох, бэрхшээлийг даван туулж чадахгүй байх, түрэмгий зан илрэх, зан харилцааны зүй бус авир гаргах зэрэг сэтгэл зүйн дарамт үүсгэх хүчин зүйл болдог. Мөн цагдаагийн албан хаагч нийгэмд эзлэх байр суурь, гэмт явдлын шалтгаан, нөхцлийг арилгахад хуулиар хүлээсэн үүргээ ухамсарлан ажил албандаа үнэнчээр хандах нь өөрийн хэрэгцээгээ мэдэрнэ гэсэн ойлголт юм.

Цагдаагийн албан хаагчаас өөрийн хүч чармайлт шаардсан ажлыг амжилттай гүйцэтгэн, өөрийн чадварыг сорьсон үед “Би өөрийгөө шинээр олж харахыг хэлнэ” хэмээн өөрийн хэрэгтэй зүйлээ мэдрэх нь өөрийгөө таагүй нөхцөл байдалд оруулахгүй, ажил дээр гарсан бүтэлгүй явдалд шантрахгүй,



дараагийн бэрхшээлийг туйлбартай давахад зоригжуулж өөрийгөө эргэлзээнд оруулахгүй байхад хүч өгнө.

Мөн цагдаагийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцад ажиллах нөхцөл, ажлын ачаалал, хамт олны уур амьсгал, харилцаанаас тэдний сэтгэл санаа, бие организмд үүссэн дарамт, түүнийг даван туулах, дасан зохицох гэсэн хүч энерги бүхий хариу үйлдлийг ажил үүргээ гүйцэтгэх явцад гарч байгаа ажлын байрны стресс хэмээн үздэг.

Цагдаагийн албан хаагч буюу бие хүнээс хувийн давуу байдлаа мэдэрч, өөрийгөө бодитойгоор үнэлэх нь шинэ нөхцөл байдалд хурдан дасан зохицох, ирээдүй өөд тэмүүлэх, хуучныг мартаж ингэснээрээ стресст орохгүй байх нэг нөхцөл болдог байна.

Хүн өөрийн хүч, чадвар бодит боломжийг зөв тооцож байвал гутралд орохгүй байх, амжилтад хүрэх магадлалыг нэмэгдүүлдэг. Өөрийгөө зөв үнэлдэг хүн өөртөө итгэлтэй ханддаг ба өөрийгөө хэтрүүлэн үнэлэх, бусдаас дээгүүр тавих нь ирээдүйгээ буруу төсөөлөх, буруу шийдэл гаргах, хамт олонтойгоо үл ойлголцох байдалд оруулах зэрэг муу үр дагаварт хүрдэг. Энэ нь хувь хүний суурь шинжийн гол алдаа байдаг.

Ийм алдаанд орохгүй байх нь адил ажил, мэргэжилтэй үе тэнгийн найз нөхөд, өрсөлдөгч нартайгаа өөрийгөө зэрэгцүүлж сул болон давуу тал, авъяас чадвар, сонирхол, зан чанарын эерэг, сөрөг тал асуудалд хандах хандлага зэрэг ажил гүйцэтгэх чадвар болон хувийн сайн, муу талуудаа бодитойгоор судалж харьцуулан үзэхийг өөрийгөө ажиглах хэмээн үздэг. Судалгаа ажиглалт нь өөрийгөө, амьдралыг илүү таних, ойлгох боломжийг бий болгодог. Мөн хариуцлага хүлээх нь төрд ажиллаж байгаа хүний ухамсар, эр зориг, мэдлэг боловсролтой холбоотой.



**ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ
САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАЛТ
ЗЭВСГИЙН СУРГАЛТ БОЛОН МОНГОЛЫН
ЦАГДААГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Д.Мөнхжаргал

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Мөрдөх ажиллагааны онол тактикийн
тэнхимийн багш, магистр,
цагдаагийн ахмад

Товч агуулга: Хүн төрөлхтний түүхэнд галт зэвсэг үүссэн түүх, дайн байлдаанд хэрхэн хэрэглэж байсан тухай. Гараар бууддаг галт зэвсгийг хэрхэн сайжруулж ан ав, спорт, тэмцээн, дайн, тулаанд хэрэглэж байсан. Мөн өнөөгийн дэлхийн хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг хэрхэн бэлддэг талаар болон Монгол Улсын хууль сахиулах байгууллагын албан хаагчдын галт зэвсгийн сургалтын харьцуулалт.

Түлхүүр үгс: галт зэвсэг, цахиур буу, буудлагын сургалт, хууль сахиулах алба хаагч, Хууль сахиулах байгууллага.

Галт зэвсгийн бэлтгэлжилтийн талаар өгүүлэхийн өмнө товчхон түүхийг авч үзье. МЭӨ үед анх Хятадад дарь үүссэн гэж үздэг ба улмаар үүнийг баяр ёслол, цэнгээний үеэр хэрэглэхийн хажуугаар цэрэг, дайны зориулалтаар ашиглахаар тэр үеийн эрдэмтэн мэргэд зохион бүтээж байсныг түүхийн хуудаснаас харж болно. Анх хар дарийг Арабын улсад бий болсон гэх бөгөөд тэр үед тэсрэх бодисын чанартай гэж ангилдаг байсан. Улмаар Европт экспортод гаргаснаар тэр үеийн эрдэмтэн, судлаач, цэрэг дайны удирдагчид дарьны хурдан,

тэсрэмтгий чанарыг ашиглан үхэр буу гэх галт хэрэгслийг анх зохион бүтээсэн гэдэг.

Энэ үеэс дэлхий дахинд үхэр буу гэж нэрлэсэн хүчирхэг, хөнөөлт зэвсгийг мэдэх болсноор ийм зэвсгийг эзэмших, бий болгон бүтээхийн төлөө тэр цаг үеийн хаад эрдэмтэн мэргэд, зохион бүтээгч нарыг олноор нь цуглуулж ил, далд аргаар туршилт, үйлдвэрлэлийг хийн улс хоорондоо наймаалцаж ашиг олохын зэрэгцээ улам хөгжүүлэн, боловсронгуй болгож ирснээр Европ тивд өргөн тархсан байна. Тухайн цаг үед цэрэг, дайчдын дундаас үхэр бууг яагаад цөөхөн бүрэлдэхүүнтэй тэр дундаа хоёр эсхүл ганцаараа авч явах боломжтой, түүгээр төвөггүй гар дээрээс буудах зориулалт байдлаар буудаж болохгүй билээ гэсэн яриа дэлгэрч, эрдэмтэн, зохион бүтээгч, инженерүүд олон жил шаргуу ажилласны үндсэн дээр анхны гар дээрээс бууддаг, цэрэг бариад чиглүүлээд явж байхаар хэмжээг нь багасгаж, урт төмөр хоолой маягтай болгож, шүлт эсвэл хайрга чулуугаар бууддаг байсан байна.

Энэ галт зэвсэг нь найдваргүй бөгөөд идэвхтэй буудах хугацаа нь маш богино байжээ. Хамгийн анхны урт жинхэнэ буу нь бидний мэдэхээр амаар сумлагддаг буу байжээ. Энэ нь модон бариултай холбогдсон зөөлөн гол төмөртэй, гол төмрийг тулсан хэсэг болон мөрний хэсэгтэй бөгөөд хар дариар гол төмрийн амаар цутгаж цэнэглэнэ.

Гол төмрийн төгсгөлийн хэсэгт амны эсрэг талд нүх байдаг. Буудагчийн дарах гох нь хөшүүрэг төдий зүйл байжээ. Тэр хөшүүрэг нь голыг нүхээр дамжуулан дарийг ноцоон бөмбөлгийг голоор явуулдаг аж. Энэ урт буу нь эцэстээ дахиад л хоцрогдож, авч явахад төвөгтэй, бороотой үед норж ямар ч ажиллагаагүй болдог байжээ. Энэ төрлийн бууг “бялтны замагтай буу” гэж нэрлэдэг байсан байна. Бялтны замаг нь 16-18 дугаар зуунд Европт их хэрэглэгддэг байжээ. Мөн өндөр үнэнтэй, ан хийхэд тохиромжгүй байсан тул тийм ч түгээмэл болж чадаагүй байна. Том нумтай бялтны замаг нь хэдэн зууны туршид цэргийн зэр зэвсгээр ашиглагдаж иржээ. Түүнчлэн дарь хийдэг эвэр лүү оч үсэрч, гал асах магадлалтай, тэсэрч болзошгүй учир авч явахад эрсдэлтэй байжээ. Дарь дэлбэрч болох тул байлдагч зэрэмдэг болох бүр үхэх аюултай. Бялттай бууны дараах үе нь цахиур буу байв.

Тэр үеийн зэвсгийн хөгжил нь дайн тулаанаас гадна тэмцээн, уралдаанд хэрхэн хэрэглэгдэж байснаар яригддаг байлаа. Буудлагын спортын хамгийн түгээмэл



хэлбэр цахиур буугаар байг оновчтой онох хамгийн хол зай нь 80 бээр буюу 73.2 метр байжээ. Цахиур бууг үйлдвэрлэх болсон гол хөшүүрэг нь дахин цэнэглэхэд хурдан, мөн ойрхон зайд галтай бууддаг боломжтой байсан явдал бөгөөд мухар буунуудыг 16-р зуунд хэрэглэх болсон ч үйлдвэрлэхэд их урт хугацаа шаарддаг, өндөр өртөгтэй байсан байна.

Цахиур бууны дараагийн хувилбар нь барьцалдуулагчтай /үрэлтэй/ буу байв. Урт хэмжээтэй, гөлгөр амтай цахиур бууг дундад зууны үед зохион бүтээж байжээ. Дайны үед цэргүүд голдуу эгнээ мөр болон жагсдаг тактиктэй байжээ. Цэргүүд гал нээхдээ пулемёт бууны зарчимтай адилаар эгнээ эгнээгээрээ зэрэг зэрэг галладаг дүрэмтэй байсан байна. Тэдний хэрэглэдэг гөлгөр хошуутай буу нь буудахдаа 50 ярд /45м/ газраас илүү гардаггүй байсан байна. 18-р зууны дайны үеийн зэвсгүүд дараа дараагийн томоохон дайн байлдаанд гологдож эхэлсэн байна. Тусгаар тогтнолын төлөөх Америкийн колонийн дайн нь цэргийн бодлогод өөрчлөлт хийсэн байдаг.

Америкчууд Англи улсад дагаар орсон тэр үед Америкчууд ямар ч арми, цэрэг, флотгүй байсан. Учир нь Англи улсын арми маш хүчтэй, зэр зэвсэг сайтай, цэргүүдийн тоо илүү болохоор америкчуудаас бослого гарахад дарж чадах цаг үе байжээ. Америкчуудад байсан ганц зүйл нь их буу болон ховилтой их буу. Тэр нь англичуудын явган цэргийн их буунаас урт бөгөөд бага хүчээр их хурдтай бууддаг байсан. Тэд үүнийг ашиглан колониуд байсан бусад жижиг улсуудын хамтаар Англи улсын колониос гарсан түүхтэй ажээ.

Аж үйлдвэрийн хувьсгалын эхэн үеэс бууны үйлдвэрлэл ихэд дэлгэрч, 18 дугаар зууны сүүл хүртэл Европын тэргүүний армиудын хурандаа нар “Буу бол дайныг хийхэд тийм ч үр ашигтай зэвсэг биш” гэж үзэж байв. Британийн эзэнт гүрэн хийгээд Хойд Америкийн колоничлогчдын хооронд дайн, мөргөлдөөн хийх нөхцөл байдал бүрмөсөн өөрчлөгджээ.

Британичууд олноор хүлээн зөвшөөрөгдсөн нээлттэй тулалдааны аргыг хэрэглэж байв. Гэвч тэдэнд нэгэн таагүй асуудал тулгарсан нь ногоон хувцсаар өнгөлөн далдалж, харагдахгүй газар байрлах колонийн дайчид Британийн цэргүүдийг толгой дараалан хороож эхэлсэн явдал байлаа.

Хэдийгээр Британийн офицерууд америкчуудын шууд галын доор байгаагаар

мэдэж байсан ч аймхай гэж хэлүүлэхгүйн тулд нуугдахыг ч оролддоггүй байв. Мөн холын зайнаас өөрсдөө нуугдаж байгаад бууддаг энэ үйл явцыг британичууд бүр ч хулчгар явдал гэж үздэг байжээ.

Мөн офицеруудын дунд бичигдээгүй нэг хууль байсан нь урт буутай британи цэргүүд колонийн армийн офицерыг буудаж болохгүй, энэ нь “ёс зүйгүй явдал”-д тооцогддог байсан байна.

18 дугаар зууны сүүлээр цахиур буу аргагүй хоцрогдсон нь ойлгомжтой болсон бөгөөд 1798 онд Их Британи явган цэргийн армидаа зориулж Jaeger төрлийн Прусст үйлдвэрлэсэн таван мянган бууг захиалж, сүүлдээ британичууд иймэрхүү буу үйлдвэрлэж чаддаг болжээ.

Буучид санаачлага гаргаж, байлдааны хэвшмэл бус нөхцөлд ажиллах ёстой байвч тэд өнгөлөн далдлалтын урлаг хийгээд сумаа дээд зэргээр гамнах аргачлалд суралцжээ. Британичуудын буучдын арга ажиллагаа Францын Наполеоны дайны үеэр онцгой үр ашгаа өгсөн байна.

Тухайлбал, Британийн мэргэн бууч Томас Планкет генерал Кольберыг онож буудсан байна. Планкет Кольберыг хэвтээ байдалд буудсан нь сонирхол татдаг.

1830-аад оны эхээр цохилтод механизм бүхий хямд төсөр цахиур буунуудыг их хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой болсон байна.¹

19-р зууны сүүл үед Клоди Мини гэгч франц хүн анх конус буюу шовх үзүүртэй, цилиндр хэлбэртэй сумыг бүтээсэн байна. Сүүлд үүнийг Америкийн нэг зохион бүтээгч шинэчлэн бүтээсэн ба энэ нь хэдэн зуун газар нисэх боломжтой хөнгөн сум байжээ. Мөн Америкийн иргэний дайн нь галт зэвсгийн хөгжилд хурдасгуур болж өгсөн түүхтэй. Энэ үед цэргийн хэрэглэдэг байсан буу нь замагтай буу байсан ба үүнийг тухайн үеийн Америкийн зохион бүтээгч Кристофер Шарф бүтээжээ.

Бууны гох буюу хөшүүргийг хойш татахад замгийг дээш өргөнө. Энэ энгийн хэрэглээний бууг морьтон цэрэгт ашиглах болсон байна. Мөн 1840 оны үед Оливер Винчестэр гэгч англи хүн цамц үйлдвэрлэгч байсан хэдий ч үйлдвэрийн ажилчин Бенжамин Тайлор Хэнритэй хамтран олон жил хичээн зүтгэсний дүнд 44 калибр бууг бүтээсэн нь үр дүн өндөртэй, анхны давтаж бууддаг буу байсан байна.

Европын иргэний дайны үед галт зэвсгийн хөгжилд нэлээдгүй хөгжил гарсан байна. Дрейсн гэгч хүн түгжээтэй буу бүтээсэн

¹ <http://www.wikimon.mn/content/39284.shtml>



бөгөөд энэ нь одоогийн "30-06"-ын анхдагч хэлбэр байжээ.

АНУ энэ үед өндөр механикжсан бууны үйлдвэрлэлтээрээ дэлхийд тэргүүлэгч болсон байлаа. Чухам энэ л цаг үед Springfield, Harper's Ferry, Colt зэрэг буу үйлдвэрлэдэг компаниуд нэрд гарч эхэлсэн байна.

1850-аад он гэхэд дайн байлдаан хийдэг улс орнууд өөрсдийн армиудад цохилтод механизмын бууг нэвтрүүлсэн нь урьд өмнөх бууны төрлөөс 10 дахин их хол зайд буудах боломжтой болов.

1853 оны Өмнөд Африк дахь дайны үеэр Британийн буучид 1200 бээр буюу 1037 метрийн зайнаас дайснаа тогтоох чадвартай болжээ. Энэ нь яах аргагүй өндөр амжилт болж байв. Учир нь үүнээс хорьхон жилийн өмнө явган цэрэг 200 бээрийн зайд /182.8 метр/ өөрийгөө аюулгүй байдалд байгааг мэдэрдэг байлаа.

Крымийн дайн /1853-1855 он/ холын зайд бууддаг байлдааны зэвсгийн хөгжлийн хувьд шинэ үе шат нь болжээ. Алсын байлдааны зэвсгүүд нь иргэний дайны үеэс эхлэн АНУ-д үндсэн зэвсэг болон хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд ихэнх байлдааны үйлдвэрүүд нь зүүнтэнүүдийн мэдэлд байжээ.

Шинэ үеийнхний зэвсгийн үр ашгийг шалгаж үзэх боломж нь 1899-1902 оны хооронд Англи-Бурын хоорондын дайны үеэр болжээ. Чухам тэд л хамгийн түрүүн цөөн тооны, энд тэндгүй тархсан, өндөр ур чадвартай мэргэн буучид чанартай буутай байхад дайсны армитай тулалдаж чадна гэдгээ харуулсан юм.

Бурчууд²¹⁾ нь урт сахалтай, толгойдоо бараан ногоон өнгийн алчуур боож маш сайн өнгөлөн далдлалт хийж байсан нь британичуудын хувьд тун ч хүндрэлтэй байсан бөгөөд Бурчуудын толгойн энэ хэрэглэл хожим, XX зууны мэргэн буучдын дунд түгээмэл болсон байна.

Гэвч Иргэний дайныг дуусах үед АНУ дахь буудлагын урлаг ахин мартагдаж, 1900 он гээд дэлхийн ихэнх улс орнууд шинэ шүршдэг винтов буутай болсон байна. Тэр үед Mauser, Krag, Mannlicher, Enfield, Schmidt-Rubin гэх зэрэг 2000 бээрийн цаанаас буудаж чаддаг, зэвсэг үйлдвэрлэдэг олон компаниуд үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

Ж.Кеннедийн төрийн эрхэнд байх үеийн Америкчуудын оролцсон Вьетнамын дайнд тэд одоогийн M-14 загварын бууг хэрэглэж байжээ. M14 нь M-1-ийн сайжруулсан хувилбар бөгөөд хийн ажиллагаатай буу

² Бурчууд гэдэг нь Өмнөд Африкт амьдардаг Нидерландаас гаралтай хүмүүсийг хэлдэг байсан байна.

юм.

Дайны үеийн түүхээс харахад ялангуяа Вьетнамд цэргийн хатуу дэглэмт, хүнд сурталтай захирагчид нь цэргүүдийг өөрсдийн зэр зэвсгийг өөрсдөө өөрчлөн сайжруулахыг шаарддаг байсан байна. Цэргүүдийн хамтдаа сайжруулан бүтээсэн зэвсэг нь 50-ийн хүрэн бүстэй машин буу байсан бөгөөд энэ нь дэлхийн 2-р дайн болоод Солонгосын дайнуудад хэрэглэгдэж байжээ. Энэ бууг танкны орой хэсэг дээр, мустанг 51 нисэх онгоцны далавч дээр байрлуулан хэрэглэхээс гадна нисэж буй онгоцны эсрэг зэвсгээр тус тус хэрэглэдэг байсан ба хүнд жинтэй, хол зайд тохирсон буу байсан байна. Мөн бууг буудахад 2 туслах шаардлагатай бөгөөд явган цэргийг дэмжихэд нэлээдгүй ашиглагддаг байжээ.

Түүнчлэн 600 ярд хүртэл газарт /550м/ саадгүй буудах бөгөөд бэхлэлт цайзыг буулгахад хэрэглэдэг байжээ. Энэ бууг бүтээсэн эзэн нь тодорхойгүй боловч Вьетнамын дайны үед бууг мэргэн буудахад тохиромжтой болгон сайжруулсан түүхтэй ажээ. Энэ загвар нь /BMG/ хуяглагдаагүй болон нимгэн хуягласан дайсны эсрэг хэрэглэхэд маш үр дүнтэй байсан бөгөөд үүнийг хэрэглэж, явуулсан олон ажиллагаанууд баримттай, бүртгэлтэй байдаг байна.

M-16 болон AR-15 буунууд дайны үед хэрэглэгддэггүй байсан ч тэр үеэс өнөөг хүртэл боловсронгуй болсоор ирсэн байна. Хот, суурингийн нөхцөлд .300 magnum болон 50 калибр гэх мэтийн хүч чадал ихтэй урт буунууд тэр болгон хэрэглэгдээд байдаггүй. Мөн 308 буу нь ихэнх тохиолдолд ашиггүй зэвсэг гэгддэг. Цэрэг байлдааны зориулалттай зэр зэвсгүүд хууль сахиулах ажиллагаанд хэрэглэгддэг, тусгай албаны ажилтнууд зэвсгийг сайн эзэмшсэн байдаг.

Хууль сахиулагч нь цэргийн алба үүсэн байгуулагдсанаас эхлэлтэй бөгөөд арми бүхий хүчирхэг улс гүрнүүдийн түүхээс харахад хууль сахиулагчийн үндсэн зарчим нь дотоодын гэмт явдлын эсрэг тэмцдэг бөгөөд өөрийн улсын хууль тогтоомжийг зөрчсөн этгээд рүү гал нээдэг.

Энэ зарчим нь тухайн үеийн зэр зэвсгийн хязгаарлагдмал байдал болон хууль дүрмийн дагуу үйлдэгдэх хандлагатай холбоотой байжээ. Харин галт зэвсэг бий болсноор хууль сахиулагчид, гэмт этгээдүүд янз бүрийн зайнаас гал нээх боломжтой болсон байна.

Дайн байлдааны түүхээс харахад зэвсгийн хөгжил нь тухайн үеийн зэр зэвсэг



болоод тактикийн өөрчлөлт, хувьслаар тодорхойлогддог. Дайн, хууль сахиулах ажиллагаанд гэмт этгээдтэй тэмцэхэд тэнцүү боломж олгохгүй байх гол зарчим байдаг. Үндсэн зорилт бол гэмт этгээдэд боломж гаргахгүй, аль чадах хурдан хугацаанд буулган авах явдал юм.

Гар дээрээс буудах галт зэвсэг бий болсон цаг үеэс, цэрэг, дайчид нэг бүрийн зэвсэг болж, оновчтой, зөв, аюулгүй хэрэглэхийн тулд дайчдыг бэлдэх, богино хугацаанд сургаж, дадлагажуулах үүргийг бүх шатны дарга нарын хариуцсан үүрэг болж ирсэн.

Дайн тулаанд болон дайн бүхий байдалд галт зэвсгээр буудах сургалтыг гурван хэсэгт хуваан авч үзэж болох юм. Үүнд:

1. Тайван цагт цэргийн алба хааж, галт зэвсэг хэрэглэх сургалтад хамрагдан сурах.

2. Дайн бүхий байдалд хариуцсан дарга, бага дарга нар шинэ цэргүүдийг богино хугацаанд дадлагажуулж сургах.

3. Дайн байлдааны үед тулааны талбарт шинэ цэргүүдийг оролцуулах ба энэ үед цэргүүд бие даан суралцах эсхүл туршлагатай хуучин цэрэгт дагалдан өндөр эрсдэлийн дор, маш богино хугацаанд галт зэвсгээ ашиглан дайн тулааны орчинд суралцах гэсэн үндсэн хэсгүүдэд ангилагдана.

Дэлхийн ихэнх улс орнуудад цэргийн алба хааж буй хугацаат болон хугацаагүй цэргийн алба хаагчдын галт зэвсгийн сургалт нь эхлээд тухайн галт зэвсгийн талаар онолын мэдлэг өгөх ба үүнд, ямар нэртэй, хүчин чадал, ажиллагааны зарчим, сум, цэвэрлэж, тослох зэргийг заах ба хамгийн гол нь аюулгүй ажиллагааны зарчмыг ойлгуулах нь онолын сургалтад гол байр суурь эзэлдэг байна.

Онолын мэдлэг авсан алба хаагчдад дадлага сургалтыг хийлгэнэ. Эхлээд тодорхой зайнуудад шагайврын болон гох буулгах, цэнэглэх дасгал хийх ба харилцан адилгүй хугацаанд дадлага хийсний дараа онцлог бүхий бай /хүн дүрс, мишок, шав бүхий бай гэх мэт/-г галт сумаар буудаж, сургагч багш үнэлэлт, дүгнэлт хийн алба хаагч нэг бүрд алдаа дутагдлыг нь заан зөвлөж дахин буудлага хийх замаар цааш үргэлжлэн буудах байрлалуудыг өөрчлөх ба тухайлбал, хэвтээгээс суугаа байрлалд шилжинэ. Суугаа босоо байрлалд шилжинэ, босоогоор урагшаа, баруун, зүүн хажуу тийш шилжилтэй буудалт хийх, янз бүрийн сааднаас болон түүний араас буудах зэрэг сургалт дадлагыг байнга хийдэг ба эдгээрийг ерөнхий цэргийн командлагчийн байлдааны тактиктэй уялдуулан хийнэ.

Дайн бүхий байдал болон дайн байлдаанд бэлдэх үед цэргийн алба хаагчийг бэлтгэхдээ ялангуяа шинэ цэргийг бэлтгэхэд хариуцсан салаан дарга, дэд дарга нар өөрийн гараар зааж сургах, дадлагажуулах нь зайлшгүй ба хуучин цэрэг /хашир туршлагатай дайчид/-д богино, эрчимжүүлсэн сургалтын дараа даалган өгөх тэдгээрт галт зэвсгийн онолын болон практик дадлагыг зааж сургах үүргийг оногдуулдаг байна.

Дайн тулааны үед ихэвчлэн шинэ цэргүүд галт зэвсгийн сургалтад хамрагдаагүйн улмаас эрсдэх явдал олон гарч байсныг түүх бэлхнээ өгүүлнэ. Дэлхийн хоёрдугаар дайнд сайтар бэлтгэгдсэн Фашист Германы армийн эсрэг зогсож байсан улс орнууд тэр дундаа Зөвлөлт холбоот улс стратегийн ач холбогдол бүхий түшиц хотуудын тулаанд шинэ цэргүүдийг ямар ч галт зэвсгийн сургалт, дадлагагүйгээр тулаанд оруулж байсан баримт бий. Энэ нь тухайн үед зэр зэвсгийн нөөц хомс, цаг хугацааны хувьд давчуу, цэргийн алба хаагчийг бэлтгэх боломжгүй болон сургагч багш хүрэлцээгүй зэрэг шалтгаанаар асар их хохирол үзсэн. Амьд гарсан дайчид нь дайны талбарт суралцсанаар хариу үйлдэл үзүүлэх, цаашлаад мэргэжлийн, хашир туршлагатай дайчид болж байсан байна.

Мөн ойрын баримт бол 1990-ээд оны ОХУ, ЧБНУ хоёрын дайн юм. Энэ дайны үеэр Чечений тал олон тооны мэргэн буудагчдыг хөлслөн байлдаж, Эх орны дайны үеэс орхигдуулаад байсан Оросын талын мэргэн буудагчид эгэл жирийн жагсаалын цэргийн нэгэн адил деграм /дүрэм бусаар цэргийн алба хаагчийг залхаан цээрлүүлэх, шийтгэх/-д хариуцсан дарга, ахлагч нар зодох байдлаар явагдаж үндсэн үүрэг болох сургалт дадлагыг хийлэгддэггүй байсан байдал нь дээрх дайны үед буугаа харж, барьж, буудаж үзээгүй /СВД Драгуновын мэргэн буудагчийн винтов/ цэргийн алба хаагч нар олноор амь насаа алдаж байсан ба нөгөө хэсэг амь гарагсад нь дайны талбарт эсрэг талаасаа суралцан дайтаж байсан юм.

Энэхүү нөхцөл байдалд удирдлагууд суралцаж, дүгнэлт хийж шинээр онол, практикийн сургалтыг эсрэг тал болох барууны улс орнууд болон АНУ-аас мэргэн буудагчийн сургалтын хөтөлбөр, сургалтын арга барил зэрэгт дүн шинжилгээ хийж өөрсдийн цэрэг, цагдаагийн сургалтыг бий болгож мэргэжилтэн сургагч багш нарыг олноор бий болгон ашиглаж сурган уйгагүй бэлдсэний үндсэн дээр өнөөдөр дэлхийн тавцанд тэргүүлэх байр суурийг богино



хугацаанд эзлэн авсан байна.

Дээрх түүхээс харахад цэрэг дайны хажуугаар дотоодын дайсан, террористууд, гэмт бүлэглэл, гэмт хэрэгтэнтэй тэмцэх байгууллага болох дэлхий нийтээр хууль сахиулах гэсэн ерөнхий нэрэн доор багтах цагдаа, шүүхийн алба, хорих байгууллага, дотоодыг аюулаас хамгаалах алба, гал сөнөөгчид, хилийн алба гэх улс орон бүрт өөрсдийн нэршлээр хэлэгдэх эдгээр албадын алба хаагчид тус тусын чиг үүргийн дагуу галт зэвсэг хэрэглэж байгаа билээ.

Галт зэвсэг хэрэглэх хууль эрх зүйн болон дүрэм журмын дагуу явагдах арга хэмжээ, хууль сахиулагчдыг сургах нэгж, байгууллага нь голлох онцлог байгууллага болоод байна.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг бэлддэг сургалтын байгууллагууд нь улс болгонд өөр өөрсдийн онцлогтой бөгөөд сургалтад галт зэвсгийн бэлтгэл нь цагийн болон заах арга нь харилцан адилгүй, нэгээс нөгөө нь суралцах, ач холбогдол бүхий сургалтын төрлийг нэвтрүүлэх зарчмаар явагддаг ба хөтөлбөрийн хувьд энэ сургалт нь бодлогоор заагддаг байна. Тухайлбал, бэлтгэл анги буюу нэгдүгээр дамжаанд онолын суурь буюу ямар ч төрлийн галт зэвсэгтэй аюулгүй харьцах дадлага зонхилон орно. Дараагийн шат буюу хоёрдугаар дамжаанд мэргэжлийн суурь хичээлээс гадна галт зэвсгийн сургалтын үндсэн хэв маяг бүхий сургалт орж эхэлнэ. Дараагийн шат буюу гуравдугаар дамжаанд мэргэшлийн суурь хичээлд хууль сахиулах албанд ашиглагддаг төрөл бүрийн галт зэвсгүүдээр /улс орон бүрийн хууль сахиулах байгууллагуудад хэрэглэдэг гар буу, автомат буу, мэргэн буудагчийн буу гэх мэт/ янз бүрийн байрлалуудаас буудах тухайлбал, хэвтээгээс тулгууртай, тулгуургүй, суугаагаас тулгууртай, тулгуургүй, зогсоогоос тулгууртай болон тулгуургүй гэх мэт. Дараагийн шатанд буюу дөрөвдүгээр дамжаанд мэргэшүүлсэн суурь хичээлээр төрөл бүрийн саадны араас буудах, явж буй авто тээврийн хэрэгсэл дотроос буудах гэх мэт ерөнхий суурь зарчмыг баримталдаг. Энэ зарчмыг барууны орнууд /Европын холбооны улс/, ОХУ, Хойд Америк зэрэг улсууд барьдаг ба яагаад галт зэвсгийн хичээл дамжаа болгонд үе шаттайгаар ордог шалтгаан нь гараар буудагдах галт зэвсгийг онол, практикаар хязгаарлахгүйгээр, хүний рефлексийн төвшинд сургах дадал болгоход гол үндэс нь оршиж байдаг.

Олон зуун жилийн газар нутгийн төлөөх

дайн байлдаан, шашин шүтлэг, улс төрийн болон геополитикийн зөрчилдөөнд, хямралт байдлын хүрээнд хууль сахиулах алба хаагчдад зайлшгүй, салшгүй байх хэрэгсэл нь галт зэвсэг болж байна. Нөгөө талаар их гүрнүүдийн /АНУ, ИБУИНВУ, ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНЭУ, Иран гэх мэт/ болон зарим улс орнууд /Израиль, Швед, БНАСАУ, БНСУ, БНЧУ, Казахстан/-ийн төрийн хар хайрцгийн бодлогоор иргэн бүр цэргийн алба хаасан байх ёстой гэдгийн гол агуулга нь галт зэвсгийн бэлтгэлжилт, эзэмшсэн байдал зэргийг хамруулж ойлгож болно.

Иймээс аливаа улс үндэстэн өөрийн батлан хамгаалах суурь болдог, галт зэвсгийг хэрэглэх нарийн арга зүйд суралцсанаар сахилга баттай, өөртөө итгэлтэй, эх орондоо итгэл төгс иргэн болох үндэс нь болж өгдөг байна.

Харин одоо манай улс орны хувьд хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг хэрхэн бэлддэг талаар сонирхоод үзье. Алба хаагч нар галт зэвсгийн талаар хэр мэдлэгтэй вэ? Хэр эзэмшсэн бэ? Галт зэвсгийн аюулгүй байдлын мэдлэг ямар хэмжээнд байна вэ? Дайн бүхий байдал бий болбол яах вэ? гэх олон асуултад бид бэлэн үү? Гэнэтийн байдлаар танд хууль сахиулах байгууллагын хэмжээнд өнөөдөр ашиглагддаг аль нэг галт зэвсгийг удирдлагаас өгвөл яах вэ? Би мэдэхгүй гээд хаяад зугтах уу? энэ асуудлаар дийлэнх алба хаагчдын мэдлэг, чадвар хомс байна.

Товчхондоо цэргийн хүн сурах ёстой, сурснаа дадал болгох ёстой. Өнөөдөр бид хууль сахиулах байгууллагын алба хаагч, нөгөө талаар улс эх орноо дотооддоо хамгаалах “цэргийн хүн”, тийм болохоор цэрэг хүн галт зэвсэг хэрэглээд хүний амь насыг хамгаална. Зайлшгүй шаардлага гарвал хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг хэрэглэж болно.

Ингээд үзэхээр бидний галт зэвсэг хэрэглэх мэдлэг, чадвар олгох сургалт хэр төвшинд байгааг та бид дотроо нэгийг бодсон биз.

Өнөөдөр манай улсад энэ талаар хар хайрцагны бодлого гэж алга галт зэвсгийн сургалт нь өөрөө өндөр эрсдэлтэй, өртөг их, цаг хугацааг баггүй зарцуулдаг, давтамж шаардагдсан учир бид энэ бүгдээс шантралгүйгээр хууль сахиулах байгууллагын бүх алба хаагчдыг тогтмол галт зэвсгийн талаарх дадлага сургалтыг зохион явуулж, үр дүнг тухайн албадын дарга, сургагч багш нар нэгтгэн үндэсний аюулгүй байдлын



зөвлөлд хүргүүлэн танилцуулах, дүн шинжилгээ хийлгэн цаашдын төлөвлөгөөг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдыг бэлддэг Хууль сахиулахын их сургуулийн хувьд дүгнэлт хийж шинээр бэлтгэж буй хууль сахиулагчдын галт зэвсгийн сургалтыг эргэн харж, шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байгааг анхаарах хэрэгтэй байна.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГ

Р.Очирбал

Отгонтэнгэр их сургуулийн багш

Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн болохын хувьд төрийн байгуулалын тогтолцоонд чухал байр суурь эзлэх хэдий ч түүний чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээ, хязгаарыг хэрхэн оновчтой тогтоох асуудал онол, үзэл баримтлалын маргааныг дагуулсаар өнөөг хүрсэн. Ялангуяа Парламентын Бүгд Найрамдах төрийн засаглалтай манай улсын хувьд Улсын Их Хурал хийгээд Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны харилцан хамаарлыг тайлбарлах асуудал шийдвэртэй бодлого, үр дүнтэй зохицуулалтыг шаардаж байна. Эдгээрийн дотроос Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт хориг тавих талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал чухлаар тавигдаж байгааг онцлон энэ талаарх сэдэмж бичгийг уншигч танаа толилуулж байна.

Ерөнхийлөгчийн хориг, түүний эрх зүйн зохицуулалтанд чухалчлан судалвал зохих онол үзэл баримтлалыг тодруулах, Ерөнхийлөгчийн хоригийн талаарх эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэхэд энэхүү сэдэмж бичиг нь өөрийн оршихуйн үүргийг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна.

Нэг.Ерөнхийлөгчийн хоригийн талаарх онол, үзэл баримтлалын тухайд

Ерөнхийлөгчийн хориг нь зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийг хамгаалах хэрэгсэл болоод зогсохгүй зохисгүй хууль батлагдах явдлаас урьдчилан сэргийлэх нэмэлт хамгаалалт юм. Парламентаас баталсан нийтийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулахуйц, нийгмийн зөрчилт байдлыг өөгшүүлсэн, хуумгай хуулийг сайтар шалгах нөхцлийг Ерөнхийлөгчийн хориг бидэнд олгодог.

Александр Хамилтон¹

Төрийн эрх мэдлийн байгууллага хоорондын зохист харьцааг бий болгох замаар хяналттай, хариуцлагатай төрийг бий болгох нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн төр улсын эрхэм зорилгын нэг билээ. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Парламент хадгалах хэдий ч энэ нь тэрээр

эрх зүйт ёсыг алдагдуулсан, Үндсэн хуулийг зөрчсөн, шударга бус хуулийг батлан гаргана гэсэн хязгааргүй, хяналтгүй эрх дарх хараахан биш ээ. Парламентаас хууль тогтоох эрх мэдлээ хэтрүүлэн хэрэгжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд Ерөнхийлөгчийн хориг бий болсон хэмээн дэлхийн түүхэнд Ерөнхийлөгчийн хоригийг анхлан бий болгосон АНУ-ын судлаачид үзэж байна.²

Ийнхүү Парламентын баталсан хууль, бусад шийдвэрт хориг тавих эрхийг Ерөнхийлөгчид олгосон нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу эрх мэдлийн байгууллагууд харилцан бие биедээ зүй ёсны хяналт тавих үзэл санаанаас улбаатай. Ерөнхийлөгчийн хориг нь хууль тогтоох байгууллагын шийдвэрт тавих Үндсэн хуулийн хяналтын нэг төрөл бөгөөд Ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллага хоорондын харилцааны тулгуур нь хориг тавих бүрэн эрх хэмээн тодорхойлж байна.³ Тийм ч учраас Хууль тогтоох байгууллагын чиг үүрэг нь хууль батлах бол Ерөнхийлөгчийн чиг үүрэг нь хуульд хориг тавих явдал хэмээн зарим эрдэмтэд тодорхойлсон⁴ нь хэтрүүлэн биш бололтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 зүйлийн 33.1.1-д Монгол улсын Ерөнхийлөгч нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрхтэй хэмээн заасан. Ерөнхийлөгчийн хориг нь хууль тогтоох байгууллагад ард түмний нэрийн өмнөөс хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх гол хэрэгсэл бөгөөд өөр ямар ч эрх мэдлийн байгууллагад хуулиар олгоогүй хүчтэй зэвсэг юм. Эрдэмтэн Роберт Спицер “Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрх бол угтаа ард түмний нэрийн өмнөөс тэдгээрийн нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор парламентын эсрэг ашиглах хүчтэй зэвсэг” хэмээн хэлжээ.⁵

Гэхдээ “хориг”, “хязгаарлалт” нь хяналтын утгыг илэрхийлэх хэдий ч хяналт бүр эрх зүйт ёс, шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хангах чин зорилготой байдаггүй нь зарим тохиолдолд Ерөнхийлөгчийн хоригийг үгүйсгэх, шүүмжлэхэд хүргэдэг. Монгол хэл бичгийн нэрт эрдэмтэн Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь хэмээх

² Паречина С.Г., *Институт президентства: История в современность*, 2003

³ Nicole L. Slezak, *The Presidential Veto: A Strategic Asset*, <http://cspc.nonprofitsoapbox.com>

⁴ Jong R. Lee, *Presidential Vetoes – Touchstone of American Presidency*, New York Press, 1988, p1

⁵ Robert J. Spitzer, *President and Congress – Executive Hegemony at the Crossroads of American Government*, Philadelphia, Temple University Press, 1993, p.70

¹ David W. Rohde, Dennis M. Simon, *Presidential Vetoes and Congressional Response: A Study of Institutional Conflict*, *American Journal of Political Science*, Vol.29. No 3, 1985, 397



бүтээлдээ “Хориг” хэмээх үгийн утгыг 1. “Хориул, хорио, саад хориг”, 2. “Бусдад муу санасан атгаг”⁶ хэмээн тайлбарласнаас үзвэл зарим тохиолдолд улс төрийн атгаг, хорон санааны үүднээс хоригийг ашиглах боломжтой юм. Ерөнхийлөгчийн хориг нь нэг талаас Улсын Их Хурлын шийдвэрт тавих Үндсэн хуульт ёсны хяналтын механизм, нөгөө талаас Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэлгүйгээр үгүйсгэх улс төрийн хийрхэл ч байж болно. Тиймээс Ерөнхийлөгч нь хууль тогтоох эрх мэдэлд нөлөөлөх эрх зүйн арга хэрэгсэл болох хориг тавих онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ уг бүрэн эрхийг олгох болсон Үндсэн хуулийн үндэслэлийг ягштал даган мөрдөх нь ихээхэн чухал юм.

Ерөнхийлөгчийн хориг нь хууль тогтоох ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх нэмэгдэл арга хэрэгсэл⁷, хууль бүтээх үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. АНУ-ын 34 дэх удаагийн Ерөнхийлөгч Д.Эйзенхауэр “Би бол хууль тогтоох ажиллагааны нэгээхэн хэсэг” хэмээн олны өмнө хэлсэн үгэндээ дурьдсан нь бий.⁸

Ардчилал болон сонгуулийн зөвлөгөө мэдээллийн олон улсын байгууллагаас / IDEA/ 2015 онд хэвлэн гаргасан товхимолд Ерөнхийлөгчийн хориг нь Үндсэн хуульт ёсыг хамгаалах, төрийн алдаатай бодлого, зохицуулалт, авилга зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх болон манлайллын хүчтэй хэрэгсэл⁹ хэмээн тодорхойлсон нь Ерөнхийлөгчийн хоригийн мөн чанарыг илтгэж байна.

Гэхдээ Ерөнхийлөгчийн хориг нь хууль тогтоох байгууллагаас Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явдлыг үгүйсгэх ёсгүй. Тийм ч учраас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээх авах эсэхийг хууль тогтоох байгууллага эцэслэн шийдвэрлэдэг нь нэгэнт тогтсон ойлголт юм. Болгар, Литви, Македон, Нигер, Перу, Португал, Тайван зэрэг улсад Парламентын гишүүдийн олонхи буюу 50%-иас дээш хувийн саналаар, харин Гурж, Польш, ОХУ, Украин, Сенегаль, Монгол зэрэг улсад парламентын гишүүдийн 2/3-ийн саналаар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэдэг.¹⁰

⁶ Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь, 1963, 694 дүгээр тал

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 162 дахь тал, Эмхтгэн хэлвүүлсэн ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол улс дахь төлөөлөгчийн газар

⁸ Паречина С.Г., *Институт президенства: История в современность*, 2003

⁹ Presidential Veto Powers, www.constitutionnet.org

¹⁰ Президентське вето в сучасних демократичних системах, Національний інстут стратегічних досліджень,

Ерөнхийлөгчөөс Парламенттай харилцахдаа өрсөлдөгчийн байр сууринаас хандах явдлаас урьдчилан сэргийлэх, хориг тавих бүрэн эрхээ хууль ёсны зорилгын үүднээс хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хориг тавихад удирдлага болгох хэд хэдэн зарчмыг тодорхойлсон нь улс орнуудад нийтлэг хэрэглэгдэж байна. Үүнд:

•Ерөнхийлөгч хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хоригоос үүдэн бий болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагаврыг бүрэн ухамсарлан, үйлдэлдээ бодитой, хариуцлагатай хандах шаардлагатай.¹¹ Ерөнхийлөгчийн хоригийг хууль тогтоох байгууллага хүлээн авах эсэхийг шийдвэрлэх зэргээр цаг хугацаа, ажлын ачаалал, хөрөнгө мөнгө шаардах болохыг Ерөнхийлөгч сайтар ухамсарлан хориг тавих бүрэн эрхээ хариуцлагатай хэрэгжүүлэх нь зүйд нийцнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг чуулганы үеэр 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хонгийн дотор хэлэлцэн нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийг гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээж аваагүй бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр үлдэхээр хуульчилснаас хоригийг үр дагаврыг харж болно. Хоригийг үнэ цэнэгүй хэрэглэх нь Ерөнхийлөгч өөрийн нэр хүнд, улс төрийн байр сууриа алдахад хүргэдэг.

•Ерөнхийлөгчийн хоригийн хууль зүйн үндэслэл нь ойлгомжтой, тодорхой байх нь түүнд тавигдах үндсэн шаардлага юм. Хоригийн хууль зүйн үндэслэл тодорхой байх нь хууль тогтоох байгууллагаас хоригийг хүлээн авах эсэх, түүнчлэн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хэлэлцэх, бодлого, шийдвэрээ шинжлэх ухаанч байдлаар эргэн нягтлан харахад чухал дэмжлэг болдог.

•Ерөнхийлөгч хориг тавих талаарх байр сууриа аль болох урьдчилан илэрхийлэх нь цаг хугацаа, ажлын ачааллыг ихээхэн хэмнэх сайн талтай.¹² Хэдийгээр хууль тогтоох байгууллагаас хуулийг хэрхэн батлахыг Ерөнхийлөгч бүхэлд нь таамаглах боломжгүй хэдий ч өөрийн байр суурийг урьдчилан тодорхой илэрхийлэх боломжтой. Монгол

Украин, www.niss.gov.ua

¹¹ James Gattuso, Reagan's Trump Card: The Veto, Heritage Foundation Backgrounder, 1985, p2

¹² James Gattuso, Reagan's Trump Card: The Veto, Heritage Foundation Backgrounder, 1985, p11



Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7-д “Ерөнхийлөгч хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлж болно. Энэ нь уул хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй” хэмээн заасан тул хуулийг албан ёсоор баталсаны дараа бус харин урьдчилан өөрийн саналаа илэрхийлэх боломж манай улсын хуульд хангалттай бэхжигдсэн байна.

•Ерөнхийлөгч хориг тавигдсан хуулийн зохицуулалтыг хэрхэн оновчтой, боловсронгуй болгох талаарх өөрийн саналыг илэрхийлэх нь хууль тогтоох байгууллагаас хоригийг авч хэлэлцэх, цаашлаад хуулийн заалтыг өөрчлөн батлахад ихээхэн дэмжлэг болно. Ерөнхийлөгч нь хууль тогтоох байгууллагаас баталсан шийдвэрийг өөрчлөх, түүнд нэмэлт оруулах эрхгүй хэдий ч хориг тавих замаар хуулийн зохицуулалтад нөлөөлөх, цаашлаад эрх зүйн эерэг үр нөлөө бүхий шинэчлэлийг бий болгох боломжтой байдаг.¹³

Ерөнхийлөгчийн хориг, түүний эрх зүйн зохицуулалт нь манай улсад харьцангуй шинэ үзэгдэл учир онолын судалгаа хангалттай бус байна. Харин ХХ зууны дунд үеэс эхлэн өрнийн улс орнуудад Ерөнхийлөгчийн хоригийг онол, үзэл баримтлалын түвшинд судлах томоохон оролдлогууд хийгдсэний үр дүнд Ерөнхийлөгчийн хоригийн үндсэн хэд хэдэн загвар бий болжээ. Эдгээрээс “Хоригийн үр дагавар наймаалцах”¹⁴ /Sequential veto bargaining theory/ болон “Буруутгах тоглоом” /Blame game theory/-ын онолуд нь нийтлэг түгээмэл хэрэглэгдэж байна.

Буруутгах тоглоомын онолоор хууль тогтоогч өөрийн батлан гаргасан хууль, бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавина гэдгийг урьдаас таамаглаж, мэдсээр атлаа Ерөнхийлөгчийн эсэргүүцэх хуулийг батлан гаргаж түүнийг улс төрийн дайсгасан харилцаанд өдөөн хатгадаг. Хууль тогтоох байгууллага болон Ерөнхийлөгч нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг хуулиар хэрхэн зохицуулах талаар харилцан адилгүй бодлого, байр суурийг баримтлаж байгаа үед Ерөнхийлөгчийг сонгогчдын өмнө хэт нэг талыг баримталж байгаа мэтээр харагдуулж, улс төрийн нэр хүндийн унагаах

¹³ The Presidential Veto and Congressional Veto Override Process, Center for Legislative Archives, www.archives.gov/legislative

¹⁴ Уг онолыг АНУ-ын эрдэмтэн Чарлз Камерон боловсруулсан бөгөөд тэрээр 1945-1992 он хүртэлх онуудад тавигдсан Ерөнхийлөгчийн 434 хоригт эмпирик түвшинд судалгаа хийсний үндсэн дээр дээрх загварыг боловсруулсан.

зорилгоор хууль тогтоогч санаатайгаар хориг тавихуйц хуулийг батлан гаргадаг. Уг харилцаанд Хууль тогтоогч, Ерөнхийлөгч гэсэн хоёр тал оролцож байгаа мэт боловч үнэндээ иргэд буюу сонгогчид харилцааны гуравдагч тал болдог. Ерөнхийлөгч хууль тогтоогчийн батлан гаргах хуульд хориг тавибал хэт радикал буюу туйлширсан болж сонгогчдын өмнө харагдах бол, хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй бол тэрээр өөрийн байр сууриас ялгаатай хэдий ч хууль тогтоогчийн батлан гаргасан хуулийг дэмжихэд хүргэдэг. Энэ утгаараа Ерөнхийлөгч хуульд хориг тавьсан ч, эс тавьсан ч түүнд ямар ч ашигтай үр дүн бий болдоггүй, харин хууль тогтоогч өөрт ашигтай хуулиа баталж чаддаг. Хууль тогтоох байгууллага болон Ерөнхийлөгч нь нэг нам, эвслээс сонгогдсон тохиолдолд уг загварыг бараг хэрэглэдэггүй бол өрсөлдөгч нам, эвслээс сонгогдсон тохиолдолд улс төрийн зорилгоор олонтаа хэрэглэдэг.¹⁵

Харин Ерөнхийлөгчийн хоригийн наймаалцах онол нь улс төрийн болон хууль зүйн шинжлэх ухаанд хамгийн ихээр судлагдсан дэлхийн улс орнуудад өргөн хэрэглэгддэг загвар бөгөөд хууль тогтоогч нь түүний батлан гаргасан хуулийг Ерөнхийлөгч хэрхэх талаар хангалттай мэдээлэлгүйгээр, эсхүл хориг тавих эсэхийг мэдэхгүйгээр хуулийг баталдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл “ав эсхүл боль” гэсэн энгийн зарчимд тулгуурладаг. /take-it-or-leave-it/. Уг загварын үед улс төрийн тоглолт гэхээсээ илүү бодит байдалд үндэслэн Ерөнхийлөгч хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.¹⁶

Монгол Улсын Ерөнхийлөгч нь хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэггүй тул Ерөнхийлөгчийн хориг тавих эрх нь наймаалцах онолын дагуу хэрэгжиж байна. Гэхдээ Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн бодлого, зохицуулалтын эрс ялгаатай байгаа үед буруутгах тоглоомын онол хэрэгжиж болохыг үгүйсгэхгүй. Хоригийн дээрх загварууд нь харьцангуй шинэ боловч онол, үзэл баримтлалын хувьд ихээхэн дэмжигдэж, зарим тохиолдолд өргөн хүрээний маргааныг бий болгож байгаа учир цаашид нарийвчлан судлах шаардлагатай судлагдахуун юм.

Дэлхийн улс орнуудад Ерөнхийлөгчийн хоригийг бүрэн, хэсэгчилсэн, түүвэр, халаасны гэх зэргээр ангилдаг бөгөөд энэ

¹⁵ Charles M. Cameron, Presidential Veto, www.princeton.edu

¹⁶ John B. Gilmour, Sequential Veto Bargaining and Blame Game Politics as Explanations of Presidential Vetoes, www.jbgilm.people.wm.edu



талаар Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан нар “Парламентат ёс” хэмээх бүтээлдээ бичсэн тул агуулга, үзэл санааг тайлбарлах нь илүүц хэмээн үзлээ.

Хоёр. Ерөнхийлөгчийн хоригийн талаарх Монгол улсын эрх зүйн зохицуулалт, цаашид анхаарах асуудлын тухайд

Манай улсад Ерөнхийлөгчийн хоригийн талаарх харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тус тус зохицуулж байгаа бөгөөд Ерөнхийлөгчийн хориг нь хууль бүтээх үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг гэдэгтэй маргах хүн үгүй бизээ.

1993-2015 он хүртэлх 22 жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нийт 57 удаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавьж байсан бөгөөд Ерөнхийлөгч П.Очирбат 9 удаа, Ерөнхийлөгч Н.Багабанди 32 удаа, Н.Энхбаяр 9 удаа, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 7 удаа тус тус хориг тавьж байжээ. 2001, 2011, 2014 онуудад Ерөнхийлөгч хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй бол 1998 онд нийт 8 удаа, 2000 онд 5 удаа, 2002 онд 6 удаа, 1997, 2003, 2005, 2008 онуудад тус бүр 4 удаа Ерөнхийлөгч УИХ-ын шийдвэрт хориг тавьж байжээ.

Хэдийгээр Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавих эрхтэй ч хоригийг хүлээн авах эсэхийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээн аваагүй бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр үйлчилдэг. Монгол улсын Ерөнхийлөгчийн тавьсан 36 хоригийг бүхэлд нь, 4 хоригийг хэсэгчлэн Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол үлдэх 12 хоригийг хүлээн аваагүй байна. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээн авсан байдлыг Ерөнхийлөгч тус бүрээр нэг бүрчлэн гаргахад Ерөнхийлөгч П.Очирбатын тавьсан 9 хоригийн 2-ийг бүхэлд нь хүлээн авсан бол 2 хоригийг хэсэгчлэн харин үлдсэн 5 хоригийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй байна. Харин Ерөнхийлөгч Н.Багабандийн тавьсан 32 хоригоос 20 хоригийг бүхэлд нь, 3 хоригийг хэсэгчлэн хүлээн авсан бол үлдэх 9 хоригийг хүлээн авах боломжгүй хэмээн шийдвэрлэжээ. Ерөнхийлөгч Н.Энхбаярын тавьсан 9 хоригийн 7 хоригийг бүхэлд нь хүлээн авч үлдэх 2 хоригийг бүхэлд нь хүлээн аваагүй бол одоогийн Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн тавьсан 6

хоригийн 1-ээс бусад хоригийг Улсын Их Хурал хүлээн авсан байна. Ерөнхийлөгчийн улс төрийн намын харъяалал, Улсын Их Хурал дахь улс төрийн намуудын авсан суудлын харьцаа, улс төрийн тогтворгүй байдал, ээлжит болон ээлжит бус сонгууль зэрэг нь Ерөнхийлөгчөөс хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөлдөг эсэх, цаашлаад дээрх байдал нь Улсын Их Хурлаас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлдөг эсэхийг судлах нь ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд ёсчилсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Улсын Их Хурлын Тамгын газар 24 цагийн дотор Ерөнхийлөгчийн тамгын газарт илгээх бөгөөд Ерөнхийлөгчийн тамгын газар хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтгаан Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэхийг шийдвэрлэхээр хуульчилсан. Харин хуульд заасан 5 хоног нь Ерөнхийлөгч хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хангалттай байж чадах уу гэсэн асуулыг бий болгож байна. Түүхэн зарим баримтуудыг судлан үзэхэд 1992.04.04-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын шийдвэрийг Ерөнхийлөгчид илгээнээс хойш тэрээр 72 цагийн дотор хориг тавих бүрэн эрхтэй байхаар хуульчилжээ. Дээрх зохицуулалт хүчин төгөлдөр үйлчлэх явцад хориг тавих 72 цагийн хугацааг хэрхэн тоолох асуудал ойлгомжгүй, маргаантай байсан учир 1994 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн тогтоолоор хуулийн заалтыг албан ёсоор тайлбарласан аж. Улсын Дээд шүүхээс хуулийн заалтыг албан ёсоор тайлбарласан хэдий ч хугацааг хэрхэн тоолох талаар УИХ болон Ерөнхийлөгч харилцан адилгүй байр суурьтай байсан нь эцэстээ Үндсэн хуулийн түвшний маргааныг бий болгож байсан нь Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 09 тоот дүгнэлтээс тодорхой харагдана.

Хууль тогтоогчийн батлан гаргасан хууль, бусад шийдвэрийг Ерөнхийлөгч хүлээн авсанаас хойш хэдий хэр хугацааны дотор хориг тавих эсэх асуудлыг хуульчлан зохицуулахдаа уг хугацаа нь нэг талаас Ерөнхийлөгч хориг тавих эсэхийг шийдвэрлэхэд хүрэлцэхүйц байх, нөгөө талаас хууль хүчин төгөлдөр болох үйл



ажиллагаанд саад, хүндрэл учруулахгүй байх нөхцлийг харгалзан үздэг. Зүүн Африкийн Бүгд Найрамдах Бенин улсад Ерөнхийлөгч хуулийг хүлээж авсанаас хойш ердийн тохиолдолд 15 хоногийн дотор, онцгой нөхцөлд 5 хоногийн дотор хориг тавих эсэхийг шийдвэрлэдэг бол Бүгд Найрамдах Коломб улсад хуулийн бичвэр буюу зүйл, заалтын их, багаас хамааран 6-20 хоногийн дотор хориг тавих асуудлыг шийдвэрлэхээр хуульчилжээ. АНУ-д 10 хоног, БНСУ-10 хоног, Украин улсад 10 хоног, БНХАУ-д 10 хоног, Кэни улсад 14 хоног, ОХУ-д 14 хоног¹⁷, Франц улсад 15 хоног, Бразил улсад 15 хоног, Украин улсад 15 хоног, Румин улсад 20 хоног, Польш улсад 21 хоног тус тус байгаагаас үзэхэд 10-21 хоногийн дотор Ерөнхийлөгч хориг тавих эсэхийг шийдвэрлэдэг нь улс орнуудад нийтлэг байна. Тиймээс Ерөнхийлөгч хориг тавих бүрэн эрхээ хууль зүйн үндэслэлтэй, хариуцлагатай, бодитой, шинжлэх ухаанч байдлаар хэрэгжүүлэх боломж олгох үүднээс хориг тавих хугацааг 7-14 хоног болгон өөрчлөх шаардлагатай хэмээн үзэж байна.

Ерөнхийлөгчийн хоригийн талаарх эрх зүйн зохицуулалтад анхаарах шаардлагатай өөр нэгэн асуудал нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.9 дэх хэсгийн “Үндсэн хуульд заасан онцгой байдал үүссэн, эсхүл Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаа өндөрлөхтэй холбогдуулан Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг энэ хуулийн 53.6-д зааснаас өөрөөр тогтоож болно” гэсэн заалт юм. Үндсэн хуульд заасан онцгой нөхцөл байдал үүссэн үед Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг богиносгон тогтоож болохыг үгүйсгэхгүй. Харин уг хугацааг хуулиар тогтоох уу? эсхүл Улсын Их Хурлаас тухай бүр тогтоох нь зохимжтой юу? Сонголт ямар ч байж болно. Харин Ерөнхийлөгчид хориг тавих хугацааг урьдчилан тооцоолох боломж олгох, нөгөөтэйгүүр хууль тогтоох байгууллагаас Ерөнхийлөгчийн хориг тавих боломжийг хязгаарлах оролдлогыг үгүйсгэх зорилгоор онцгой байдлын үед Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг хуулиар зохицуулах нь зүйтэй.

Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаа өндөрлөхтэй холбогдуулан Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг Улсын Их Хурлаас богиносгон тогтоох боломжтой байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар олгогдсон

¹⁷ Peter B. Maggs, Olga Schwarz, William Burnham, Law and Legal System of the Russian Federation, Sixth Edition, 2015, p273

Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх явдлыг хязгаарласан Үндсэн хуулийг зөрчсөн заалт хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Ийнхүү Ерөнхийлөгчийн хориг тавих боломжийг хугацаагаар хязгаарлах Парламентын элдэв оролдлогыг үгүйсгэх зорилгоор “Pocket Veto” буюу “халаасны хориг” үүсэн бий болсон түүхтэй. Зарим улсын жишээ дурьдахад: АНУ-ын түүхэн дэх 44 Ерөнхийлөгчийн 37 нь 1789 оноос хойш өнөөг хүртэл нийт 2566 удаа хориг тавьсан бөгөөд тэдгээрийн 1500 буюу 58.5 хувь нь ердийн хориг байсан бол үлдэх 1066 буюу 41.5 хувь нь халаасны хориг байжээ.¹⁸ Монгол Улсын Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй хэдий ч зарим тохиолдолд түүний тавьсан хориг хууль зүйн үр дагаврыг бий болгодоггүй. Хэрэв хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр Ерөнхийлөгч хориг тавьсан ч Улсын Их Хурал хоригийг хүлээж аваагүй тохиолдолд Ерөнхийлөгч Үндсэн хуулийн цэцэд хандан хүсэлт гаргах боломжтой. Хэдийгээр Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах замаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй хэдий ч энэхүү эрхээ хэрхэн ашиглаж байгаа нь анхаарал татаж байна. Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаас хойш өнөөг хүртэлх хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч 2 удаа хүсэлт гаргасан байна. /Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтээр 1993-02-12-ны өдөр Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйл заалт нь Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай, 1993-11-23-ны өдөр Байнгын хорооны дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолтой холбогдсон маргааныг хянан шийдвэрлэсэн/ Монгол Улсын Ерөнхийлөгч нь 1993-1994 онд Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаснаас хойш өнөөг хүртэл дахин хүсэлт гаргаагүй явдал нь тэрээр Үндсэн хуулиар олгогдсон энэхүү эрхээ ашиглахад хүчин чармайлт гаргахгүй байгаа гэсэн дүгнэлтийг өгөхөд хүргэж байна.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавих талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хязгаарлалт байх эсэх асуудал манай улсад эрх зүйн маргаантай асуудлыг үүсгэж байна. Хэдийгээр Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Ерөнхийлөгчийн хориг тавих эрхэд

¹⁸ Meghan M Stuessy, Regular Vetoes and Pocket Vetoes: In Brief, 2015, www.crs.gov



хязгаарлалт тогтоосон зохицуулалт байхгүй хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас гаргасан дүгнэлтийг хүлээн авах эсэх асуудлыг хэлэлцээд гаргасан Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд Ерөнхийлөгч хориг тавьсан явдал нь уг асуудлыг ул суурьтай судлах шаардлагыг бий болгож байна.

Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болох бөгөөд түүний шийдвэрийг ямар ч байгууллага үгүйсгэх, хууль зүйн үндэслэлтэй эсэхийг магадлан шалгах эрхгүй. Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаас гаргасан дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлэх бөгөөд тэрээр цэцийн дүгнэлтийг хүлээн авах, эс хүлээн авах эсэхийг шийдвэрлэхээс бус хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянан шалгах эрхгүй. Гэтэл Ерөнхийлөгчийн тавьсан хоригт Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хууль зүйн заавал биелэгдэх шинжийг үгүйсгэсэн зарим утга санаа агуулагдаж байгааг түүний агуулгаас тодорхой харж болно. Хэдийгээр Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавих эрхтэй хэдий ч Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авах эсэх асуудлаар гаргасан тогтоолд хориг тавих нь Үндсэн хуульд ёсыг алдагдуулсан, Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхэд халдсан, зохисгүй үйлдэл хэмээн үзэж байна. Учир нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авах асуудлаар гаргасан Улсын Их Хурлын тогтоол нь хууль тогтоох байгууллагын хүрээнд нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор батлан гаргасан заавал биелэгдэх шинжтэй тогтоолоос агуулга, чиг үүргийн хувьд ихээхэн ялгаатай хэмээн үзэж байна.

ДҮГНЭН ТЭМДЭГЛЭХЭД: Үндсэн хуулиар олгогдсон Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрх нь хяналттай, хариуцлагатай төрийн байгуулалыг бий болгоход чухал үр нөлөө бүхий Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны нэг хэсэг бөгөөд Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралтай харилцах харилцаанд эдлэх онцлог бүрэн эрх юм. Ерөнхийлөгчийн хориг нь нэг талаас Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ эдэлж хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс саад учруулж байгаа мэт боловч нөгөө талаас Үндсэн хуульд ёсыг хамгаалах, төрийн алдаатай бодлого, зохицуулалтыг засварлах үр нөлөө бүхий арга хэрэгсэл юм. Иймээс Ерөнхийлөгчийн хоригийн талаарх эрх зүйн зохицуулалтыг онолын хувьд нарийвчлан

судлах замаар өөрийн улсын эрх зүйн зохицуулалтыг цаашид төгөлдөржүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж байна.



ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Мөнгөннахиа

Санхүү эдийн засгийн дээд сургуулийн
Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш,
хууль зүйн магистр

Товч агуулга: “ХЭРЭГЛЭГЧ та ХААН” гэсэн лоозонг та аль ч үйлчилгээний байгууллагын танилцуулга, сурталчилгаа дээрээс харж болно. Хэрэглэгч та хаан гэх лоозон нь дэлхий даяар түгэн тархаж буй өнөөгийн нийгэмд хэрэглэгч гэж хэн болох, түүний язгуур эрх ашгийг хэрхэн хамгаалж, энэ талаар дотоодын хууль тогтоомждоо хэрхэн тусгаснаас хамаарч улс орны хөгжлийн түвшин тодорхойлогддог. Хэрэглэгч хаан гэж өргөмжлөх нь зүй ёсны асуудал бөгөөд хэрэглэгчгүйгээр ямар ч бизнес урагшлахгүй нь тодорхой юм. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн харилцаа нь бүхий л цаг үед нийгмийн хамгийн чухал тулгуур ойлголт болж иржээ. Тиймээс хэрэглэгчийн эрхийг хамгаалахад тулгамдаж буй асуудал нь хууль эрх зүйн орчинтойгоо хэрхэн уялдаж буй талаар дүн шинжилгээ хийх үүднээс энэхүү сэдвийг сонгон судлав. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль нь хэрэглэгчийн бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Мөн хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэн хамгаалах, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай хуульд тусгасан байдаг. Гэвч хэрэглэгчийн

эрхийг хамгаалах хууль, хууль эрх зүйн орчин нь хэрэглэгчийг хаан шиг эрхэмлэн, эрхийг нь зөрчихгүй байж чадаж байна уу? Монгол Улсын хууль тогтоомж хэрэглэгчийн эрхийг хамгаалахад хангалттай зохицуулалт хийж чадаж байна уу гэдэгт дотоодын хууль эрх зүйн орчин хийгээд гадаадын зарим улс орны туршлагыг судлан, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төр, засгийн цогц бодлого хэрэгтэй байгааг судалгааны ажлын үр дүнгээр илэрхийлэхийг зорьлоо.

Түлхүүр үг: Хэрэглэгч, хэрэглэгчийн эрх, хэрэглэгчийн эрх зүйн зохицуулалт, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар

Хэрэглэгч гэж хэн бэ?

Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1-д “хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг хэлнэ гэж томъёолсон байдаг. Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан “Бизнесийн эрх зүй” 2014 он., сурах бичигт: “хэрэглэгч гэж нэгдүгээрт, хүн бүрийг хэлэхгүй ба гагцхүү бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан худалдан авахаар захиалж гэрээ хэлцэл байгуулсан, үнийг төлсөн эсвэл урьдчилгаа мөнгийг өгсөн, ажил үйлчилгээ хүртсэн хувь хүнийг хэлж байгаа ойлголт юм. Хоёрдугаарт, бүх л төрлийн бараа, ажил, үйлчилгээ бас биш юм. Энэ нь зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээнд зориулагдсан байх ёстой юм”.¹ гэж тодорхойлсон байна.

Хэрэглэгчийн эрх зүй гэдэг нь иргэдийн материаллаг, соёлын болон бусад хэрэгцээг хангахад чиглэсэн харилцааг зохицуулж буй хэд хэдэн салбар эрх зүйгээс /захиргааны, иргэний, эрүүгийн гэх мэт/ бүрдсэн цогц эрх зүй юм. Хэрэглэгчийн эрх зүйн харилцааг манай орны хувьд 1990-ээд оноос эхлэн “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим”, “Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг” зэрэг эрх зүйн актуудаар баталгаажуулан, зохицуулж байна. Хэрэглэгчийн эрхийг “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах

¹ Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан “Бизнесийн эрх зүй”. УБ. 2014 он.



нийгэмлэг” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын түвшинд хамгаалж байна. Мөн сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалахад чиглэсэн бодитой ажлууд хийгдэж байгааг та бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонсож, анзаарч байгаа билээ.

Хэрэглэгчийн эрх нь хүний эрхийн хамгийн өргөн хүрээг хамаардаг бөгөөд бүх хүнд заяасан төрөлх эрхийн төрөл юм. Иймээс хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь төр, засгийн байгууллагын анхдагч үүрэг болохыг 1993 онд болсон Дэлхийн хүний эрхийн бага хурлаар баталсан Венийн тунхаглалд тодорхойлсон байдаг.

XX зууны 60-аад оноос эхлэн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хөдөлгөөн Америкийн нэгдсэн улсад хүчтэй өрнөж эхэлсэн буюу “Consumerism” гэдэг нэр томъёо нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэсэн агуулгаар хэрэглэгдэж иржээ.² 1962 оны 3-р сарын 15-ны өдөр Америкийн нэгдсэн улсын 35 дахь ерөнхийлөгч асан Дж.Кеннеди улсынхаа үндэсний эрх ашгийг хамгаалах үүднээс энгийн америк иргэн-хэрэглэгчийн эрхийг тэнцвэржүүлэн баталгаажуулж Америкийн хэрэглэгчийн үндсэн эрх болох аюулгүй байх, сонголт хийх, мэдээлэл авах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэрэглэгчийн боловсролын эрх хэмээх таван язгуур эрхүүдийг тунхагласан нь эдүгээ Хэрэглэгчийн олон улсын байгууллага /The consumers international/-ыг үүсгэн байгуулах суурь болсон төдийгүй НҮБ-ын 1985 онд баталсан “Хэрэглэгчийг хамгаалах дүрэм”-ийн эхлэл болжээ. 1960 онд үүсгэн байгуулагдсан Лондон хотод төвтэй олон улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах “Хэрэглэгчийн олон улсын байгууллага” болон 1972 онд байгуулагдсан Брюссель хотод төвтэй “Европын хэрэглэгчийн эрхийн байгууллага”-ууд нь идэвхтэй ажиллаж байна. Дэлхийн 2-р дайны дараагаас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн нь баруун европын орнуудад хүчээ авсан ба Их британи, Герман, Швед зэрэг орнуудад өрнөсөн. Европд анх 1954 онд Нидерландад “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбоо”, Англид 1975 онд “Их Британийн хэрэглэгчийн үндэсний зөвлөл”, 1978 онд Финляндад хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллага тус тус байгуулагджээ. Оросын Холбооны Улсад 1980-аад оны дунд үеэс хэрэглэгчийн

эрхийг хамгаалах нийгэмлэг, холбоод байгуулагдсан байна.

Үүнээс харахад хөгжингүй орнуудад хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, холбоод эртнээс үүссэний сацуу хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр төрөл бүрийн хэрэглэгчийн нэвтрүүлэг явагддаг. Үүнийгээ дагаад хэрэглэгч гэж хэн байх, хэрэглэгчийн эрхийг хэрхэн хамгаалах тухай эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй болсоор ирсэн гэж ойлгож болно.

1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт

Монгол Улс хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг 1991 онд баталж, 1992 онд Монгол Улсын Засгийн Газар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас сайшаан дэмжсэн “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим”-ыг хүлээн зөвшөөрч, “Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг”-ийг 1993 онд батлан гаргажээ. 2003 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан ба 2008 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Харин 2009 онд Монгол Улсын Засгийн Газраас Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлжээ.

Одоогоор Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 500 гаруй хууль байгаагаас хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой 30 орчим хууль, эрх зүйн акт үйлчилж байна. Энэ дотроос хэрэглэгчийн хууль ёсны язгуур эрх ашиг /аюулгүй байх, сонголт хийх, мэдээлэл авах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэрэглэгчийн боловсролын эрх/-ийг хамгаалах зорилго бүхий дараах хууль тогтоомжууд байна. Үүнд: Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, иргэний хууль, эрүүгийн хууль ... Түүнчлэн Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.2 дахь хэсэгт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй³ гэж заажээ. Мөн Монгол Улсын үндсэн хуулийн 10-р зүйлийн 10.3-т Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль

² <http://en.wikipedia.org/wiki/Consumerism>

³ Төрийн мэдээлэл эмхтгэл №1



тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ ⁴ гэж заасан нь “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт”, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” нь манай улсын хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ гэсэн үг юм. Дээрх хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцоор хэрэглэгчийн эрхийг хамгаалах, эрх зүйн орчинг зохицуулж байна. Үндсэн хуульдаа хэрэглэгчийн эрхийг баталгаажуулж, хангахаар зааж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульдаа энэ тухай нарийвчлан зохицуулсан боловч хэрэглэгчээс авсан судалгааг харахад,

Хэрэглэгчийн эрхийн тухай ойлголтыг

тамхинд бие эрхтэн, оюун санааны хувьд бүрэн донтсон байна. Түүний эхнэр болон хүүхдүүд тамхины улмаас хүний бие махбодод ямар сөрөг үр дагавар учирч болохыг түүнд ойлгуулж, түүнийг тамхинаас гаргах гэж идэвхтэй оролдсон ч оролдлого бүр бүтэлгүйтжээ. Филип Морисс компани өөрийн зар сурталчилгаагаар Марлборо тамхи нь бусад шүүлтүүргүй тамхийг бодвол хүний биед сөрөг үр дагаваргүй, уушгины хорт хавдраас айх хэрэггүй хэмээн олон нийтэд танилцуулсан учир Жесси Виллиамс “Филип Морисс” компанийн хүний бие махбодод хортой бүтээгдэхүүн худалдаалахгүй гэдэгт бүрэн итгэдэг байсан



бага зэрэг мэднэ, муу мэднэ, огт мэдэхгүй гэх хариултууд байгаа нь хэрэглэгчид эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, эрх нь зөрчигдсөн буюу хохирол учирсан тохиолдолд хаана, хэрхэн хандахаа мэдэлгүй хохироод үлддэг гэж харж болохоор байна. Мөн ШӨХТГ-т ирсэн өргөдөл гомдлыг ангилж үзвэл барилга, орон сууц, СӨХ, банк, харилцаа холбооны салбаруудад иргэдийн гомдол зонхилж байгаа бол 2014 онд нийт 2569 өргөдөл, гомдол хүлээн авсны 60% нь хэрэглэгчийн эрхтэй холбоотой гомдол, 25% нь барилга, орон сууцны / метр квадратны зөрүү/ асуудлаар гаргасан байгаа нь дээрх салбаруудад хэрэглэгчийн эрх илүүтэйгээр зөрчигдөж байна. Эндээс 60% нь хэрэглэгчийн эрхтэй холбоотой гомдол байдаг гэж харахад энэ талын хэрэглэгчийн эрх нэлээд зөрчигдөж байна гэж хэлж болохоор байна. Тэгвэл хэрэглэгч зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалуулдаг, хохирлоо хэрхэн төлүүлдэг тухайд авч үзвэл:

Энэ тухайд жишээ дурдахад, АНУ-ын иргэн Жесси Виллиамс гэгч эр “Филип Морисс” компанийн брэнд бүтээгдэхүүн болох Марлборо тамхийг худалдаанд гарснаас хойш 47 жилийн хугацаанд тасралтгүй хэрэглэсэн бөгөөд тэрээр уг

аж. Гэвч Жесси Виллиамсын эрүүл мэндийн байдал муудаж, эмнэлэгт үзүүлтэл тэрээр уушгины хүнд хэлбэрийн хорт хавдар туссан, энэ нь тамхи их хэмжээгээр татдаг байсантай холбоотой хэмээн шинжилгээний дүгнэлт гарчээ. Тэрээр 6 сарын дараа нас барсан байна.

Жесси Виллиамсын эхнэр “Филип Морисс” компанийг хэрэглэгчийг хуурч мэхэлсэн, худал мэдээлэл өгсний умаас хүний амь насанд гэм хор учруулсан үндэслэлээр зарга үүсгэсэн бөгөөд шүүхээс хохирлын нөхөн төлбөр болгон 821,485.50 ам доллар, хэрэглэгчийн эрхийг зөрчсөний төлөө иргэний эрх зүйн залхаан цээрлүүлэх хариуцлага болгон 79 сая ам долларыг нэхэмжлэгчид олгон (punitive damage) шийдвэрлэж, 79 сая ам долларын 60 хувийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн санд шилжүүлэхээр шийдвэрлэжээ.⁵

Хэрэв манай улсад энэ төрлийн хэрэг, маргаан гарч бизнесийн байгууллага гэм буруутай болох нь тогтоогдвол уг байгууллагад Зар сурталчилгааны тухай хууль зөрчсөн үндэслэлээр 50,000-250,000 төгрөгийн торгууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 “Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс

⁴ Төрийн мэдээлэл эмхтгэл №1

⁵ <https://www.law.cornell.edu/supct/cert/07-1216>



хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгөхийг хориглоно”, 12.9 “Бараа, ажил үйлчилгээг зууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн үндэслэлээр 100,000-250,000 төгрөгийн торгууль ногдуулж, Иргэний хуулийн зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалтаар хариуцагч этгээдээс зарим зардлыг гаргуулан нэхэмжлэгчид олгох үндэслэл байж болох ч нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэх нь хууль хэрэглээний практикийн хувьд эргэлзээтэй. Хэрэглэгчийн эрхийн хамгийн чухал хөндөгдөж буй асуудал нь үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх юм. Худалдан авагч буюу хэрэглэгч нь учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх ямар эрхтэй болохыг тайлбарлая.

-Худалдан авагч нь эд хөрөнгийн доголдлыг өөрийнхөө зардлаар арилгаж өгөхийг худалдагчаас шаардах эрхтэй

-Худалдан авагч нь доголдолтой эд хөрөнгийг доголдолгүй эд хөрөнгөөр сольж өгөхийг худалдагчаас шаардах эрхтэй

-Худалдан авагч гэрээнээс татгалзах эрхтэй. Татгалзсан тохиолдолд худалдан авагч эд хөрөнгийг буцаан өгч, худалдагч үнийг буцаан өгөх үүрэгтэй байна.

Юуны өмнө хэрэглэгч дээрх эрхээ хэрэгжүүлэхийн тулд хуульд заасан ямар хугацаанд гомдлын шаардлага гаргах эрхтэй болохыг тодруулбал: Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.Бараанд биет байдлын доголдол /тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй гэж заасан байна. Эндээс харахад “...хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй” гэсэн заалт нь ойлгомжгүй, практикт хуульчид харилцан адилгүй ойлгож хэрэглэх явдал ажиглагддаг. Иргэний хуулийн тайлбарт нэн даруй гэх хугацааг “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд гэж ойлгоно⁶

гэжээ. Энэ нь мөн хуульчид, шүүгчид өөрсдийн үзэмжээр шийдэх асуудал болоод байна. Өмгөөлөгч, шүүгчид энэ хугацааны тухай тодорхой ойлголтод хүрэх хэрэгтэй байна. Тухайлбал, иргэн Ж нь гэрийнхээ ойролцоо байдаг нэгэн цахилгаан барааны дэлгүүрээс богино долгионы зуух худалдан авчээ. Гэтэл уг зуух нь 3 сар хэрэглэсний дараа ажиллахгүй болсон байна. Энэ үед хэрэглэгч тухайн зуухыг доголдолтой бараа гэж үзэн дэлгүүрт буцаан өгч болох юм. Гэхдээ иргэний хуулийн 254.6.Худалдагч эд хөрөнгийн баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш зургаан сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй. 254.7.Эд хөрөнгийн баталгаат хугацааг худалдан авагчид эрсдэл шилжсэн үеэс эхлэн тоолох бөгөөд хэрэв баталгаат хугацааны дотор гол доголдлыг илрүүлсэн бол худалдан авагчид эрсдэл шилжих үед уг доголдол байсан гэж үзнэ гэснийг хагалзан үзэх ёстой. Энэ тохиолдолд худалдагч шаардлагыг иргэний хуульд зааснаар хангах үүрэг хүлээдэг бол хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд, гэрээнд заасан хугацаагаар эсвэл нэн даруй гэж заасан хугацааны дагуу шаардлагыг хангах үүрэг хүлээнэ. Дээрх хуулийн шаардах эрхийн “нэн даруй” гэсэн хугацааг тодорхойлж, хэрэглэхэд хүндрэлтэй байна.

Мөн хуулийн 6-р зүйлийн 6.3.Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар шаардлагыг гаргах эрхтэй гэж хуульчилсан байна. Энэ нь мөн л ойлгож, тайлбарлахад хүндрэлтэй байдаг. Жишээ нь, иргэн А нь нийслэлд байдаг нэгэн автомашин худалддаг газраас “Тоёото” маркийн автомашин худалдан авчээ. Хуулийн дагуу шилжүүлж авснаас хойш 3 сарын дараа дөрвөн хаалганы цахилгаан түгжээ нь сайн ажилладаггүй болохыг олж мэдсэн байна. Нэг хаалга нь байнга түгжигддэггүй үлддэг байж. Тэгсэн хэдий ч 3 сарын турш унасан байна. А нь 3 сарын дараа автомашин худалдааны газар очиж, тухайн машинаа доголдолгүй авто машинаар сольж өгөхийг шаарджээ. Энд

⁶ <http://www.supremecourt.mn/>



дээр дурдсан шаардлага гаргах хугацаа ярихаас гадна тухайн автомашиныг 3 сар унаж 4.000 км явсан А-аас мөнгөн төлбөр гаргуулах уу гэдэг асуудал үүснэ. Энэ тохиолдолд автомашин худалдааны газар А-д доголдолтой автомашиныг сольж өгч байгаа тохиолдолд хэрэглэгдсэн хугацааны элэгдэлд нөхөн төлбөр төлөхийг шаардах эрхтэй гэсэн утгатай хуулийн заалт байхгүй байна. Энд худалдан авагч нь доголдолтой эд хөрөнгийг, доголдолгүй эд хөрөнгөөр сольж өгөхийг худалдагчаас шаардах тохиолдолд өмнө нь шилжүүлсэн доголдолтой эд хөрөнгийг буцаан өгөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй байдаг. / Иргэний хууль 253.3/ Мөн хэрэглэгч тухайн барааны доголдлоо гуравдагч этгээдээр арилгуулсан бол хэрэглэгчид учирсан хохирлыг худалдагч хариуцах эсэх нь мөн л хуульд тусгагдаагүй, зохицуулалтгүй байна. Энэ нь хэрэглэгч болон худалдагч хоёрын хооронд үл ойлголцох асуудал үүсч болохоор, ойлгомжгүй заалт юм. Эндээс харахад үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухайд хэдийгээр иргэний хуулийг төсөөтэй хэрэглэж байгаа ч иргэний хуулийн зүйл заалт хангалттай зохицуулалт болж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Дээрх хуулийн зүйл заалтаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд гэм хороо хэрхэн нэхэмжлэх, учирсан хохирлыг хэрхэн хариуцах, сэтгэл санааны гэм хороо хэрхэн арилгах тухай зохицуулалт байхгүй. Тухайлбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Бараа, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг иргэний хуулийн 18, 52 дугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан нь мөн л зохицуулалт хангалтгүй гэж үзэж байгаа юм.

Энэхүү судалгааны ажилд зөвхөн ХЭХТХ-ийн 6-р зүйлд тулгамдаж буй асуудлын тухай сонгон судалсан бөгөөд тус хуульд үүнээс гадна тодорхойгүй, ерөнхий зохицуулалт байгааг үргэлжлүүлэн судлах болно. Мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх /169 дүгээр зүйл/, Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн

худалдах /171 дүгээр зүйл/, Эрүүл мэндийн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалах /172 дугаар зүйл/ гэсэн тусгай гэмт хэргүүдийг нэрлэсэн байдаг ба энэ тухай үргэлжүүлэн судлах болно.

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомж нийгмийн харилцааг бүрэн гүйцэд зохицуулж чадахгүй улмаар хуулийн хийдлийг бий болгож байвал бусад улс орны дэвшилтэд эрх зүйн зохицуулалтыг эх орны хууль эрх зүйн хөрсөнд монгол хүний ухамсар хийгээд нийгмийн амьдралд зохицуулан буулгах шаардлага тулгардаг. Иймд бусад улс орнуудын дэвшилтэд зохицуулалтыг авч үзье.

2. Гадаад улс орнуудын туршлага

Гадаадын зарим улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд шинжилгээ хийж, Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох туршлага судаллаа.

Тухайлбал: БНХАУ-д 1993 онд “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль” анх батлагджээ⁷. Энэхүү хууль нь цахим худалдаан дахь олон талын зохицуулалтыг хийдэг байна. Үүнд:

- хуулийн дагуу гэм хор арилгах,
- хэрэглэгчийн харилцаа холбоог албан ёсоор хүлээн зөвшөөрөх,
- хувь хүний мэдээллийг хамгаалах,
- үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ташаа мэдээллийн улмаас хэрэглэгчид учирсан гэм хорыг хариуцах гэх зэрэг олон асуудлыг зохицуулжээ.

Эдгээрээс гадна цахим худалдааны журам хэрэгждэг байна. Худалдагч нар бараа бүтээгдэхүүнийхээ тухай худалдан авагчдын сэтгэлд хүртэл тайлбарлах, үнэн, зөв мэдээллээр хангах, мөн худалдан авалт хийснээс хойш 7 хоногийн дотор хэрэглэгчид учирсан гэм хорыг тухайн байгууллага хариуцаж, нөхөн төлөх ёстой байдаг байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагуудаас дурдвал:

• АНУ-д холбооны худалдааны комисс “Federal Trade Commission”

• Англи улсад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг “Consumer Protection Association”

• БНСУ-д Солонгос улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах агентлаг “Korea Consumer Agency” зэрэг манай улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг

⁷ www.wikipedia.org



байгууллагууд байдаг.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйл. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийг Малайз, Канад улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл заалттай нь харьцуулан үзэхэд. Малайз улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль⁸ /Consumer protection act 1999/ нь Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухай нарийн зохицуулалт хийж өгсөн ба "...нийлүүлэгчээс урьдчилан товлосон хугацаанд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй" гэж хуульчилсан байдаг. Мөн хэрэглэгч "...гэм хорыг арилгуулахад гарсан бүх зардлыг нийлүүлэгчээс гаргахыг шаардах эрхтэй" байхаар хуульчилсан нь манай улсын хуульд маргаантай байдаг асуудлыг зохицуулахаар хуульчилсан нь сайн талтай юм. Канад улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон төрлийн хууль байдгаас 2010 онд батлагдсан⁹ барааны аюулгүй байдлыг хамгаалах хууль нь /Canada Consumer Product Safety act/ түгээмэл хэрэглэгддэг байна. Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тал дээр манай улсын хуультай харьцуулахад нарийвчилсан зохицуулалтыг зааж өгсөн давуу талтай. Одоогоор Монгол Улс нь худалдааны тухай хуульгүй ба барааны аюулгүй байдлыг хангах асуудлыг хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулиар зохицуулж байна.

Дүгнэлт

Хууль амьдралаас тасрах ёсгүй бөгөөд тухайн хуулиар хамгаалагдах ёстой субъектын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих ёсгүй юм. Ингэж зөрчих нөхцөлийг бүрдүүлж улмаар эрх зүйн хийдлийг бий болгосноор хууль үнэ цэнээ алдаж, цагаан цаасан дээр хараар бичигдсэн бичээс болон хувирах, эрсдэлийг дагуулж байдаг.

Дэлхий дээрх 7 тэрбум гаруй хүнийг нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэг, боловсролын байдлаас үл хамааран нэгэн нэрийн дор ХЭРЭГЛЭГЧ хэмээх нэрийг хууль зүйн талаасаа хэрэглэдэг. Чинээлэг хэрэглэгч, ядуу хэрэглэгч, гадаадын хэрэглэгч, дотоодын хэрэглэгч гэж хэнийг ч үл ялгаварлан, тухайн улсын хэрэглэгчийн

эрхийг хамгаалах хууль нь үйлчлэх учиртай. Тиймдээ ч судалгааны ажилдаа Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтад тулгамдаад байгаа үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухай асуудлыг гадаадын зарим орны хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжтой харьцуулан судалсан. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйл "Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх"-ийн эрх зүйн зохицуулалт нь төдийлөн хангалттай зохицуулалт болж чаддаггүйг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хэсэгт дурдсан болно.

Дүгнэн хэлэхэд, манай улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль нь ерөнхий зохицуулалт ихтэй, шинэчлэн найруулах шаардлагатай юм. Тухайлбал "...хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй" гэсэн хугацааны хувьд тодорхой бус байгааг хуульч, шүүгчид тодорхой болгох шаардлагатай. Мөн иргэний хуулийн 254.1 нь доголдлыг арилгахтай холбогдон гарсан зардлыг худалдагчаас шаардах худалдан авагчийн эрхийн хувьд тодорхой бус байна. Магадгүй, хэрэглэгч хэдийд ч доголдлыг арилгахыг шаардаж болох ба энэ хугацаанд гарсан зардлыг хэн нь хэрхэн, яаж төлөх нь тодорхойгүй, харилцан тохиролцож /Канад улсын хуульд ийм заалт бий/ болох заалт байхгүй байгаа нь хэрэглэгч болон үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн хооронд маргаан үүсэх, үл ойлголцох асуудал үүсч болохоор байна. Д э э р х хуулийн зүйл заалтаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд гэм хороо хэрхэн нэхэмжлэх, учирсан хохирлыг хэрхэн хариуцах, сэтгэл санааны гэм хорыг арилгах тухай зохицуулалт байхгүй. Тухайлбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Бараа, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг иргэний хуулийн 18, 52 дугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй" гэж заажээ. Харин Монгол Улсын

⁸ <http://www.aseanconsumer.org/>

⁹ <http://www.canadianlawsite.ca/consumer-protection.htm>



Эрүүгийн хуулийн Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх /169 дүгээр зүйл/, Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах /171 дүгээр зүйл/, Эрүүл мэндийн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалах /172 дугаар зүйл/ гэсэн тусгай гэмт хэргүүдийг нэрлэсэн байдаг ба энэ тухай үргэлжүүлэн судлах болно.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг хүргэж байна.

-Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хохирол нөхөн төлүүлэх, доголдол арилгуулах хугацааны тухай зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулж ойлгомжтой, тодорхой болгох нь хуульч, судлаачид нэг мөр ойлгож хэрэглэхэд тустайгаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэсэн утгыг бүрэн илэрхийлж өгнө.

-Иргэний хуулийн доголдлыг арилгахтай холбогдон гарсан зардлыг худалдагчаас шаардах худалдан авагчийн эрхийн хувьд тодорхой бус байгааг тодорхой болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуультай уялдуулан хуульчлан тогтоох,

-Бизнес эрхлэгчид хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд хэрэглэгч хэдий хугацаанд хохирлоо барагдуулахаар гомдол гаргах эрхтэй болох тухай хууль эрх зүйн орчинг судлах,

-Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг судлан, судалгааг хуульд тусгах,

-Гадаадын зарим улс орны буюу Малайз, Канад, АНУ зэрэг өндөр хөгжилтэй улсуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан тодорхой хугацаа, тодорхой заалтуудыг Монгол Улсад хэрэгжүүлэн, нутагшуулах зэрэг болно.

Ашигласан материал:

- 1)Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл №1. УБ., 1992
- 2)Иргэний хууль. Төрийн мэдээлэл №7. УБ., 2002
- 3)Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (ерөнхий анги). УБ., 2005
- 4)Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. Иргэний хэрэг. УБ., 2006-2009
- 5)О.Жамбалдорж - Иргэний эрх зүй I дэвтэр. УБ., 2004
- 6)Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан. Бизнесийн эрх зүй. УБ., 2014
- 7)<http://www.supremecourt.mn/>
- 8)<https://www.law.cornell.edu/supct/cert/07-1216>
- 9)<http://www.aseanconsumer.org/>
- 10)<http://www.canadianlawsite.ca/consumer-protection.htm>
- 11)www.wikipedia.org
- 12)<http://en.wikipedia.org/wiki/Consumerism>

Хавсралт 1

Монгол Улс	Малайз Улс
6 дугаар зүйл. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх	5 дугаар бүлэг. “Нийлүүлэгчдийн эсрэг гомдол гаргах хэрэглэгчийн эрх”
6.2. Бараанд биет байдлын доголдол /тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй.	41. Хэрэглэгч баталгааг хангаагүй бараа бүтээгдэхүүнд нийлүүлэгчийн эсрэг гомдол гаргах эрхтэй. Баталгааг хангаагүйгээс үүссэн гэм хорыг хэрэглэгч: 1. гэм хорыг арилгах боломжтой бол энэ хуулийн 42 заасны дагуу нийлүүлэгчээс урьдчилан товлосон хугацаанд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. Нөхөн төлбөр нь хэрэглэгчийн төлбөл зохих эсвэл төлсөн дүнгээс доогуур байна.



<p>6.3.Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар шаардлага гаргах эрхтэй.</p>	<p>2. Гэм хорыг арилгах боломжгүй эсвэл их хэмжээний гэм хор байвал тус хуулийн 44 дугаар зүйлд заасны дагуу: i/ 43 зүйлд зааснаас бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүнээс татгалзах эрхтэй. ii/ учирсан гэм хороос үүдэн бүтээгдэхүүний үнэ цэнэ буурсан бол буурсан үнэ цэнэтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр нийлүүлэгчээс гаргуулах эсхүл үнийг бууруулах эрхтэй.</p> <p>3. Хэрэв нийлүүлэгч гэм хорыг арилгахаас татгалзсан эсхүл үл хайхарсан эсхүл тодорхой хугацаанд гэм хорыг арилгаагүй болон үл хайхарсан бол хэрэглэгч: а/ Өөр байдлаар гэм хорыг арилгахыг шаардах, гэм хорыг арилгуулахад гарсан бүх зардлыг гаргахыг нийлүүлэгчээс шаардах эрхтэй. б/ 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүнээс татгалзах эрхтэй</p>
---	--

Хавсралт 2

Монгол Улс	Канад Улс
<p>6.2 Бараанд битет байдлын доголдол / тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй.</p>	<p>92.6 Тохиролцсон баталгаат хугацаанд хэрэглэгчийн худалдан авсан бараа чанарын шаардлага хангахаа больсон бол нийлүүлсэн /гүйцэтгэгч/ хувь хүн болон албан байгууллага засаж, нөхөн төлөх үүрэгтэй бөгөөд гарсан хохирлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр нөхөн төлнө.</p> <p>92.8 Хэрэглэгч нийлүүлэгч /гүйцэтгэгч/ харилцан тохиролцож чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлж болно.</p>
<p>6.3.Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар дараах шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй: ...</p> <p>6.3.1. Барааны доголдлыг үнэ төлбөргүй арилгуулах буюу уг доголдлыг хэрэглэгч өөрөөсөө болон гуравдагч этгээдээр арилгуулахад гаргасан зардлыг нөхөн төлүүлэх;</p> <p>6.3.5. Гэрээг цуцлах</p>	<p>114.2 Хохирол учирсан аливаа хэрэглэгч нөхөн төлбөр шаардах эрхтэй</p> <p>114.3 Хүний үйл ажиллагаатай холбоотой ба үүргүүдийн холбоотой ямар ч зардал гарсан ямар нэгэн хууль эрх зүйн зардлыг судалж, гарсан аливаа зардлыг төлөх үүрэгтэй.</p> <p>23.2. Гэрээ хүчингүй болгох мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 10 хоногийн дараа гэрээг хүчингүй болгох эрхтэй. /Тодорхой учир шалтгааны улмаас нэг талын буруутай үйл ажиллагаанаас болж/</p>



ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭН ЭРХЭД ХАМААРАХ НЬ

Ц.Мөнхтуяа

Үндэсний тагнуулын академийн сонсогч

Оршил

Аливаа төрт улс энэрэнгүй ёсны үзэл санааны хүрээнд ард иргэдийг гэмт хэрэгт холбогдсонтой холбогдуулан

*Цагаатгах

*Уучлал үзүүлэх

*Өршөөх гэсэн үйл ажиллагаануудыг эрхлэн хэрэгжүүлдэг.

Цагаатгах нь шүүх эрх мэдлийн байгууллагаас гэмт хэрэгт холбогдогчийн гэм буруугүйг нотлосон шүүхийн шийдвэрээр баталгааждаг үйл ажиллагаа байдаг бол уучлал нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Ерөнхийлөгчөөс ганцаарчилсан хэлбэрээр эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх өвөрмөц зохицуулалт байдаг.

Харин өршөөлийг хууль тогтоох байгууллагаас хууль гаргах замаар хэсэг бүлэг этгээдэд хандан гаргадаг байна.

Өршөөл үзүүлэх харилцаа нь улс орон бүхэнд харилцан адилгүй журмаар хэрэгждэг ч гол төлөв төрийн энэрэнгүй бодлого, хүнлэг ёсны зарчимтай холбон ойлгож, хэрэглэгддэг байна.

Манай оронд төр, хууль цаазны түүхэн уламжлалт цаг үеүдэд өршөөл үзүүлэх явдал байсаар ирсэн бөгөөд түүнийг эзэн хааны зарлиг, хууль цааз, түүнчлэн шинэ үе рүүгээ дөхөөд ирэхээр АИХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр улс орны түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдээр үзүүлсээр ирсэн түүх бий.¹

Цөөнгүй оронд, тухайлбал Орос, Казакстан гэх орнуудад манай улс шиг үндэсний болон төр, улсын ойн их баяр ёслолын үеэр өршөөл үзүүлдэг байна.² Тэгвэл энэхүү тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ард иргэдээ хийсэн гэмт үйлдлээс нь өршөөн хэлтрүүлдэг уламжлал сүүлийн жилүүдэд манай оронд цаг хугацааны хувьд хэтэрхий ойр давтагдаж байгаа бөгөөд энэ нь хууль ёсны төдийгүй, энэрэнгүй ёсны зарчим хэрэгжиж байна хэмээх нэрийн дор тодорхой судалгаа шинжилгээгүй, өмнөх хуулиуд дээрээ багахан өөрчлөлтийг хийж,

¹ Г.Оюунболд. Өршөөлийн үр нөлөө. 2009,

² Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2014 он,

дүр үзүүлэх төдий байдлаар, мөн хууль тогтоогч нар өөрсдийн эрх мэдлийг харуулах боломж мэтээр ойлгон өршөөлийг үзүүлж байна гэсэн шүүмжлэлийг дагуулах болсон.

Нөгөөтэйгүүр гэмт хэрэгт холбогдсон хэмээн хянан шалгагдаж байгаа гэм буруутай эсэх нь тогтоогдоогүй иргэдийг өршөөх, мөн хийсэн гэмт үйлдлээ ухамсарлаж амжаагүй этгээдүүдийг мөн хянан шалгагдаж байгаа гэм буруутай эсэх нь тогтоогдоогүй иргэдийг өршөөх нь нийгмийг айдаст автуулан цаашлаад нийгмийн аюулгүй байдалд ч нөлөөлнө хэмээх хардалтыг бий болгож байна.

Тиймээс Монгол улс өршөөл үзүүлэх асуудалд нухацтай, хариуцлагатай хандах шаардлагатай байгаа бөгөөд өршөөл үзүүлэх, эс үзүүлэх асуудал нь зарим талаар эрдэмтэд судлаачдын дунд маргаан өрнүүлэхэд хүргэдэг бөгөөд өршөөлийг хэдийд ямар үед, ямар үндэслэлээр үзүүлэх болон өршөөлийн эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг бодитойгоор тооцох, уг институтын зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тавигддаг.

Иймээс дээрх шалтгаануудыг үндэс болгон миний бие энэхүү илтгэлээрээ өршөөл үзүүлэх Улсын Их Хурлын бүрэн эрх, түүний эрх зүйн зохицуулалт, түүнээс үүсч буй хууль зүйн болон бусад үр дагаврын талаар судлан үзэж, улмаар түүнийг боловсронгуй болгох асуудалд өөрийн саналаа нэмэрлэх зорилгыг тээн энэхүү илтгэлийг бичиж байна.

1. Өршөөл үзүүлэх асуудал Улсын Их хурлын бүрэн эрхэд хамаарах нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 14-т зааснаар Өршөөл үзүүлэх асуудал нь Улсын Их хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд Өршөөл үзүүлэхдээ УИХ заавал **Өршөөл үзүүлэх тухай хууль** гаргадаг хэдий ч алийг нь яаж шийдэхээ их хурал өөрөө мэддэг.

Өршөөл гэдэг нь онолын дагуу шорон хэт дүүрэх, тодорхой үзэгдлийн улмаас олон хүн зэрэг шоронд орсон тохиолдолд ялын бодлогоо зөөллөх зорилгоор авдаг арга хэмжээ ³ хэмээн судлаач Г.Оюунболд тодорхойлжээ.

“Өршөөх гэдэг нь хэрэв сайн хуультай, хөнгөн ялтай байгаад шүүх нь шуурхай шударгаар шийдвэрлэгддэг үед хэрэггүй атлаа эсрэг тохиолдолд засаглагчид нэмэлт үүрэг болгон ашигладаг буяны үйл

³ <http://www.ikon.mn/> Хууль Зүйн Яамны ахлах мэргэжилтэн Г.Оюунболдын сэтгүүлд өгсөн ярилцлаганаас



болж хувирдаг байна.”⁴ хэмээн Ч.Бекариа өршөөлийн хуулийн үр нөлөөний талаар үндэслэлтэй дүгнэлт өгч байжээ.

Энэ нь шүүх тогтолцоо нь эрүүдэн шүүдэг, хүмүүсийг хэлмэгдүүлдэг биш л бол гэмт хэрэг хийсэн хүн түүнийхээ үр шимийг заавал хүртэх бөгөөд засаглагчдаас сайн нэр зүүн өөрийн эрх мэдлийн хүрээнд шүүх эрх мэдлийн бүрэн эрхэд халдан өршөөлийг цаг хугацааны хувьд ойр давтамжтай үзүүлэх шаардлагагүй юм гэдгийг илэрхийлж байна.

Үүнээс үзвэл өршөөл нь эрүүгийн бодлогын тэнцвэрийг хангах хэрэгсэл боловч нөгөө талаар Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаардаг утгаараа эрх баригчдын хүсэл зоригийг илэрхийлсэн шинжтэй шийдвэр байх магадлалтай.

Эрүүгийн хариуцлага буюу ялаас чөлөөлөх асуудал нь Монгол улсын Эрүүгийн эрх зүйн нэг бие даасан институт бөгөөд энэ талаар эрүүгийн эрх зүйн чиглэлээрх эрдэмтэн судлаачид өөр өөрийн тодорхойлолтыг өгсөн байх бөгөөд Монгол Улсын эрүүгийн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-д “Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлж болно.” хэмээн заасан байна.⁵

Судлаач, эрдэмтдийн өгсөн тодорхойлолт болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хэм хэмжээг харьцуулан үзвэл өршөөл нь:

-гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлөх⁶

-гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг ... бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж буй хэлбэр⁷

-гэмт хэрэг үйлдсэн этгээд болон ял эдэлж байгаа ялтнуудын үйлдсэн гэмт хэргийн эрх зүйн үр дагаврыг хүчингүй болгож эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлдөг ... онцгой үйл ажиллагаа⁸

-гэмт хэрэг үйлдсэн тодорхой бус этгээдүүдийг эрүүгийн хариуцлага буюу ялаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх эсхүл ялын хугацааг багасгах, өөр хөнгөн ялаар солих эсхүл ял шийтгээгүйд тооцох журам⁹ гэж тодорхойлсон байна.

Эндээс харахад :

⁴ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ.,2009. орч Р. Батхв.

⁵ Монгол улсын эрүүгийн хууль, 2002, 77 дугаар зүйл.

⁶ Мөн тэнд.

⁷ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ.,2014, 183 дах тал.

⁸ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол.УБ., 2009 он

⁹ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь, УБ., 2007, 366 дахь тал.

Нэгдүгээрт: Өршөөлд хамрагдах этгээдийг -гэмт хэрэг үйлдсэн этгээд /гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй/

-гэмт хэрэг үйлдээд эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд

-гэмт хэрэг үйлдээд ял эдэлж байгаа этгээд /ялтан/

-тэр ч бүү хэл ялаа эдлээд суллагдсан боловч ялтайд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа этгээдбайхаар өөр өөрөөр тодорхойлсон;

Хоёрдугаарт: Өршөөл үзүүлэх хэлбэрийн хувьд

-эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх

-зөвхөн ялаас чөлөөлж буй хэлбэр

-үйлдсэн гэмт хэргийн эрх зүйн үр дагаврыг хүчингүй болгож эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлдөг ... онцгой үйл ажиллагаа

-эрүүгийн хариуцлага буюу ялаас чөлөөлөх эсхүл ялын хугацааг багасгах, өөр хөнгөн ялаар солих эсхүл ял шийтгээгүйд тооцох журам гэж мөн л өөр өөр агуулгаар тодорхойлсон байгаа нь өршөөлийн хууль гарах үед ард иргэдийн дунд эргэлзээ төрөх үндэс болж байна.

Эндээс тухайлан үзвэл “гэмт хэрэг үйлдсэн этгээд” гэдэгт “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэсэн Үндсэн хуулийн заалтын дагуу шүүхээр гэм буруу нь тогтоогдсон этгээд гэж ойлгохоор атал 2015 онд баталсан **“Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай”** хуульд “Гэмт хэрэг үйлдсэн хүн гэдэгт 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн, захиргааны зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн хүн хамаарна.” хэмээх тодорхойлсон хэм хэмжээгээр Үндсэн хуулийн заалтыг илтэд зөрчсөн тайлбар хийжээ.

2. Ардчилал бэхжиж эхэлсэнээс хойш үзүүлсэн Өршөөл үзүүлэх тухай хуулиудыг харьцуулан үзэх нь

Өршөөлийн хууль нь Монгол Улсын эрүүгийн бодлогоос шууд хамааралтай, ялын үр нөлөөг зохистой барих, тодорхой алдааг засахад шууд чиглэгдсэн, тухайн үеийнхээ нөхцөлд тохирсон нийтлэг эрх ашгаас тодорхой хувийн эрх ашигт чиглэсэн, ял



эдлүүлэх ажиллагаатай харилцан нөхцөлдсөн байх шаардлагатай.

2.1 Өршөөл үзүүлэх хэмжээ хязгаар

Ардчилал бэхжиж эхэлсэнээс хойш гарсан өршөөлийн хуулиудыг харьцуулан үзвэл:

Өршөөл үзүүлсэн огноо	Хамрах хүрээ	Өршөөлийн хэлбэр
1991 ¹	Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийг үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх	Ялын хугацааг харгалзахгүйгээр үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх Эдлээгүй үлдсэн хорих ялаас өршөөн хасах Ял нь тэнсэгдсэн болон сахилгажуулах ангид ял эдэлж байгаа ялтны ялаас чөлөөлөх Хэрэгсэхгүй болгох
2000 ²	Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийг үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн этгээд 3-25 жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээд, Ял тэнсэгдсэн, хорих газраас тэнсэн суллагдсан, хорих ял шийтгүүлсэн таслан шийдвэрлэх тогтоолыг хойшлуулсан насанд хүрээгүй этгээд	Ялын хугацааг харгалзахгүйгээр үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх Ял өршөөн хасна Хэрэгсэхгүй болгоно
2006 ³	Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийг үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх Болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн, Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн, Хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн, Хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд, Онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн, Хорих газраас тэнсэн суллагдсан этгээд, Хорих ялыг нь тэнссэн этгээд, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд байгаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд,	Ялаас өршөөн хэлтрүүлэх Ялаас өршөөн хасах Зарим хугацааг хэрэгсэхгүй болгох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох



2009 ⁴	Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийг үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэх үндэслэл: Болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээд, Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн, Хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн, Хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд, Онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн, Хорих газраас тэнсэн суллагдсан этгээд, Хорих ялыг нь тэнссэн этгээд, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд байгаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд, Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх ажиллагааг хойшлуулсан насанд хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг,	Ялаас өршөөн хэлтрүүлэх, Ялаас өршөөн хасах Зарим хугацааг хэрэгсэхгүй болгох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох
2015 ⁵	Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн этгээд, Захиргааны зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн этгээд, Хорих ял нь тэнссэн хүн, Тэнсэн суллагдсан этгээд, Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, насанд хүрээгүй хүн, Хуульд заасан тухайн төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээд тус тус хамаарна.	Ялаас өршөөн хэлтрүүлэх, Ялаас өршөөн хасах Зарим хугацааг хэрэгсэхгүй болгох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох Зарим захиргааны зөрчил, шийтгэлийг хэрэгсэхгүй болгох

Дээрх хүснэгтээс үзвэл өмнө жилүүдэд гарсан өршөөлийн хуулиудад өршөөл үзүүлэх хэлбэр буюу өршөөл үзүүлэх арга зам нь тогтсон хэлбэрээр буюу

- Ялаас өршөөн хэлтрүүлэх,
- Ялаас өршөөн хасах
- Зарим хугацааг хэрэгсэхгүй болгох

-Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох гэсэн хэлбэрээр үзүүлдэг байсан бол

Харин энэ удаагийн өршөөлийн хуулиар хууль тогтоомж зөрчиж, захиргааны зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн этгээдийг хамруулахаар хуульчилсан нь Эрүүгийн хуулийн 77.1-д заасантай зөрчилдөж байна.

Өршөөлд хамрагдах этгээдийн хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд өмнө нь хэрэгжиж байсан өршөөлийн хуулиудыг энэ удаагийн өршөөлийн хуультай харьцуулан үзвэл 1991 оноос 2009 оны хооронд гарсан Өршөөл үзүүлэх тухай хуулиудаар “Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн

ялтны шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэхээр заасан” бол

2015 оны Анхны Ардчилсан Сонгууль Болж Байнгын Ажиллагаатай Парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан **гаргасан ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ хуульд** «энэ хуульд ялаас өршөөн хасах болон өршөөлд хамааруулахгүйгээр зааснаас бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтныг шүүхээс оногдуулсан болон биечлэн эдэлсэн ялын хугацааг үл харгалзан эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ». хэмээжээ.

Үүнээс үзэхэд уг өршөөлийн хуулиар өмнө хэрэгжиж байсан Өршөөлийн хуулиуд шиг «анх удаа гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн» гэх болзол тавигдаагүй бөгөөд, өршөөлд хамрагдах этгээдийг насны



хязгаарлалт, биеийн байдал, амьдралын нөхцөл шаардлагаас үл хамааран гэмт хэргийн зүйлчлэлд нь өршөөл үзүүлсэн, мөн захиргааны шийтгэлээс чөлөөлөх асуудал шинээр тусгагдсанаас харахад Өршөөл үзүүлэх хуулийн хамрах хүрээ улам тэлж байгаа бөгөөд энэ нь ард иргэдэд өршөөл үзүүлэх асуудал нь эрх баригчдын өөрсдийн хүсэл зоригийн дагуу, нийтийн ашиг сонирхлыг хамарсан бус цөөнхийн эрх ашгийг хамгаалж байна хэмээх хардлагыг төрүүлж байгаа юм.

Иймээс эрх зүйт ёсыг төлөвшүүлэхийг зорьж буй өнөөгийн нөхцөлд өршөөл үзүүлэх ажиллагааны хамрах хүрээ, өршөөлийн хэлбэр, байж болох үндэслэлийг нийтлэг байдлаар шинээр батлагдан гарах гэж буй “Гэмт хэрэг”-ийн хуульд нэмж хуульчилж өгөх нь зүйтэй хэмээн үзэж байна. Ингэснээр эрх баригчид буюу хууль тогтоогчид өөрсдийн үзэмжээр өршөөлийн хууль гаргаж байна гэсэн сэрдэлтээс сэргийлэх боломж бүрдэнэ.

2.2. Өршөөл үзүүлсэн статистик мэдээлэл

Өмнө нь гарч байсан Өршөөлийн хуульд хамрагдаж суллагдсан иргэдийн 7-8 хувь нь дахин гэмт хэрэгт холбогдсон байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар энэ удаагийн өршөөлөөр суллагдсан этгээдүүдээс 28 хүн дахин гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэ нийт гэмт суллагдсан гэмт хэрэгтний 1,4% нь юм. Үлдсэн 90 гаруй хувь нь ажил хөдөлмөр эрхлээд сайхан амьдарч байгаа¹⁰ гэх боловч энэхүү бага гэж хэлж болох хэмжээ нь иргэдэд шууд нөлөөлж байгаа нь харамсалтай.

2015 оны Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан этгээдүүдийг зүйлээр нь ангилан үзвэл:

Зүйл	Суллагдсан хүмүүсийн тоо
4.1. Гэмт хэрэг үйлдэж, анх удаа хорих ялаар шийтгүүлсэн дор дурдсан ялтны шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ...	1200
4.2. Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн этгээдийг гүйцэтгэгдээгүй ялаас өршөөн хэлтрүүлнэ.	312 - Гүйцэтгэгдээгүй торгохоос: 119 - Албадан ажил хийлгэхээс: 63 - Баривчлах: 130
4.3. Хууль тогтоомж зөрчиж захиргааны зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн этгээдийг өршөөн хэлтрүүлнэ.	81500 жолооны эрхийн зөрчилтэй этгээдийг өршөөсөн.
5.1.2. онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн хорих ялаас хоёр жилийг.	1760 (2 жил хасагдаж 678 хүн суллагдсан байна.)
7.1. Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүмүүсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгоно.	338 хүнд холбогдох 284 Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

•Өршөөгдсөн хоригдлуудыг нас, хүйсээр:

Насанд хүрээгүй хүн – 11, Эмэгтэй – 87, Эрэгтэй 1165

•Гэмт хэрэг үйлдсэн тоогоор нь:

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн – 701 хүн, Хоёр дахь удаа гэмт хэрэг – 308 хүн, Гурав болон түнээс дээш удаа гэмт хэрэг – 243 хүн

•Гэмт хэргийг төрлөөр:

Хулгай – 693

Залилан – 99

Бусдын итгэмжлэн өгсөн хөрөнгийг завших – 38

¹⁰ Мөн тэнд



Албан тушаалын гэмт хэрэг /Хээл хахууль өгсөн/ - 1

Мансуурах гэмт хэрэг – 9

Хэдий төр энэрэнгүй ёсны үзэл санааны үүднээс ард иргэдээ хийсэн гэмт хэргээс нь өршөөж байгаа ч эдгээр суллагдан гарч байгаа хүмүүсийн сэтгэл зүй нийгэмд бэлтгэгдээгүй байдаг байна. Суллагдсан этгээдүү ихэвчлэн хүч хэрэглэсэн гэмт хэргүүд, бусдыг хэрцгийгээр алах, насанд хүрээгүй хүүхдүүдийг хүчирхийлэх гэмт хэргүүд үйлддэг. Манайд өршөөлийн хуулийн институтийг нь шийдсэн хэрнээ суллагдсан хүмүүсээ хүлээж авдаг тогтолцоо нь байдаггүй.

Өршөөлийн хууль гарсаны дараа нийт ард иргэдэд ч айдас төрдөг ба “гэмт хэрэгтэн хүмүүс суллагдаж нийгэмд аюултай байдал бий болгоно” гэсэн шууд нөлөөлөх сэтгэхүйн харьцаа бий болдог байна. Түүнчлэн ял эдлээд суллагдаж байгаа хүмүүсийн хувьд ч гэсэн нийгэм намайг хүлээж авахгүй, хэвийн ажиллаж амьдарч чадахгүй гэсэн айдас түгшүүр санаа зовох байдлууд гардаг байна.

Дүгнэлт, санал

Ардчилсан хувьсгалаас хойш гарсан өршөөл үзүүлэх хуулиудын хууль зүйн болон бусад үр дагаврын талаар судлан үзэхэд нэг нэгнээсээ хуулбарласан шинжтэй, зарим зүйл заалт утга агуулгууд нь зөрүүтэй, үүнээс улбаалаад хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарах, мөн хохирогчийн эрх ашиг, хөндөгдсөн эрх, эрх чөлөөг хөсөрдүүлдэг, ял завших, алагчилж үйлчилдэг, бусдад давуу байдал олгодог гэх мэт маргаантай асуудлууд гарсаар байна. Харин уг хуулийн эерэг тал нь нийтэд бага байдаг ч тодорхой этгээд, хувь хүмүүс, тэдний ар гэрт сайнаар тусч, ухаарч, цаашид алдахгүй байх тэр боломжийг олгож, шоронгийн хэт дүүргэлтийг хязгаарлах, ялтай шийтгэлтэй байдлын үр дагаврыг арилгадаг ач холбогдолтой талуудыг бас дурдахгүй өнгөрч үл болно.

Дүгнэн хэлэхэд дээр дурдсан үр нөлөөллүүд буюу эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх зарчмын үр нөлөөг бууруулах, нийгэмд хүлээлт бий болгодог атлаа шууд ард иргэд рүү чиглэсэн аюул учруулж дахин гэмт хэрэг үйлддэг зэрэг сөрөг үр дагаврыг бууруулахын тулд дараах арга хэмжээг авах нь зүйтэй хэмээн санал дэвшүүлж байна. Үүнд:

-Өршөөлийн хуульд хамрагдах болзлыг ерөнхий шинжээр эрүүгийн хуульдаа

хуульчлах эсхүл заавал шүүхээр тогтоон, эцэслэн шийдвэрлэсэн гэм буруутай эсэхийг тогтоосон этгээдэд л үзүүлэх,

-Өршөөл үзүүлэх журмыг бий болгох (Энэ нь хууль тогтоогчдыг өөрсдийн эрх ашгийн төлөө хууль гаргахаас сэргийлсэн, мөн өршөөл үзүүлэх цаг хугацааны талаар тодорхой журамласан байх),

- Байнгын ажиллагаатай өршөөл үзүүлэх орон тооны бус зөвлөл байгуулж ажиллавал гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг судлан нийгэмд нийгэмшээгүй, хийсэн гэмт хэргээ ухамсарлаагүй ялтныг суллахаас сэргийлнэ.

(Footnotes)

1 <http://legalinfo.mn/>

2 <http://legalinfo.mn/>

3 Мөн тэнд

4 <http://legalinfo.mn/>

5Мөн тэнд